

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ:

МОНГОЛЧУУД НЭГДЭЖ, ХАМТРАН
ЗҮТГЭВЭЛ ЮУГ Ч БҮТЭЭЖ ЧАДДАГИЙГ
“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”

ХАРУУЛЛАА







Монгол Улсын Ерөнхийлөгч
У.Хүрэлсүх
116 хүнсний үйлдвэрээр
өөрийн биеэр очиж,
хэрэгжилт, үр дүнтэй
танилцаж, үйлдвэрлэгчдийн
санал бодлыг сонсож, бизнес
эрхлэгчдийн хэлсэн ярьсан
асуудлуудыг УИХ-ын тогтоолд
тусгуулан ажиллаж байна.

Импорт буурч, валют эх
оронд үлдэх эхлэл тавигдлаа.

44 мянган ажлын
байрыг хадгалж үлдлээ.



Хөрс эрүүл бол хүнс эрүүл – Хүнс эрүүл бол хүн эрүүл



АГУУЛГА

Редакцийн зурвас 05

“Хүнсний хувьсгал”-ын тайлант дугаар

Мэндчилгээ 07

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх

Онцлох 10

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бэхэжсэн нь

Баялаг бүтээгчид 14

“Хүнсний хувьсгал”-ын үр дүнд 53 үйлдвэр ашиглалтад оров

Зөвлөх 16

Ч.Даваабаяр: Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хувьсгал”-ыг санаачилснаараа түүхэнд үлдэнэ

Санхүүгийн дэмжлэг 22

“Хүнсний хувьсгал”-ын дэмжлэгүүд

Хүнс 24

Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг 100

хувь дотоодоосоо хангана

Баялаг бүтээгчид 31

Чинээлэг дундаж давхаргатай МОНГОЛЫН ТӨЛӨӨ...

Гадаад харилцаа 32

Э.Одбаяр: 2026 онд гадаад бодлого Зүүн өмнөд Ази, булангийн орнууд руу чиглэнэ

Айлчлал 34

Төрийн айлчлал ба стратегийн түншлэл

Бодлого, стратеги 40

О.Нямсүрэн: “Хүнсний хувьсгал” бол Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлд тулгуурласан бодлогын бодит үр дүн

Олон улсын байгууллага 41

Чинюнь Дяо: Бид “Хүнсний хувьсгал”-ын зорилгыг бүрэн дэмжиж ажиллаж байгаа

Судлаач 43

М.Пүрэвжав: Монгол Улс 35 жил хүнсээ судалж,

шинжлээгүй орхигдуулж ирсэн

Сангийн яам 45

С.Тулга: Зээлийн хүүгийн татаасанд 213.3 тэрбум төгрөгийг зарцуулсан

Монголбанк 46

Н.Ариунбат: 768.1 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 493.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна

Зээлийн батлан даалтын сан 47

Б.Энхсайхан: Манай сан 18.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан

Олон улсын туршлага 48

Хүнсний хомсдолоос дэлхийн экспортлогч

Орон нутаг 56

Хязгаарлагдмал хүртээмжийг тэлэх стратеги

Дүгнэлт 61

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн үргэлжлэх хүлээлттэй байна

Сурвалжилга 62

“Хүнсний хувьсгал”-ынхан амжилтаа дүгнэлээ

“Харумафүжи сүүний ферм” 66

Д.Бямбадорж: Ард олондоо хайрлагдсан дотно амтыг түгээнэ

“Өгөөмж Архад” ХХК 67

Н.Энхжаргал: Жижиг, дундын салбарыг дэмжиж байгаад баяртай байна

“Очирдагинас” ХХК 68

Х.Тэмүүжин: Дэлхийн махны олимпоос есөн алт, нэг хүрэлтэй ирсэн

“Витафит Инвест” ХХК 69

Ч.Ванчин-Эрдэнэ: “Хүнсний хувьсгал” дотоодын үйлдвэрлэгчдэд том дэмжлэг боллоо

“Түмэн шувуут” 70

Ж.Болд: Дотоодын өндөгний хэрэгцээг 100 хувь хангана

“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫН ТАЙЛАНТ ДУГААР

Mongolian Economy сэтгүүл “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд гарч буй “Хүнсний хувьсгал” сэтгүүлийг энэ дугаараас эхлэн гаргаж эхэлж байна.

Хүнсний аюулгүй байдал, чанар, хүнсээ дотоодоосоо 100 хувь хангах гэдэг асуудал ямар ч улс орны хувьд хамгийн чухал номер нэгд тавих асуудал. Тиймээс бид Mongolian Economy сэтгүүлийнхээ дэргэд “Хүнсний хувьсгал” сэтгүүлийг гаргаж байгаадаа баяртай байна. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн хэлсэн “Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол монгол хүн эрүүл” гэсэн үг бол “Хүнсний хувьсгал”-ын гол томьёолол юм.

Бидний зүгээс энэ томьёоллыг “Хүнсний хувьсгал” сэтгүүл дээр ажиллаж эхэлснээс хойш илүүтэй мэдэрснээ хэлэхийг хүсэв. “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн ямар чухал асуудлыг хөндөн гаргаж ирж, төрийн бодлого болгож, хувийн хэвшил, үндэсний үйлдвэрлэгчдээ хөхиүлэн дэмжиж байгааг баримтууд, үр дүн харуулна. Олон жил яриад нэг л сайн явж өгөхгүй байгаа төр, хувийн хэвшлийн түншлэл “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн дээр харин ч бодитоор хэрэгжиж, жишиг болжээ гэдгийг онцолъё.

Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилга гаргаж, үндэсний хэмжээнд уриалж, өөрөө үндэсний үйлдвэрүүдээр очиж, үйлдвэрлэгчдэд урам зориг өгч явсан нь төрийн тэргүүний манлайлал маш чухал гэдгийг бид бас сайн харлаа. Харин Ерөнхийлөгчийн санаачлагыг бодит ажил хэрэг болгоход Ерөнхийлөгчийн Үйлдвэр үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр томоохон үүрэг гүйцэтгэж, гардан хариуцаж, Ерөнхийлөгч, үндэсний үйлдвэрүүдийн хооронд гүүр болж, тодорхой үр дүнг гаргаж ажиллалаа.

Ерөнхийлөгчийн Үйлдвэр үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаярын хувьд баялаг бүтээгчдийг арван жил удирдсан. Энэ хугацаанд Монгол Улсыг бүтэн хоёр удаа тойрсон, өрхийн үйлдвэрлэлээс эхлээд топ компанийн жаргал, зовлон бүх асуудлыг биеэрээ мэдэрсэн хүн. Энэ утгаараа тэрбээр “Хүнсний хувьсгал”-ыг эхнээс нь гардаж зохион байгуулсан учраас тодорхой бодит үр дүнг гаргасан гэж хэлж болно.



Нөгөөтэйгүүр Засгийн газар, ХХААХҮЯ “Хүнсний хувьсгал”-ын бодлогыг зангидаж, хэрэгжүүлснээр хүнсний салбарт өнгөрсөн гурван жилд томоохон өөрчлөлт гарсан билээ. Үндэсний үйлдвэрлэгчдийн дотоодод үйлдвэрлэж буй хүнсний нэр төрөл өнөөдөр 800-д хүрээд байна. Олон шинэ үйлдвэр ашиглалтад орж, олон шинэ ажлын байрыг бий болгож, эх орны хөрсөнд ургасан хүнсээр ард иргэдээ хангах бодлого маш эрчимтэй явж, үндэсний үйлдвэрүүд хөл дээрээ зогсох том алхам болж, хөгжил дэвшлийн үүд хаалгыг хүчтэй татсан байна.

Манай сэтгүүлчид энэхүү хөдөлгөөнд хамрагдсан үндэсний компаниудын төлөөлөлтэй уулзаж, шинэхэн үйлдвэрээр нь очиж, үйл ажиллагааг нь сурвалжиллаа. Энэ бүхний дүнд бид “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний үр дүнг тайлагнасан дугаарыг уншигч та бүхэнд хүргэж байна.

Энэхүү үр дүн цаашаа үргэлжлэх ёстой. Өнгөрсөн гурван жилд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн эхлэлийг тавьсан бол одоо урт хугацаанд үргэлжлүүлснээр Монгол Улс эрүүл хүнсээр иргэдээ дотоодоосоо бүрэн хангаж, улмаар хүнс экспортлогч улс болох зорилгодоо хүрэх юм. Олон улсын туршлагаас харахад ийм агуулга бүхий хөтөлбөрийг 30-50 жилийн туршид хэрэгжүүлж ирсэн бөгөөд улмаар экспортлогч улс болж, хөгжин дэвшсэн хэд хэдэн улсын туршлагыг энэхүү дугаартаа хуваалцлаа.

Бид мөн бүх талын оролцоог хангаж, тухайлбал, төрийн ямар бодлогууд гарч, ямар санхүүгийн дэмжлэгүүд явснаар үндэсний үйлдвэрүүд хэрхэн босож ирэх, шинэ шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл бүрдсэн талаарх нийтлэл, ярилцлага, сурвалжлагыг цогцоор нь хөндлөө.


“Хүнсний хувьсгал”-ын үр дүнд Төрийн тэргүүнээсээ эхлээд үндэсний үйлдвэрлэгчид сэтгэл хангалуун, баяртай байна. Энэ л өөрөө үр дүн хэр гарсныг харуулах үзүүлэлт болно. Та манай шинэ дугаараас улс оронд маань ямар хувьсгал эхэлж, яаж өрнөж, ямар үр дүнг үзүүлснийг мэдэх болно. Тэгээд та ч баярлах болно.

Сэтгүүлийн редакц

"ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



"ЦАГААН АЛТ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



"ТЭРБҮМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



"АТРЫН IV АЯН"



МЭНДЧИЛГЭЭ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

Эрхэм хүндэт хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгчид Та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Аливаа улс орны хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдал, ард түмний аж амьдралд эрүүл, чанартай хүнсний хангамж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил дэвшил чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авах”-аар заасан байдаг.

Хүнсний хангамж, аюулгүй байдал бол манай ард иргэдийн эрүүл саруул, элбэг дэлбэг, аз жаргалтай амьдрах гол хүчин зүйлүүдийн нэг тул улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалтай адилтган авч үздэг учиртай.

Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгч гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, улмаар хүнс экспортлогч орон болох зорилт дэвшүүлэн “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг санаачилж, улс орон даяар хэрэгжүүлээд багагүй хугацаа өнгөрч байна.

Өнгөрсөн хугацаанд тус хөдөлгөөний хүрээнд олон улсын стандартад нийцсэн 53 үйлдвэр үүд хаалгаа нээж, шинээр 1000 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, ард иргэдийнхээ гар дээр хүргэж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Эх орондоо үйлдвэрлэгдсэн эрүүл, чанартай эдгээр хүнсний бүтээгдэхүүнээ өргөнөөр хэрэглэж, эх оронч худалдан авалт хийн, баялаг бүтээгчдийнхээ үйл ажиллагааг дэмжихийг нийт ард иргэддээ Төрийн тэргүүн уриалж байна.

Цаашид Монгол төр улс орныхоо хүнсний хангамж, аюулгүй байдалд дүн шинжилгээ хийж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах, мал аж ахуй, газар тариаланг шинэ шатанд гарган хөгжүүлэх, бүс нутагтаа хүнсний экспортлогч улс болох зорилтуудыг тууштай хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, эдийн засгийн тогтворгүй байдал, халдварт өвчин, олон улсын геополитикийн нөхцөл байдал зэрэг хүчин зүйлээс үүдэлтэй гарч болзошгүй эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх учиртай.

Түүнчлэн Ногоон эдийн засгийг дэмжсэн ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлэх, Шим тэжээлд суурилсан хүнсний бодлогыг хэрэгжүүлэх, Нийгмийн хариуцлагад суурилсан хүнсний тогтолцоог хөгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг дэмжин хамтран ажиллаж, хүн ардынхаа хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үйлсэд хувь нэмрээ оруулж байгаа төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм болон олон улсын байгууллага, үндэсний үйлдвэрлэгчид Та бүхэнд гүн талархал илэрхийлж, ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай.



ДЭЛХИЙ НИЙТИЙГ ЭНХ ТАЙВАНД УРИАЛАВ

НҮБ 2022.09.13

У.Хүрэлсүх: Цэрэг арми, зэвсэглэлд зарцуулж буй энэ их төсөв, хөрөнгийг нэн буурай болон хөгжиж буй улс орнуудад зориулсан бол хэчнээн сая хүн ядуурлаас гарч, өвчин зовлонгоос ангижирч, хэчнээн сая хүн хоол хүнстэй, орох оронтой болох байсан бол. Энэ их зардал мөнгийг дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх их үйлсэд зарцуулсан бол ямар их ахиц дэвшил гарч болох байсан бол гэдгийг дэлхий нийтээрээ эргэцүүлэн бодож, тунгаан үзэх цаг нэгэнт болжээ.

ШХАБ 2022.09.19

У.Хүрэлсүх: Хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудалд улс орнууд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй. НҮБ-ын мэдээлснээр 2019 онд дэлхийн хэмжээнд 135 сая хүн хүнсний хэт дутагдалд орж байсан бол энэхүү үзүүлэлт өнөөдөр 2.5 дахин нэмэгдэж, 345 саяд хүрээд байна. Иймд улс орон бүр хүнсний хангамж, аюулгүй байдалдаа ихээхэн анхаарах шаардлагатай.

COP27 2022.11.07

У.Хүрэлсүх: Хөрс, хүнс, хүн гурав хүйн холбоотой. Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол хүн эрүүл. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх үйл хэрэг бол хөрсөө хамгаалах, хүнсээ хамгаалах, хүнээ хамгаалах хүн төрөлхтний суурь асуудал мөн.



United Nations Climate Change



Монгол Улсын
Ерөнхийлөгч
У.Хүрэлсүх

ЭРХЗҮЙН ОРЧИН



6 үйл ажиллагаа

УДИРДЛАГА
 ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



8 үйл ажиллагаа

ГАЗАР ТАРИАЛАН



11 үйл ажиллагаа

МАЛ АЖ АХУЙ



6 үйл ажиллагаа

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ



10 үйл ажиллагаа

5 ЧИГЛЭЛ, 41 ҮЙЛ АЖИЛЛАГАА, 114 АРГА ХЭМЖЭЭ

Эх сурвалж: ХХААХҮЯ

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа **бэхэжсэн нь**

Улс орнуудын үндэсний аюулгүй байдалд хүнсний салбар онцгой ач холбогдолтой байдаг. Энэ утгаараа дэлхийн улс орнууд дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих дунд, урт хугацааны бодлогыг төсөв, мөнгөний бодлоготойгоо уялдуулан тогтвортой хэрэгжүүлж, гол нэр төрлийн хүнсний дотоодоос хангахыг зорьж ажилладаг.

Дэлхий нийтээр 2020 онд коронавируст халдварын цар тахалд өртөж, 2022 онд ОХУ, Украйны хооронд дайн гарснаас үүдэж хүнсний бүтээгдэхүүний тээвэр, нийлүүлэлтийн сүлжээ доголдож улс орнуудын хүнсний аюулгүй байдалд шууд нөлөөлснийг та бид санаж байгаа.

Манай улс ч мөн адил энэ хүндрэлтэй нөхцөл байдлыг тойроогүй, туулж гарсан. Тиймээс Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар Засгийн газраас

Хоорондоо уялдаа холбоо бүхий “Хүнсний хувьсгал”, “Тэрбум мод”, “Атрын-4 аян аян”, “Цагаан алт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлсэн билээ.

Энэ хүрээнд 2022 оны зургаадугаар сарын 17-ны өдөр “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсан.

Тус тогтоолд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтын, газар тариалангийн үйлдвэрлэлийн, мал аж ахуйн үйлдвэрлэлийн, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 41 үйл ажиллагаа, 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. УИХ-ын 36 дугаар тогтоолоор таван жилийн бодлого, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, санхүүжилтийг хамтатган батлуулсан юм. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 оны улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бүрдүүлэв. “Хүнсний хангамж, аюулгүй байдал”-ын үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх 114 арга хэмжээний ▶

- ▶ 90 хувийг ХХААХҮЯ хэрэгжүүлж, бусдыг нь 35 байгууллага, олон улсын байгууллагууд, “Хүнсний хувьсгал” ТББ, эрдэмтдийн зөвлөл арилжааны 10 банк хамтран хууль журмын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийг зөвхөн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжихээс гадна Засгийн газраас татварын бодлогоор дэмжих, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр цогц бодлого хэрэгжиж буй юм. Мөн гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх зорилго тавьж, түүнд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүд авч байна. Үр дүнд нь 53 үйлдвэр шинээр баригдаж, импортын хамаарал тодорхой хэмжээгээр буураад байгаа юм. Түүнчлэн хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Ургамал хамгаалал, ургамлын эрүүл мэндийн тухай хууль батлагдаж, Хөдөө аж ахуйн тухай хууль, Хүнсний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт хэлэлцэгдэх шатанд явж байгаа юм байна.

Монгол Улс хөдөө аж ахуй, эрчим хүч, дэд бүтэц, эрүүл мэнд зэрэг нийгэм, эдийн засгийн голлох салбаруудын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж буй. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Цагаан алт”, “Атрын-4 аян” зэрэг үндэсний хөдөлгөөнүүдийг санаачилж, улс орон даяар хэрэгжүүлж байгаа бөгөөд төр, хувийн хэвшил, баялаг бүтээгчид, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, ард иргэд идэвхтэй оролцож, хамтран ажиллаж байна. Тухайлбал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан ургуулснаар ойн хомсдол, доройтлыг бууруулах, усны нөөц, хүлэмжийн хийн шингэлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тогтвортой санхүүжилтийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байгаа юм.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол монгол хүн эрүүл. Энэ гурав хоорондоо хүн холбоотой” гэдэг уриагаар “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлж байв. Энэ хүрээнд

2022 он

- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг хуралдуулж зөвлөмж гаргаснаар УИХ-ын чуулганы 2022 оны тавдугаар сарын 13-ны өдрийн хуралдааны индэр дээрээс “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг зарлаж буйгаа мэдэгдсэн.
- “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг 2022 оны зургаадугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.

2023 он

- 2023 оны нэгдүгээр сарын 2-нд Түр хорооны хоёрдугаар тогтоол гарч, 20 хувиас багагүй санхүүжилтийг жижиг, дунд үйлдвэрлэлд олгохоор тусгасан.
- 2023 оны дөрөвдүгээр сарын 1-нд Засгийн газрын 63 дугаар тогтоол батлагдаж, арилжааны 10 банкны эх үүсвэрээр Засгийн газраас хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн.

хоорондоо уялдаа холбоо бүхий “Тэрбум мод”, “Атрын-4 аян”, “Цагаан алт хөтөлбөр”-ийг мөн хэрэгжүүлж байгаа юм. Энэ талаар Ерөнхийлөгч “Хөрс сайн байж эрүүл хүнс бий болно. Тиймээс хөрсөө хамгаалахын тулд мод тарих ёстой. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн үүнтэй холбоотой. Олон улсын байгууллагууд манай хөдөлгөөнийг дэмжиж, үлгэр жишээ авдаг болсон байна. Энэ хүрээнд үндэсний үйлдвэрлэгчид хөрсөө хамгаалах, байгаль орчноо хамгаалах чиглэлд санаачилга гаргаж байгаад баяртай байна. Бид 100, 100 жил мод тарьж ойжуулах ёстой юм билээ. Тэгээд хүнс нь эрүүл хөрсөнд ургах ёстой юм. Бид дотоодынхоо хүнсний хэрэгцээг хангадаг болох хэрэгтэй. Үүний зэрэгцээ хүнс экспортлогч орон болъё гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэ боломжтой” хэмээн ярьсан.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжээд 3.5 жил болж байна. Энэ хугацаанд Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа жинхэнэ утгаараа хэрэгжиж, олон төрлийн арга хэмжээ нь очих ёстой эздэдээ хүрсээр байна. ■

“Хүнсний хувьсгал”-д төр болон төрийн бус байгууллагууд нэгдэв

ИНФО

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН

ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРЖ БҮЙ ҮЙЛДВЭРИЙН ТОО

ШИНЭ ҮЙЛДВЭР 

17 Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр

Ашиглалтад орсон 13

ӨРГӨТГӨЛ 


8 Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр

Ашиглалтад орсон 6

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ 

4 Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр

Ашиглалтад орсон 3



МАЛ ТӨХӨӨРӨХ хүчин чадал


879 өсөлт тн/хоног 

2025.III (2679 тн/хон) улирлын байдлаар 2022 (1801 тн/хон) оноос 49% өсөв (150 хоног ажилладаг)

МАХ БОЛОВСРУУЛАХ хүчин чадал

1.5 өсөлт тн/хоног 

2025.III (1041 тн/хон) улирлын байдлаар 2022 (997 тн/хон) оноос 0.2% өсөв

 2025.III улирал

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРЖ БҮЙ ҮЙЛДВЭРИЙН ТОО

ШИНЭ ҮЙЛДВЭР 

10 Сүү боловсруулах үйлдвэр

Ашиглалтад орсон 5

ӨРГӨТГӨЛ 


3 Сүү боловсруулах үйлдвэр

Ашиглалтад орсон 2

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ 

8 Сүү боловсруулах үйлдвэр


Ашиглалтад орсон 6




СҮҮ БОЛОВСРУУЛАХ хүчин чадал

520 өсөлт Тн / хоног 

2025.III (480 тн/хон) улирлын байдлаар 2022 (904 тн/хон) оноос 88% өсөв

 2025.III улирал

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



БАЯЛАГ БҮТЭЭГЧИД

“Хүнсний хувьсгал”-ын үр дүнд 53 үйлдвэр ашиглалтад оров

Төрийн бодлого хэрэгтэй цагтаа, зөв зүйлд хүрэх нь богино хугацаанд ямар том амжилтыг дагуулж болдгийг “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнөөс харж болохоор байна. Энэхүү хөдөлгөөний хүрээнд 2500 гаруй аж ахуйн нэгж 1.26 их наяд төгрөгийн зээл авч үйлдвэрээ өргөжүүлж, шинээр барьж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, чанарыг нь сайжруулж бүр цаашлаад экспортод гаргах тухай өөдрөг мөрөөдөлтэй болжээ. Энэ бол 3.5 жилийн дотор гарсан үр дүн. Энэ хөдөлгөөн амжилттай хэрэгжихэд Ерөнхийлөгчийн баг хамт олон тэр дундаа “Хүнсний хувьсгал” төрийн бус байгууллага хичээл зүтгэл гарган ажилласныг дурдах нь зүйтэй.

Мөн гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодынхоо хэрэгцээг хангаж, улмаар экспортлогч орон болё гэдэг зорилт бас тавьсан. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хөтөлбөрт хамрагдаж амжилттай ажиллаж байгаа

олон үйлдвэрээр орж, үйл ажиллагаатай нь танилцав. Тэд үнэхээр хийе, бүтээе, эрүүл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэе гэсэн чин сэтгэлээр хичээн зүтгэж ажиллаж байна. Өндөгний үйлдвэрлэгч “Түмэн шувуут”, талх нарийн боов, бялууны “Жүр үр”, “Монос хүнс”-ээс эхлээд жижиг, дунд аж ахуйн нэгж “Eden”, “Өгөөмж Архад” талх нарийн боовны үйлдвэрээр орж танилцсан юм. Тэд хийж бүтээх эрмэлзэл, нүдэнд нь гал, хүсэл тэмүүлэл дүүрэн харагдана. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх анх удаагаа хүнсний асуудлыг үндэсний хэмжээнд аваачиж, том хөдөлгөөн өрнүүлсэн нь хэдхэн жилийн дотор үр дүнгээ өгсөн нь ийн харагдаж байна.

“Түмэн шувуут” компани гэхэд л урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл авч, өнгөрсөн онд “Түмэн шувуут-2” үйлдвэрээ ашиглалтад оруулан, дараагийн үйлдвэрээ барьж байна. Энэ онд 170 сая, ирэх жил 250 сая ширхэг өндөг үйлдвэрлэх бөгөөд энэ нь бусад энэ чиглэлийн

**“Жүр үр”
компани 10.000
кв.м талбай
бүхий шинэ
үйлдвэрийн
байр
ашиглалтад
оруулав**



▶ аж ахуйн нэгжүүд нийлээд дотоодын зах зээлийн 75 хувь гэсэн үг юм. 2026 онд бүрэн хүчин чадлаараа ажиллаж 100 хувь хангах зорилт тавьж байна. Харин “Монос хүнс” компани 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээл авчээ. Ингэснээр дэвшилтэд тоног төхөөрөмж бүхий шинэ үйлдвэрээ ашиглалтад оруулж хүнсний агуулахаа өргөтгөхийн зэрэгцээ нийслэлийн зүүн бүсэд шинэ агуулахын бүтээн байгуулалтыг эхлүүлж, хүүхдэд зориулсан жимсний нухашны тоног төхөөрөмжөө шинэчилжээ. Үүний үр

дүнд үйлдвэрлэлийн хүчин чадал гурав дахин нэмэгдэж, үйлдвэрлэлийн биет хэмжээ 96 хувь, борлуулалтын орлого 2022 онтой харьцуулбал 68 хувиар буюу 19 тэрбум төгрөгөөр өссөн байна. “Жүр үр” компани бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, 10.000 кв.м талбай бүхий шинэ үйлдвэрийн байраа ашиглалтад оруулан хүчин чадлаа нэмэгдүүлжээ. Харин жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг “Eden” компани үйлдвэрийн хүчин чадлаа 3.5 дахин нэмжээ. Мөн үйлдвэрлэл шинэ шатанд гарч долоон брэндийн 68 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн нэмэгдэж, үйлдвэрлэлийн хэмжээ нь 1489 тонн буюу 89 хувиар өсжээ. Энэ өсөлтийг дагаад улсад төлөх татвар, НӨАТ, НДШ 2-3 дахин өссөн байна.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголд амжилттай хэрэгжиж байгаа олон улсын төслүүд ч бий. Манай баялаг бүтээгчид ч зогсолтгүй ажиллаж байна. Төр засгаас сайн дэмжиж байна. Арилжааны 10 банкаар бага хүүтэй зээл олгож татаасыг нь улсаас хариуцаж байна. Дээрээс нь зээлийн батлан даалтын сангаас аж ахуйн нэгжийн зээлийг нь батлан дааж байна. Тэд хамтдаа энэ бүгдийг бүтээж байна. ■

937 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР

2025.III

884 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР

2022 он

ХҮНСНИЙ
ҮЙЛДВЭР
53-ААР
НЭМЭГДЭВ

- Мал төхөөрөх **102**, мах боловсруулах **76**
- Сүү боловсруулах үйлдвэр **83**
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр **437**
- Ургамлын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр **16**
- Давсны үйлдвэр **8**
- Шингэн хүнсний үйлдвэр **162**

- Мал төхөөрөх **112**, мах боловсруулах **83**
- Сүү боловсруулах үйлдвэр **93**
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр **452**
- Ургамлын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр **19**
- Давсны үйлдвэр **6**
- Шингэн хүнсний үйлдвэр **165**
- Бусад **7**

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Ч.ДАВААБАЯР: Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫГ санаачилснаараа түүхэнд үлдэнэ



Төрийн бодлого удаан, үр дүн нь бүдгэрдэг гэх ойлголт олон нийтэд байдаг. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн богино хугацаанд эрчимтэй хэрэгжиж, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, байгууллагуудын уялдааг нэг дор төвлөрүүлсэн бодит үр дүнгээрээ анхаарал татаж байна. Эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоод, холбогдох яамд, төрийн захиргааны байгууллагууд, арилжааны банкууд, олон улсын байгууллага зэрэг өргөн хүрээний оролцоотойгоор хэрэгжиж буй энэ хөдөлгөөнд 2500 гаруй аж ахуйн нэгж хамрагдаж, шинээр 53

үйлдвэр бий болсон нь хөдөлгөөний бодит нөлөөг илтгэнэ. Энэхүү ажлыг бодлогын түвшинд гардан чиглүүлж, талбар дээр нь явж зөв менежментээр удирдсан хүмүүсийн нэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх, “Хүнсний хувьсгал” мэргэжлийн холбооны тэргүүн, Доктор, Профессор Ч.Даваабаяр. Түүнтэй хийсэн ярилцлагаас “Хүнсний хувьсгал”-ын зорилго, механизм, цаашдын стратеги, тэр дундаа олон улсын бодлого, хоёр хөрштэй харилцах эдийн засгийн бодит нөхцөл, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль эрх зүйн шинэчлэлийн шаардлага илүүтөдөрхой харагдана. ▶

► **“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжээд багагүй хугацаа өнгөрчээ. Таны хувьд энэ ажилтай хэрхэн холбогдсон бэ?**

“Хүнсний хувьсгал” эхлэх үед би Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд энэ жил тав дахь жилдээ ажиллаж байна. Мөн “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”-ны ерөнхийлөгчөөр арван жил ажиллах хугацаандаа Монгол Улсаа хоёр бүтэн тойрч, баялаг бүтээгчидтэйгээ уулзсан байна. Жижиг, дунд, өрхийн үйлдвэрлэгчидтэй ойр ажилласнаа Ерөнхийлөгчийн зөвлөхийн ажлын хүрээнд үндэсний томоохон үйлдвэрлэгчид, бодлогын байгууллагуудтай уялдуулан үргэлжлүүлж байна.

► **“Хүнсний хувьсгал” богино хугацаанд үр дүнд хүрэхэд юу нөлөөлсөн бэ?**

Зах зээлийн эдийн засагт шилжсэн сүүлийн 30 гаруй жилд хүнсний аюулгүй байдлын асуудал тодорхой хэмжээнд орхигдсон. Үүний үр дагаварт иргэд гарал үүсэл, хадгалалт, шим тэжээл нь эргэлзээтэй бүтээгдэхүүн хэрэглэх эрсдэлтэй нүүр тулсан. Энэ бол зөвхөн хэрэглээний асуудал биш, эрүүл мэнд, аюулгүй байдал, цаашлаад үндэсний аюулгүй байдлын асуудал юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд иргэн эрүүл, аюулгүй амьдрах, улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой байдал хангагдах асуудлыг үндсэн суурь гэж үздэг. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд улс орныхоо тусгаар тогтнолыг баталгаажуулах, ард иргэдээ эрүүл, аюулгүй хүнсээр хангах том зорилгын төлөө “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг санаачилж, өөрийн биеэр манлайлан ажилласаар бодит үр дүн гаргаж чадлаа. Үүгээрээ Төрийн тэргүүн Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарт түүхэн шийдвэр гаргаж хэрэгжүүлсэн түүхэн хүнээр тодорч үлдэх болно.

Нөгөө талд, олон улсын орчин өөрөө хүнсний бодлогын ач холбогдлыг өсгөсөн. Дэлхий нийтээрээ уур амьсгалын өөрчлөлт, нийлүүлэлтийн сүлжээний эмзэг байдал, үнийн савлагаа, улс орнуудын экспортын хязгаарлалт зэрэг хүчин зүйлс нэмэгдэж

байна. Ийм үед Монгол Улс импортын өндөр хамаарлыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлээ өсгөх нь тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдлын нэг хэсэг юм.

Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн “Халамжаас хөдөлмөрт, олборлолтоос боловсруулалтад, импортоос экспортод” шилжих суурь реформ, “100 жил – 10 зорилт” санаачилгын хүрээнд хүнсний аюулгүй байдлыг хангаж, дотоодын хэрэгцээгээ бүрэн ханган, улмаар бүс нутагтаа хүнс экспортлогч улс болох томоохон зорилт тавьж байна.

► **Хөдөлгөөний хэрэгжилтийн бүтэц, уялдаа ямар байна вэ?**

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 114 ажил хэрэгжиж байна. Гол ажлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариуцан хэрэгжүүлж, УИХ-ын дөрвөн байнгын хороо, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хүнсний төсөл, хөтөлбөрийн

алба, салбарын эрдэмтдийн зөвлөл, төрийн захиргааны байгууллагууд, олон улсын байгууллагууд, “Хүнсний хувьсгал” ТББ, арилжааны банкууд, хэвлэл мэдээллийн баг хамтран ажиллаж байна.

Мөн 28 мэргэжлийн холбоо нэг дор уялдсан нь бодлогын том давуу тал болсон. Ингэснээр салбарын асуудлыг нэг ширээний ард бодитоор ярьж, шийдвэр гаргалт руу оруулах боломж нэмэгдсэн. ►

Төр, хувийн хэвшлийн уялдааг маш сайн ханган ажиллаж байгаа



ORDA хүнсний үйлдвэр. Өвөрхангай аймаг

▶ Манай алба “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг ЕТТ-ын чиг үүргийн хүрээнд зөвлөж, төр-хувийн хэвшлийн уялдааг хангах уулзалт, зөвлөлдөх механизмуудыг тогтмол ажиллуулж ирсэн.

-Ерөнхийлөгч “Давсаа хүртэл айлаас гуйхаа больё” гэж уриалсан. Энэ уриа бодлогын хувьд юуг илэрхийлсэн бэ?

-Ерөнхийлөгчийн “Давсаа хүртэл айлаас гуйхаа больё” гэх уриа нь нэг бүтээгдэхүүн, нэг салбарын тухай энгийн санаа бус, харин улс орны тусгаар тогтнол, дархлаа, аюулгүй байдлыг хүнсээр дамжуулан баталгаажуулах бодлогын гүн утгыг илэрхийлсэн стратегийн мессеж юм. Энэхүү уриа нь хүнсний хэрэгцээгээ дотоодоос хангах чадварыг бий болгох, өөрөөр хэлбэл улс орон өөрийн нөөц,

үйлдвэрлэл, мэдлэгт тулгуурлан тогтвортой орших чадамжтай байх ёстой гэсэн үзэл баримтлалыг илтгэнэ. Ийм утгаараа “Хүнсний хувьсгал” нь зөвхөн үйлдвэрлэл, эдийн засгийн бодлого бус, үндэсний аюулгүй байдал, стратегийн бие даасан байдлын бодлого юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн энэ үзэл санаа нь ковид цар тахлын хүнд үед Ерөнхий сайдын хувиар улс орныг удирдаж байхдаа хүнсний нийлүүлэлтийн эмзэг байдлыг бодитоор туулсан туршлага дээр суурилж, улмаар Ерөнхийлөгчийн институтийн түвшинд залгамж чанартайгаар бодлого болон өргөжсөн гэдгээрээ онцлог. Өөрөөр хэлбэл, богино хугацааны хариу арга хэмжээ бус, төрийн бодлогын тогтвортой үргэлжлэл болж чадсан юм. ▶



"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн үр дүн, үзэсгэлэнгийн арга хэмжээ 2025.12.12

► “Хүнсний хувьсгал” нь цогц хандлагатай бодлого тул үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, санхүүжилтээс гадна мэдээлэл, соён гэгээрэл, олон нийтийн оролцоог бодлогын салшгүй хэсэг хэмээн үзсэн. Энэ хүрээнд төр, мэргэжлийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн салбар харилцан уялдаа, итгэлцэлд суурилан ажиллаж, өнөөдрийн байдлаар 150 цуврал нэвтрүүлэг, 1000 гаруй сошиал контент, зургаан дугаар бүхий сэтгүүлийг бэлтгэн олон нийтэд хүргээд байна.

Энд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн гурван өндөрлөгийн бодлогын уялдаа, мөн ардчилсан нийгмийн чухал тулгуур болох “дөрөв дэх засаглал” буюу хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоо онцгой үүрэг гүйцэтгэж байна. Энэ хамтын ажиллагаа нь зөвхөн бодлогыг тайлбарлах бус, иргэн бүрийн ухамсар, хандлага, сонголтод нөлөөлөх соён гэгээрлийн хөдөлгөөн болон өргөжсөнөөрөө онцлог гэдгийг цохон тэмдэглэн хэлэх байна.

Иймд “Хүнсний хувьсгал” нь хүнс үйлдвэрлэх хувьсгал байхаас гадна Монгол хүний сэтгэлгээ, оюун санаанд чиглэсэн хувьсгал болж, “гадаадаас хараат бус, өөрийн хүч боломждоо итгэдэг” үндэсний ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэж байна.

–“Хүнсний хувьсгал”, “Атрын IV аян”, “Цагаан алт” бодлогуудын уялдаа, эдийн засгийн үр нөлөөг та хэрхэн харж байна вэ?

–Сүүлийн жилүүдэд хил гаалиар уул уурхайн тоног төхөөрөмж давамгайлж орж ирдэг байсан бол одоо хөдөө аж ахуйн машин, тоног төхөөрөмжийн эзлэх хувь эрс нэмэгдсэн нь өөрөө чиг хандлагын өөрчлөлт юм. “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Атрын IV аян” гэсэн харилцан уялдаатай бодлого нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, газар тариаланг мал аж ахуйтай хослуулах, түүнд суурилсан боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилготой.

Төрийн үндсэн үүрэг бол иргэдээ эрүүл хүнстэй, ажилтай, орлоготой байлгах. Энэ суурийг хангаж чадсанаар үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг бэхжинэ. Хөдөө аж ахуйн сэргэлт нь зөвхөн ажлын байр биш орон нутгийн эдийн засгийг тэтгэж, импортыг орлох бодлогын гол хэрэгжүүлэгч болж байна. Цаашилбал экспортын шинэ боломж нээж,



“Хүнсний хувьсгал” мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн Х хуралдаан

валютын эх үүсвэрийн “хоёр дахь багана” болох суурь тавигдаж, эдийн засаг солонгорч, уул уурхайн бус салбар хөгжинө.

–“Хүнсний хувьсгал” цаашид үргэлжлэх ёстой гэдэг дээр олон нийтийн хүлээлт байна. Таны байр суурь ямар вэ?

–“Хүнсний хувьсгал” II, III гээд шаталсан байдлаар үргэлжлэх нь зайлшгүй. Дэлхийд хүнсний реформ 30-50 жил үргэлжилсэн жишээ олон бий. Манай улсын хувьд ч 25-30 жил тасралтгүй хэрэгжүүлж байж дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах түвшинд хүрнэ. Бид органик хүнс экспортлогч улс болох зорилготой. Эхний ээлжид тогтолцоог эхлүүлээ. Цаашид эрх зүйн орчин бүрдэж, тогтолцоо бэхжвэл ямар ч удирдлага солигдсон бодлогын залгамж чанар алдагдахгүй. Ийм учраас хууль эрх зүйн шинэчлэл бол дараагийн шатны хамгийн гол багана болж байна.

–Эрх зүйн орчны шинэчлэл гэж яг юут хэлж байна вэ?

–Нэгдүгээрт, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын “суурь хууль”-ийн зохицуулалт илүү тодорхой, уялдаатай болох шаардлагатай. Хоёрдугаарт, үйлдвэрлэл–гээвэр–хадгалалт–борлуулалт–экспорт хүртэлх сүлжээнд стандарт, хяналт, хариуцлагын тогтолцоо нэг ►

► мөр байх ёстой. Мөн олон улсын худалдааны бодит нөхцөл, хоёр хөрштэй хийх худалдаа, транзит, логистикийн орчин, гуравдагч зах зээлд гарах шаардлага зэрэг нь дотоодын эрх зүйтэй салшгүй холбоотой. Тиймээс ойрын хугацаанд хэд хэдэн хуулинд өөрчлөлт оруулах шаардлага бий. Ерөнхий зорилго нь импортыг орлох үйлдвэрлэлийг хамгаалах, экспортын өрсөлдөх чадварыг өсгөх, чанар, стандарт, итгэлцлийн тогтолцоог бүрдүүлэх явдал.

-Дараагийн шатанд анхаарах сургамж, засах шаардлагатай зүйл юу байна вэ?

-Монгол Улс чинээлэг дундаж давхаргыг бий болгож байж тогтвортой хөгжинө. Бизнесийн 90 орчим хувь нь жижиг, дунд үйлдвэрлэл байдаг учраас кластерын системээр уялдуулах нь чухал. Төрийн цогц бодлого, тогтолцооны шинэчлэлгүйгээр дараагийн шатны өсөлт тогтворжиход бэрх л дээ. Мөн санхүүжилтийн тэнцвэр дээр анхаарах шаардлага бий. Жишээ нь газар тариалан, хүнсний салбарт бага хүүтэй зээл очиж байгаа ч мал аж ахуй руу очих санхүүжилт харьцангуй бага байх тохиолдол байна. Эрсдэл өндөр гэх шалтгаанаар банкууд болгоомжлох хандлагатай. Энэ тохиолдолд эрчимжсэн мал аж ахуй хөгжихгүй, бодлого эзэндээ хүрэхгүй эрсдэл үүснэ. Энэ мэт асуудлыг дараагийн шатанд илүү нарийн засаж, зөв тэнцвэржүүлэх ёстой. Эцсийн зорилго бол Монгол хүн эрүүл хүнс хэрэглэж, илүү чанартай, урт удаан амьдрах, улс орон

хүнсээрээ бие дааж, цаашлаад экспортын шинэ гарц нээх асуудал юм.

-Үндэсний хөдөлгөөн эрчимтэй өрнөж, бодит үр дүн гарч эхэлсэн энэ үед бодлогын дараагийн шатанд ямар эрх зүйн болон зах зээлийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай гэж та үзэж байна вэ?

-Өнөөдөр “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн нь төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, санхүүгийн байгууллага, хэвлэл мэдээлэл зэрэг олон талын түншлэлд тулгуурлан богино хугацаанд бодит үр дүн гаргаж чадсан цөөн бодлогын нэг болж байна. Энэ нь зөвхөн санхүүжилт, дэмжлэгийн асуудал бус, харин нийт нийгмийг хамарсан итгэлцэл, хамтын ажиллагаанд суурилсан үндэсний хөдөлгөөн болж өргөжсөний илрэл юм.

Гэхдээ энэхүү эрчийг тогтвортой хадгалах, хүрсэн үр дүнг алдахгүй баталгаажуулахад хууль эрх зүйн орчны шинэчлэл удаашралтай байгааг бодитоор хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Тухайлбал, Хөдөө аж ахуйн тухай хууль, Худалдааны тухай хууль, Импортын зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд бодлогын энэ хурдтай уялдаж шинэчлэгдэхгүй байгаа нь хөдөлгөөнийг тодорхой хэмжээнд хойш татаж буй бодит хүчин зүйл болж байна.

Иймд цаашид дотоодын үйлдвэрлэлийг төрийн худалдан авалтын бодлогоор дэмжих, эх оронч худалдан авалтыг тогтолцооны түвшинд хэвшүүлэх, мөн импортын татварыг үе шаттайгаар нэмэгдүүлж, дотоод зах зээлээ хамгаалах эрх зүйн шийдлүүдийг зоригтой хийх нэн шаардлагатай байна. Үүний зэрэгцээ сүлжээ хүнсний дэлгүүрүүдийн хувьд үндэсний үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнд зориулсан лангуу, талбайг бодлогоор өргөтгөх, ил тод, тэгш өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.

Эцэст нь хэлэхэд, “Хүнсний хувьсгал” бол эхэлсэн хөдөлгөөн бус, тогтсон тогтолцоо болох ёстой бодлого юм. Үүний тулд богино хугацаанд гарсан амжилтыг эрх зүй, зах зээлийн хамгаалалт, худалдан авалтын бодлогоор баталгаажуулж чадвал Монгол Улс хүнсээрээ бие даасан, өрсөлдөх чадвартай, дархлаатай улс болох бодит боломж бүрдэж байна. ■



"Хүнсний хувьсгал" ажлын алба. Зүүн гар талаас Ш.Баасанжав, Б.Батцэцэг, Ч.Даваабаяр, Н.Мөнхцацрал, О.Нямсүрэн, Ө.Төмөрбаатар



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн 2023.04.15



Баялаг бүтээгчид Энэтхэг улсын аж үйлдвэрийн паркт зочилло

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

“Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийг зөвхөн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээс гадна Засгийн газраас татварын бодлогоор дэмжих, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр цогц бодлого хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгсөн билээ. Тодруулбал, зээлээс гадна олон төрлийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулал, татаасыг аж ахуйн нэгж, иргэнд үзүүлсэн юм.

“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫН ДЭМЖЛЭГҮҮД

— Хөрс эрүүл бол хүнс эрүүл - Хүнс эрүүл бол хүн эрүүл



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд:

- Жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 90 хувиар хөнгөлсөн. Энэ нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ачааллыг мэдэгдэхүйц бууруулж, бизнесээ өргөжүүлэх боломж өгч байна.
- Үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс, жимсгэнэ, тэжээл, тэжээлийн ургамал тариалсан, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн эрчимжсэн тахианы аж ахуйн орлогын албан татварыг 50 хувиар хөнгөлсөн. ▶

- Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг 2027 он хүртэл импортын гаалийн албан татвараас бүрэн чөлөөлсөн.

БУЦААН ОЛГОЛТЫН ДҮН

2023 онд 59 аж ахуйн нэгжид 2.1 тэрбум төгрөг


2024 онд 53 аж ахуйн нэгжид 6.7 тэрбум төгрөг

- Дотооддоо тарьж, борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, гурилыг НӨАТ-аас, дотооддоо үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлсөн.
- Дотоодын түүхий эдээр боловсруулж, дотооддоо борлуулсан хүнсний сүү, сүүн бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлсөн.
- Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид үйлдвэрлэл технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг нь эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлсөн.
- Үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас эхний таван жилд чөлөөлж, дараагийн таван жилд 50 хувиар хөнгөлж байна.
- Боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барихад зориулан импортоор оруулж ирж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан

татварын төлөх хугацааг хоёр жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг хоёр жилийн хугацаанд хэсэгчлэн төлөх зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

- Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлж байна.
- Хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгааны болон хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2025 он хүртэл НӨАТ-аас бүрэн чөлөөлөх шийдвэр гарсан. Эдгээр арга хэмжээ нь нэг талаас үйлдвэрлэл эрхлэгчдийн зардлыг бууруулж, нөгөө талаас хөдөө аж ахуй, хүнсний салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх, цаашлаад хүнсний хангамжийг бэхжүүлэх чухал алхам болж байна.
- “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн үр дүнд гарсан эерэг үзүүлэлтүүдээс дурдвал, газар тариалангийн салбарт улаан буудайн усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, таримлын шинэ сортыг нутагшуулах, турших, тэдгээрийн сортын элит баталгаат үр үржүүлэхийг дэмжих, бордоо болон техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлт олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн юм.
- Байцаа, сонгино, саримс, чинжүү, улаан лооль, өргөст хэмх, навчит ногоо, шар лууван, хүрэн манжинд урамшуулал олгож байна. ■

Хүнсний ногооны ургацын тонн тутамд 100 мянган төгрөгийн урамшуулал олгов



Дотоодын ургацаас хүнсний ногооны 72.6 хувийг хангав

278.3 мянган тонн үр тариа	252.3 мянган тонн улаанбуудай	108.5 мянган тонн төмс
208.6 мянган тонн хүнсний ногоо	146.5 мянган тонн тэжээлийн ургамал	27.4 мянган тонн тосны ургамал

Энэ нь хүн амын хэрэгцээт улаан буудайн 62.5 хувь, төмсний 78.5 хувь, хүнсний ногооны 72.6 хувийг дотоодын ургацаас хангасан амжилт үзүүлжээ.

ХҮНС



Давс

6%



67%


Гурилан бүтээгдэхүүн



Гурил

77%

ГОЛ НЭР ТӨРЛИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ 100 ХУВЬ ДОТООДООСОО ХАНГАНА



Өндөг

75%

Манай улсын хувьд мах, махан бүтээгдэхүүн, сүү, гурил, төмс, лууван, шар манжин зэрэг бүтээгдэхүүнийг дотоодоосоо бүрэн хангадаг болжээ. Харин сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, байцаа, сонгино, өндөг зэрэг бүтээгдэхүүнийг 58-95 хувь хангаж байна.



Жимс, жимсгэнэ

9%



Хүлэмжийн ногоо

52%



Тахианы мах

4%


Маж

100%



Махан бүтээгдэхүүн

79%





Лууван

97%



Сонгино

97%



Байцай

95%



Сармис

85%



Төмс

100%

Хэдхэн жилийн өмнө КОВИД-19 цар тахал болоход монголчууд бид ямар өчүүхэн гэдгээ мэдэрсэн. Идэх хоол, өмсөх хувцсаа хүртэл гаднаас авдаг байв. Цар тахлын хөл хорио удаан үргэлжилж, хил хаагдвал Монгол Улс хүнсний картын бараанд шилжихээс өөр замгүй, хатуу сонголттой нүүр тулсныг бид харсан. Энэ бүхэн монголчуудад дохио сануулга болсон билээ. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнүүдийг дотооддоо тарьж ургуулдаг, үйлдвэрлэдэг болохын тулд “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг санаачилсан. Үүний тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангах. Мөн импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавих шаардлага, стандартыг нэмэгдүүлж, эрүүл, чанартай хүнс хэрэглэх тогтолцоог сайжруулах зорилт тавьсан юм. Тус зорилго ч тодорхой хэмжээнд биеллээ олж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээмж, үйлдвэрлэлийн хэмжээ, дотоодын нийлүүлэлт эрчимтэй өсөж байна. Хүнсний үйлдвэрлэлийн салбарт мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, жимс, хүнсний ногоо, даршилсан, хөлдөөсөн бүтээгдэхүүний шинэ үйлдвэрүүд ашиглалтад орж, импортын хамаарлыг бууруулах чиглэлд бодит ахиц гарч байна. Дотоодын үйлдвэрлэлд чиглэсэн татвар, хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээл, технологийн шинэчлэл, экспортын дэмжлэг зэрэг бодлого хэрэгжсэнээр хувийн хэвшлийнхний идэвх ч нэмэгджээ.



Цөцгийн тос

47%

Ургамлын тос

10%



Сүү

100%



Сүүн бүтээгдэхүүн

87%



Хүрэн манжин

100%

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд оролцогч талуудын сэтгэгдлийг хүргэе.



Ч.ДАВААБАЯР
/Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
Үйлдвэр,
үйлчилгээний
бодлогын зөвлөх/

Төр бодлогоор үйлдвэрлэгчдээ хамгаалах ёстой

Импортын гаалын татварыг үе шаттай нэмэгдүүлж, төр үндэсний үйлдвэрлэгчдээ бодлогоор хамгаалах шаардлага үүсэж байна. Хоёрдугаарт, ард иргэд эх оронч худалдан авалт хийж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй. Импортын гаалийн албан татварыг үе шаттай нэмэгдүүлэх, Худалдааны хуулийг нэн яаралтай батлах нь чухал. Манай улс чөлөөт эдийн засагт аль эрт шилжсэн ч худалдааны зохицуулалт сул явж ирлээ. Импортын хүнс бараа ихээр орж ирж байна шүү дээ. Үндэсний үйлдвэрлэл нь арай хийж босож ирчхээд импортын хямд бараатай яаж өрсөлдөх билээ. Үйлдвэрлэгчид үйлдвэрээ барина, тоног төхөөрөмжөө шинэчилнэ, ажлын байрыг бий болгоно, улсад татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс гадна тог цахилгаан, дулаан, интернэт, ус гээд бүх зүйлээ дотоодоосоо хэрэглэж байгаа нь эдийн засгийн эргэлт сайжирч,

ажлын байрыг нэмэгдүүлж байна. Үндэсний үйлдвэрлэл баялаг бүтээгчдээ дэмжсэн бодлого хөтөлбөрүүд урт хугацаандаа үргэлжлэх шаардлагатай.

Өрхийн үйлдвэрлэл, бичил, жижиг, дунд, том аж ахуйн нэгжүүд бүгд кластераар хамтран ажиллах ёстой. Ингэснээр бид "Хүнсний хувьсгал"-ыг хийж чадна. Жижиг, дунд үйлдвэрлэл улс орны стратегийн маш чухал салбар байдаг. Энэ салбарыг дэмжсэн бодлого, санхүүгийн дэмжлэг, төрийн худалдан авалт зэрэг дэмжлэгүүд бий. Гэхдээ өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид энэ боломжийг төдийлөн авч чадахгүй хэвээр байгаа. Тиймээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид рүү чиглэсэн төрийн бодлого шинэчлэгдэж, нийгмийн чинээлэг дундаж давхаргын хүрээг тэлэх ёстой.

Уул уурхайн бус салбараа хөгжүүлж, эдийн засгаа солонгоруулж байж Монгол Улс хурдтай хөгжинө.



Т.ЖАМБАЛЦЭРЭН
/Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн
яамны Төрийн нарийн
бичгийн дарга/

Хөдөө аж ахуйн өсөлтийг урт хугацаанд тогтвортой хадгалах хэрэгтэй

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн сүүлийн жилүүдэд Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарт бодит ахиц, хэмжигдэхүйц үр дүн авчирсан. Ялангуяа газар тариалан, хүнсний боловсруулах үйлдвэрлэл, махны экспортын чиглэлд бодлогын дэмжлэг харьцангуй үр ашигтай хэрэгжжээ.

Үүнээс гадна экспортын бүтэц төрөлжиж, дулааны аргаар боловсруулсан махны экспорт нэмэгдэж байгаа нь эерэг хандлага юм.

Гэсэн хэдий ч анхаарах нэг асуудал нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувь 2021 оноос хойш буурч ирсэн явдал юм. Хэдийгээр 2025 оны эхний хагас жилд салбар 36.5 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 3.6 нэгж хувийг бүрдүүлсэн ч энэ өсөлтийг урт хугацаанд тогтвортой хадгалах бодлого зайлшгүй шаардлагатай байна. Тиймээс уг хөдөлгөөнийг үргэлжлүүлэх, хэрэгжүүлэх хугацааг сунгах шаардлага урган гарч байгаа юм.



З.БАУЫРЖАН
/Засгийн газрын
хэрэгжүүлэгч агентлаг
Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний ерөнхий
газрын дарга /

"Хүнсний хувьсгал"-ын хүрээнд 2448 иргэнд 21.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон

"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд иргэдэд 10.0-20.0 сая төгрөг хүртэлх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэлх сарын хугацаатай, хүүгүй, барьцаагүй олгож, бизнесийн үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. 2025 оны байдлаар улсын хэмжээнд 4462 иргэнд нийт 35.5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Үүнээс хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 632

иргэнд 4.8 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж, үйлдвэрлэл, үйл ажиллагааг нь тогтворжуулах, өргөжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хүрээнд хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж нийт 2448 иргэнд 21.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.



Ц.БАТЗУЛ
/Төрийн худалдан
 авах ажиллагааны
газрын дарга/

"Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд сурагчийн үдийн цайны чанар сайжирч байна

"Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд сурагчийн үдийн цайны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны газар Боловсролын ерөнхий газартай хамтран нийслэлийн сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд шаардлагатай хагас боловсруулсан хонь, үхрийн мах, хэрчиж бэлтгэсэн хүнсний ногоо, аруул, сүү, тараг, шар, цагаан будаа, луувангийн шүүс зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг цахим дэлгүүрээс захиалга хийн үдийн цай хөтөлбөрт хэрэглэж байна. 2025 онд нийт 332 төрийн

байгууллага 17 аж ахуй нэгжээс 23.5 тэрбум төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүн худалдан авчээ.

Мөн Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Увс аймгуудын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд зарим дотоодын хүнсний бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний аргаар зохион байгууллаа. Ингэснээр Дархан-Уул аймагт хагас боловсруулсан хонь, үхрийн махыг сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд бэлтгэн нийлүүлэхэд хялбар боллоо.



Б.САРУУЛ
/МҮХАУТ-ын Ерөнхий
нарийн бичгийн дарга/

"Хүнсний хувьсгал"-ын хүрээнд улс орнуудтай туршлага солилцох аялал зохион байгуулсан

2025 онд МҮХАУТ нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн төрийн айлчлалын хүрээнд Турк, Чех, Польш, Тажикистан, Киргизстан, Энэтхэг, Итали зэрэг улсуудад өндөр хэмжээний бизнес форум болон Бизнес турыг зохион байгуулсан бөгөөд "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд тухайн улс бүрд голлох хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэрүүдтэй танилцах, туршлага

солилцох аялал зохион байгууллаа.

Эдгээр гадаад форумд нийт 600 гаруй бизнес эрхлэгч оролцож түншийн харилцаа тогтоох, зах зээл судлах, туршлага солилцох зэргээр хамтын ажиллагааны хүрээгээ тэлсэн байна. Түүнчлэн гадаад чуулган, үзэсгэлэнд 1200 орчим төлөөлөгч оролцож, дотоодод зохион байгуулсан бизнес уулзалт, арга хэмжээнд 1800 гаруй төлөөлөгч оролцсон байна.



Б.БАТЖАРГАЛ

/Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/

“Хүнсний хувьсгал” ажилтнуудын нийгмийн хамгааллыг хангах том хөтөлбөр болсон

Нийгмийн даатгалын байгууллагат тайлангаа өгч хамтран оролцдог 63 мянган ажил олгогч байдаг. “Хүнсний хувьсгал” хөтөлбөр үйлдвэрлэлийг дэмжсэнээр ажлын байрыг бий болгож байна. Энэ нь манай нийгмийн даатгалын тогтолцоонд маш ач холбогдолтой ажил болж байна. Нэгдүгээрт, нийгмийн даатгалд даатгуулагчийн тоог өсгөж байна. Хоёрдугаарт, найдвартай ажлын байр бий болгосон. Ингэснээр цалин хөлс тогтмол тавигдаж, нийгмийн даатгал тогтмол төлөгдөж байна. Энэ нь эргээд ажилтнуудын нийгмийн хамгааллыг хангах

том хөтөлбөр болж уялдаж байгаа юм.

Аль болох Монголдоо бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь импортоос хэт хараат байдлаасаа гарах, импортын гаралтай инфляцыг бууруулахад нөлөө үзүүлэх ёстой. Нөгөө талдаа даатгуулагчид, тэтгэвэр авагчдад маш том дэмжлэг болж байна. Тогтвортой бодлого бэхжих тусам нийгмийн даатгал төлөгчдийн бааз, суурь нэмэгдэх чиг хандлагатай болж байна. Энэ нь нийгмийн даатгалын тогтолцоонд маш их ач холбогдолтой.



Б.БАТЦЭЦЭГ

/Хүнсний хувьсгал мэргэжлийн холбооны Гүйцэтгэх захирал/

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулахаар хамтран ажиллаж байна

“Хүнсний хувьсгал” мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн гишүүдийн X хуралдаан 12 дугаар сард болсон. Энэ хурлаараа бид төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, дэмжигч байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, салбарын эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлыг онцлон хэлэлцэж, 2026 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө,

санхүүгийн тайланг хэлэлцэж баталсан. Цаашид хамтран ажиллах Удирдах зөвлөлд хүнс, хөдөө аж ахуйн салбарын 45 төлөөллүүд багтаж, “Хүнсний хувьсгал” болон өрнөж буй “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний үр дүнг эрчимжүүлэх болон хэрэгжилтэд санал хүсэлтээ илэрхийлсэн.



А.БАКЕЙ

/Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич, Эрдэмтдийн зөвлөлийн гишүүн/

“Хүнсний хувьсгал” хөдөлгөөн зөв чиглэл рүү явж байгаа

Хүнсний хангамж, аюулгүй байдал дэлхий дахины асуудал болсон. Манай орны хувьд бүр илүү ач холбогдолтой. Яагаад гэвэл нэг талаар уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай хөдөө аж ахуй тэр дотроо газар тариалангийн салбарын эрсдэл эмзэг байдал улам нэмэгдэж байгаа. Хүнсний хэрэгцээг дотооддоо хангах боломж бас хэцүү болж байна. Нөгөө талаараа геополитиктой холбоотойгоор импортоор хүнсээ авна гэдэг дээр найдах аргагүй болсон. Үүнтэй

холбоотой Монгол Улсын Ерөнхийлөгч “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн санаачилж, УИХ-ын 36-р тогтоол гарсан. Энэ тогтоолын дагуу бодлого, эрх зүйн дэмжлэгийн хувьд олон зүйл хийж байгаа. Зөв чиглэл рүү явж байгаа ажил. Мах, сүү, үр тариа, төмс хүнсний ногоо зэрэг гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо хангах чадавхаа бэхжүүлэх, түүнийгээ тогтвортой авч явах нь хамгийн чухал. Зохих хэмжээний төрийн дэмжлэг нөлөө үзүүлж байна.



Б.БОЛДБААТАР
/Монголын сав, баглаа, боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо" ТББ-ын тэргүүн /

Шинээр 16 нэр төрлийн сав, баглаа боодол үйлдвэрлэсэн

Хүнсний хувьсгал хөтөлбөр зарлагдсанаас хойш дөрөв дэх жилийнхээ нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд үнэхээр бодит өөрчлөлтүүд гарсан. Сав баглаа боодлын салбарын аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгө 30 гаруй, борлуулалтын орлого 27-28, татвар төлөх хэмжээ 14 хувиар тус тус нэмэгдсэн зэрэг өөрчлөлт гарсан. Манай аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь эргэлтийн хөрөнгийн зээл авсан. Эргэлтийн

хөрөнгийн зээлээрээ ийм үр дүн гаргаж байна. “Об пластик” компани хөрөнгө оруулалтын зээл авсан. Тус компани 6156 м.кв ажлын байрыг шинээр бий болгож, тоног төхөөрөмжөө суурилуулсан. Монгол Улсад өмнө нь хийж байгаагүй 16 нэр төрлийн сав, баглаа боодлыг тэд энэ жил шинээр үйлдвэрлэж эхэлж байна. Ийм л бодит үр дүн гарч байна.



Ц.ГАНЗОРИГ
/Pinuta брэндийн үүсгэн байгуулагч/

Бүтээгдэхүүнээ гадаад зах зээл дээр гаргана

“Хүнсний хувьсгал” хөдөлгөөний үр нөлөөгөөр хэрэглэгчид импортын бүтээгдэхүүн бус үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээ түлхүү сонгож худалдан авалт хийх болсонд баяртай байна. Тиймээс бид цаашид дотоодын зах зээлээ хангахаас гадна экспортын бүтээгдэхүүнээ хөгжүүлж гадаад зах зээлд “Монголд үйлдвэрлэв шошготой”

бүтээгдэхүүнийг худалдаанд гаргахаар ажиллаж байна. Мөн манай компани байгаль дээрээс хуулийн дагуу түүхий эдээ бэлтгэдэг учир Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 3000 ширхэг хуш модыг Богд хан ууланд тарьж тогтмол арчлаад явж байгааг та бүхэнд дуулгахад таатай байна.



У МЁН ГЮУ
/“KORIA Mongolia” төвийн захирал/

Монголд цагаан будаа тариалах боломжтойг нотоллоо

Монгол орны хөрс нь үржил шим багатай, зуны улирал богино байдаг тул цагаан будаа тарихад тохиромжгүй гэх ойлголт олон нийтэд түгээмэл байдаг. Гэвч сүүлийн жилүүдэд монголчууд үндсэн хүнс болох мах, гурилын хэрэглээнээс аажмаар эрүүл хүнсний хэрэглээ рүү шилжиж эхэлсэнтэй холбоотойгоор будааны хэрэглээ өссөөр байна. Статистик мэдээллээр Монгол Улс жилд ойролцоогоор 53.984 тонн будаа импортолж байна. Цагаан будааны импорт нь БНХАУ зэрэг гадаад орнуудаас бүрэн хамааралтай бөгөөд ихэнх нь удаан хадгалсан, чанар нь буурсан бүтээгдэхүүн байдаг. Тиймээс Монголчуудын эрүүл

мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд Монголд дотооддоо будаа тариалах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

2023 оны өвлөөс эхлэн Монголд будаа тариалах боломжит бүс нутгийн уур амьсгал, байгаль орчны судалгааг хийсэн. Эдгээр судалгаанд тулгуурлан 2024–2025 онд Ховд аймгийн Булган суманд анхны туршилтыг амжилттай хийж, Монгол Улсын түүхэнд анх удаа дотооддоо тариалсан будааны ургац авсан нь томоохон ололт боллоо. Туршилтын явцад Монголд будаа тариалах боломжтойг нотлохын зэрэгцээ шийдвэрлэх шаардлагатай хүндрэл, бэрхшээлүүдийг тодорхойлсон.



ЖЕРЕМИ ТИЙССЭН
/Канад улсын иргэн/

Малчны хотоос шилмэл мал авч, хоол тэжээлийг нь чанаржуулсан

Манай компани “Хүнсний хувьсгал” хөтөлбөрөөс 2024 онд зээл авсан. Ингэснээр малчны хотоос шилмэл мал авч, хоол тэжээлийг нь чанаржуулан, фермийн үйл ажиллагаагаа илүү сайжруулсан. Хөдөө аж ахуйн чиглэлээр банкнаас өндөр хүүтэй зээл авах бараг боломжгүй байдаг. Тэгвэл “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүү бага учраас үйлдвэрлэл эрхлэгчдэд бодит дэмжлэг болсон юм.

Энэ бол зөв бодлого. Үүнийг цаашид

үргэлжлүүлэх хэрэгтэй байна. Дунджаар 5-8 жилд тогтвортой үргэлжилбэл, хөдөө аж ахуйн салбарт маш том ахиц гарч, үйлдвэрүүдийн ажил жигдэрч эхэлнэ. Хөдөө аж ахуйн салбарын онцлог нь 5-8 жилдээ үр ашгаа хүртдэг.

Бага хүүтэй зээл олгож, хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлснээр үйлдвэрлэл эрхлэгчид ард түмэнд эрүүл, аюулгүй хүнсийг зах зээлээс арай бага үнээр бүрэн хангах боломжтой.



З.ШАРАВ
/Баянхонгор аймгийн
“Хүнсний хувьсгал”
салбар хорооны дарга
“Баянжаргант хүнс”
ХХК-ны захирал/

Баянхонгор аймгийн мах, махан бүтээгдэхүүний 50 хувийг хангадаг

“Хүнсний хувьсгал” хөтөлбөрт маш их талархууштай байгаа. Тэр дундаа орон нутгаас хамрагдсандаа баяртай байдаг. Манай үйлдвэр долоон төрлийн хиам, найман төрлийн мах, утсан мах зэргийг үйлдвэрлэж, Баянхонгор аймгийн мах, махан бүтээгдэхүүн, хиам, утсан махны 50 хувийг хангах хүчин чадалтай бөгөөд 18 суманд бүтээгдэхүүнээ түгээж байна.

Тус хөтөлбөрөөс 500 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үхрийн фермээ өргөжүүлэн, түүхий эдийн асуудлаа шийдсэнээр бүтээгдэхүүний гарц, борлуулалт гурав дахин нэмэгдэж,

нутгийн брэнд бүтээгдэхүүн болж чадсан. Түүнчлэн малын үржилд онцгой анхаарч, үхрийнхээ угшил гарал үүслийг сайжруулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжөө бүрэн шинэчилсэн. Энэхүү хөтөлбөрийг цаашид үргэлжлээсэй гэж хүсэж байна. Ингэхдээ үйлдвэрийн онцлогоос хамаарч зээлийн хугацааг урт хугацаанд сунгаж өгвөл дотоодын үйлдвэрлэгчдэд маш их үр өгөөжтэй юм.

Бид цаашид хүний оролцоогүй ухаалаг тоног төхөөрөмжийг суурилуулан, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг дэмжсэн бүрэн шинэчлэлт хийх төлөвлөгөөтэй байна.



Б.БАЙГАЛЬМАА
/“Үлэмж бадрах
сүү” ХХК-ийн үүсгэн
байгуулагч/

Бид арилжааны банкны шаардлагыг хангаж чадахгүй байна

Манайх “Хүнсний хувьсгал”-аас 400 сая төгрөгийн зээл хүссэн боловч 150 сая төгрөгийн зээл авсан. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хэрэгцээ, хангамж, шаардлага нь тэгш бус байдаг. Арилжааны банкаар зээл дамжуулагдаж олгогдсон. Гэтэл арилжааны банк бидэнд өндөр шалгуур тавьсан. Бид дөнгөж өрхийн үйлдвэрлэлээсээ салаад жижиг, дунд үйлдвэрлэл

рүү шилжих гэж байгаа. Арилжааны банкныхаа шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй. Орон нутагт байгаа үл хөдлөхөө барьцаалахаар үнэлгээ байдаггүй. Банкнаас бидэнд маш олон төрлийн шалгуур тавьдаг. Энэ шаардлагуудаас болж хүссэн хэмжээний зээлээ авч чаддаггүй. Хөдөөд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлнэ гэдэг бол тэмцэл болж байна. Манайх сүү цагаан идээний үйлдвэрлэлээ 25 жил явуулж байна.

БАЯЛАГ БҮТЭЭГЧИД

Чинээлэг дундаж давхаргатай МОНГОЛЫН ТӨЛӨӨ...



“Баялаг бүтээгдчийг дэмжих холбоо” нь 2015 онд үйлдвэрлэл эрхлэгчдийн хүсэлт нийгмийн шаардлагаар үүсгэн байгуулагдаж, Нийслэлийн есөн дүүрэг, 21 аймагт салбар хороотой, 100 мянга гаруй идэвхтэй гишүүнтэй мэргэжлийн холбоо юм.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүд 40 гаруй удаа хуралдаж, баялаг бүтээгчдийнхээ төлөө шийдвэр гаргажээ. Энэ хугацаанд Монгол орноо хоёр удаа бүтэн тойрч, 21 аймаг, 300 гаруй сумдаар тархан үйлдвэрлэл эрхэлж буй 1000 гаруй бизнес эрхлэгчидтэй уулзаж, үйлдвэрлэл бүтээгдэхүүнийг сурталчлан таниулжээ.

Монгол орон даяар “Баялаг бүтээгч” хэмээн үндэсний үйлдвэрлэгчдийг алдаршуулж, төрд дуу хоолойгоо “хамгийн чанга-хамгийн хүчтэй”-гээр хүргэж, өдгөө арван жил тогтвортой үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд холбооны зүгээс баялаг бүтээгчдээ төлөөлж салбарын хууль журамд санал оруулж, төрийн бодлого шийдвэрт дуу хоолойгоо хүргэж иржээ. Улмаар УИХ, Засгийн газар, салбар яам, төрийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшний албан тушаалтанд санал хүргэж, төр хувийн хэвшлийн хооронд гүүр болох ажлаа тогтвортой хариуцлагатайгаар гүйцэтгэж байна.

2025 оны 11 дүгээр сард 400 гаруй баялаг бүтээгч, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид оролцсон “Mongolian SME Forum-2025” арга хэмжээг зохион байгуулсан юм. Тэд дараагийн арван жилийн алсын хараагаа “Чинээлэг дундаж давхаргатай Монголын төлөө...” хэмээн тунхаглаж “Монголын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний холбоо” болгон нэрээ өөрчилж үйл ажиллагаагаа тэлж буйгаа албан ёсоор орон даяар зарлалаа.



“Монголын Жижиг, Дунд үйлдвэрлэл, үйлчилгээний холбоо”-ны Ерөнхийлөгч Ч.Даваабаяр



ГАДААД ХАРИЛЦАА

Э.Одбаяр: 2026 онд гадаад бодлого Зүүн өмнөд Ази, булангийн орнууд руу чиглэнэ

Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх
Э.Одбаяртай ярилцлаа.

-Монгол Улс гадаад харилцааны “хөлөг” дээр идэвхтэй бөгөөд сонирхолтой нүүдлүүд хийсээр байна. Эдгээр нүүдлийн онцлог, ач холбогдлыг та хэрхэн дүгнэх вэ?

-Сүүлийн жилүүдэд дотоод, гадаадыг чиглэсэн төрийн айлчлалууд идэвхтэй, өрнүүн байна. Үүнийг монгол хүн бүр мэдэрч байгаа болов уу. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2025 онд найман улсад айлчлал хийсэн бол гадаадаас таван төрийн тэргүүн манай улсыг зорин ирлээ. Оны эхнээс бид Европын орнууд буюу гуравдагч хөрш рүү хандсан гадаад харилцааг идэвхтэй өрнүүлсэн. Нэгдүгээр сард БНТУ руу төрийн айлчлал зохион байгуулж, үндэсний хөдөлгөөнүүдийн зорилго, үнэ цэнийг таниулах алхмуудыг хийсэн. Турк улстай бид хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар ярилцсан бол гуравдугаар сард Польш, Чех улсад айлчлахдаа мөн энэ чиглэлээр хамтран ажиллах боломжтойгоо илэрхийлсэн. Айлчлал бүрээр тодорхой гэрээ хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” зэрэг үндэсний хөдөлгөөнүүд дан ганц монголчуудын хүсэл зоригоор урагшлахгүй. Тиймээс гаднын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдээр бид хүчээ зузаатгах ёстой. Энэ утгаараа төрийн айлчлал, олон улсын хурал цуглаан, арга хэмжээнд Монгол Улсын, монголчуудын хүсэл зоригийг тодоор илэрхийлж, үндэсний хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлан таниулахад онцгойлон анхаарч байна.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн айлчлал өмнөх төрийн тэргүүнүүдийн айлчлалаас олон талаараа ялгарч байгаа. Өмнөх төрийн айлчлалуудаар хөрөнгө оруулалтын орчноо танилцуулах уулзалт, форумыг чухалчилдаг байсан бол Ерөнхийлөгч У.Хүрэлсүх бизнесийн бүрэлдэхүүн, баялаг бүтээгчдийн саналын дагуу



төрийн айлчлалын үр дүн, ач холбогдлыг илүү тодотгож, зарчмын өөрчлөлт хийсэн.

Тухайлбал, айлчлалын хүрээнд уулзалт, форум хийхээс гадна тусгай үйлдвэрүүд, аж үйлдвэрийн парк, кластеруудаар танилцах аялал хийдэг болсон. Ингэснээр бизнес эрхлэгчдийн холбоо харилцаа илүү бэхжиж, бодит үр дүнд хүрэх цаг хугацааг дөтөлж чадсан. Сүүлийн гурван жилд л гэхэд 1000 гаруй баялаг бүтээгчийг төрийн айлчлалын баг бүрэлдэхүүнд хамруулсан байна. Хамгийн чухал нь, бид эргэх холбоотой байж, айлчлалын үр дүн, цаашид анхаарах зүйл зэргийг бизнес эрхлэгчдээс асууж тодруулан, хариу арга хэмжээ авахыг ямагт чухалчилдаг. Энэ бол компаниудын зорилго, алсын харааг Монголын төр эрхэмлэж хүндэтгэж буйн тод илрэл юм.

-Төв Азийг чиглэсэн гадаад бодлого сүүлийн жилүүдэд эрс идэвхжлээ. Төв Азийн улсуудаас ямар хүлээлттэй байна вэ?

-Монгол Улс бие даасан, олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого хэрэгжүүлдэг. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын тэргүүн дипломатч байдаг. Энэ утгаараа гадаад харилцааны талбарт Ерөнхийлөгч өөрөө түүчээ болж явах учиртай. 2025 онд, Төв Ази руу чиглэсэн гадаад бодлого ▶

► бүрэн бүтэн болсон. Үүнийг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

2022 онд Киргизийн Ерөнхийлөгч манай улсад айлчилсан. Киргизийн төрийн тэргүүнийг эх орондоо урьсан нь Төв Ази руу чиглэсэн гадаад бодлогын эхний нүүдэл байсан. Төв Азийг чиглэсэн гадаад бодлого үндсэндээ 20-оод жилийн турш орхигдсон. Тиймээс Киргизээр цөн түрж, Төв Азийг чиглэсэн гадаад бодлогоо сэргээсэн. Улмаар 2025 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Киргиз рүү хариу айлчлал хийлээ.

Мөн Казахстан улсын Ерөнхийлөгч есдүгээр сард манай улсад айлчилж, хоёр орны харилцааг стратегийн түншлэлийн түвшинд хүргэсэн. Энэ жил Монгол Улсын Ерөнхийлөгч Казахстан руу хариу айлчлал хийхээр бэлтгэл ажлаа базааж байна. Түүнчлэн Туркменистан, Узбекистаны төрийн тэргүүнүүд манай улсад айлчилж, Тажикистан руу төрийн айлчлалын жолоог чиглүүлсэн. Эдгээр айлчлалд бизнесийн бүрэлдэхүүнээ ч идэвхтэй оролцуулсан.

Манай бизнес эрхлэгчдийн хувьд, Казахстаны бизнес эрхлэгчидтэй харьцангуй идэвхтэй хамтын ажиллагаатай байдаг. Харин Төв Азийг чиглэсэн гадаад бодлогыг идэвхжүүлж, бүрэн бүтэн болгосны үр дүнд Киргиз улс, Тажикистан, Туркменистан, Узбекистан зэрэг улсуудаар хамтрал тэлж, харьцангуй шинэ зах зээлийн үүд хаалгыг нээж чадлаа.

Мөн бид гаднаас хөрөнгө оруулалт татахыг чухалчилдаг байсан бол манай баялаг бүтээгчид өөрсдөө Төв Азид хөрөнгө оруулж эхэллээ. 2025 онд л гэхэд, “Таван богд” компани Төв Азийн бүсэд 10-аад сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. Төв Азийг чиглэсэн гадаад бодлого бүрэн бүтэн болсноор баялаг бүтээгчдэд, нэн ялангуяа “хүнсний хувьсгал”-ын эзэд болсон аж ахуйн нэгжүүдэд ээлтэй ирээдүйг авчирна гэдэгт бид итгэж байна.

-Гадаад харилцааны ололт амжилт Төв Азиар хязгаарлагдахгүй болов уу. Италитай стратегийн түншлэл тогтоож, харилцааны түвшнийг хоёр шат ахиуллаа. Энэ түншлэлээс гарах үр дүн юу байх бол?

-Итали улсын тухайд, манай гуравдагч хөрш. Их Долоогийн бүлгийн гишүүн, дэлхийд эдийн засгаараа тэргүүлэгч орон. Тус улстай харилцаагаа хоёр шат ахиулсан нь олон талын ач холбогдолтой. Стратегийн түншлэл тогтоосон тохиолдолд улс орнууд маш өөр түвшинд яриа

хэлэлцээ өрнүүлдэг.

Бас нэг зүйлийг онцлоход, Итали бол хүнсний үйлдвэрлэлээр Европт тэргүүлдэг гурван орны нэг. Энэ утгаараа Ерөнхийлөгч “Хүнсний хувьсгал”-д хамтрахыг санал болгосон. Айлчлалын бизнес бүрэлдэхүүнд 60 гаруй компанийн төлөөлөл багтсан. Италид хүнсний салбарынхнаас гадна ноос ноолуурынхан ч том “амбиц” тээж очсон. Хүссэн зүйлээ ч олж чадсан. Бид хөнгөн үйлдвэрлэлийн нарийн технологиудыг Италиас нутагшуулж, мэдлэг үр чадвараа хуваалцаж болохоор байна. Тухайлбал, Италийн хамгийн том бяслагийн үйлдвэртэй манай бизнес эрхлэгчид танилцсан. Мөн арьс шир, ноос ноолуур боловсруулах тал дээр Италитай хамтрахаар ярилцлаа. Өмнө нь ноос ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоодууд Италитай олон жилийн турш шууд харилцаатай ажиллаж ирсэн. Үүний

ачаар италичуудын суурь ойлголт, хүлээлт харьцангуй тодорхой байсан.

Бас нэг сонирхолтой баримт дурдахад, манай улсын ноолуурын экспортын 80 хувь нь Италийг чиглэдэг. Италийн томоохон брэндүүд монгол ямааны ноолуурыг ашиглаж байна. Мөн италичууд манай улсад хамгийн хэрэгтэй байгаа ээрмэлийн үйлдвэрийг харилцан хөрөнгө оруулалт хийж, байгуулах талаар бодит

яриа хэлэлцээ өрнүүлсэн.

-2026 онд гадаад харилцааны гол нүүдэл хааш чиглэх вэ?

-Гадаад харилцаа Төв Ази, Европ руу чиглэснээс гадна Энэтхэг Номхон далай, Зүүн өмнөд Азийг чиглэсэн. Гурван жилийн өмнө манай улсын төрийн тэргүүн Лаос, Вьетнам улсад айлчилж, тус улсын төрийн тэргүүнүүд манай улсад хариу айлчилж байсныг эргэн сануулмаар байна. Цаашид Монгол Улс тэнцвэртэй, бие даасан, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлогоо үргэлжлүүлнэ. Цаг үе ч ийм зарчмаар урагшлахыг шаардаж байна. 2026 оны тухайд, гадаад бодлого Зүүн өмнөд Ази, булангийн орнууд руу чиглэнэ. Индонез, Филиппин, Тайланд, Катар, Кувейт, Саудын Араб руу төрийн айлчлалын жолоог эргүүлнэ. ■

Төв Азийг чиглэсэн гадаад бодлого идэвхжиж бүрэн бүтэн болсноор Монголын бизнес эрхлэгчдэд шинэ зах зээлийн үүд хаалга нээгдсэн

ТӨРИЙН АЙЛЧЛАЛ БА СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛ



БНЭУ 2025.10.13-16
Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Н.Моди



Туркменистан 2024.10.10-13
Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хурэлсүх Туркменистан Улсад



БНТУ 2025.01.15-19
Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоан



БНЧУ 2025.03.9-12
Бүгд Найрамдах Чех Улсын Ерөнхийлөгч П.Павел



БНПУ 2025.03.13-14
Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч А.Дуда



ОХУ 2025.05.7-9
ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин



БНКУ 2025.7.20
Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Жапаров



Тажикистан 2025.07.23-26
Бүгд Найрамдах Тажикистан Улсын Ерөнхийлөгч Э.Рахмон



Монгол-Хятад-Орос 2025.09.02
БНХАУ-ын дарга Ши Жиньпин, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин



Гэгээн Ширээт Улс 2025.12.04-05
Гэгээн Ширээт Улсын төрийн тэргүүн Пап Арвандерөвдүгээр Лео



БНИУ 2025.12.01-03
Бүгд Найрамдах Итали Улсын Ерөнхийлөгч С.Маттаралла

Туркменистан 2024.10.10-13



Хамтын ажиллагааны шинэ эхлэл

Монгол Улс, Туркменистан Улс 1992 оны дөрөвдүгээр сарын 23-ны өдөр дипломат харилцаа тогтоож байв. Түүнээс 32 жилийн дараа Монгол Улсын төрийн тэргүүний түвшинд хэрэгжиж буй анхны айлчлал гэдгээрээ онцлог байлаа.

Айлчлалын хүрээнд Монгол Улс, Туркменистан Улсын төрийн тэргүүн нар ганцаарчилсан уулзалт болон албан ёсны хэлэлцээ хийж, хоёр улсын харилцаа болон бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагаа зэрэг өргөн хүрээний асуудлаар санал солилцсон. Мөн “Монгол-Туркменистаны бизнес форум”-ыг амжилттай зохион байгуулж, хоёр орны бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчид хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан нь цаашид худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа.

Турк 2025.01.15-19



Стратегийн түншлэл

Монгол Улсын хувьд Европ, Ойрхи Дорнодыг холбох гүүр нь Турк юм. Хөнгөн үйлдвэр, барилга, хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагаа эрчимжиж байна. Соёл, түүхийн язгуур холбоотой, итгэлцэлд суурилсан түншлэл Монгол-Туркийн харилцааны онцлог юм. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Турк Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр улс Стратегийн түншлэл тогтоож, харилцааны түвшний түүхэн шинэ шатанд гаргасан. Айлчлалын хүрээнд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Засгийн газар, байгууллага хоорондын нийт 11 баримт бичигт гарын үсэг зурлаа. Ерөнхийлөгчийн Төрийн айлчлалын бүрэлдэхүүнд 100 гаруй компаниудын төлөөлөл багтсан нь бизнесийн бодит тулгууртай харилцааны баталгаа юм. Манай хоёр улс барилга, уул уурхай, хөдөө аж ахуй, хүнс, эрүүл мэндийн салбарын 100 орчим компанийн төлөөлөл оролцсон бизнес форум, гэрээ, хэлэлцээрүүдээр үргэлжилсэн. Мөн хоёр орны холбогдох яамдын удирдлагууд уулзаж, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх боломжийн талаар ярилцсан. Туркийн Худалдааны

сайд халал стандартыг маш сайн хангасан малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох, арьс шир, мал аж ауйн чиглэлээр түүхий эд бэлтгэн нийлүүлэх боломжууд мөн эдгээр салбарт хөрөнгө оруулалт татаж, хамтран ажиллах боломж нөхцөлүүдийг бүрдүүлэн ажиллах тухай ярилцсан юм. Турк улс дэд бүтэц, барилгын технологи, үйлдвэрлэлийн туршлагатай бол Монгол Улс байгалийн баялаг, түүхий эдийн нөөцөөрөө давуу. Хоёр талын бизнес эрхлэгчид харилцан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх сонирхолтой. Турк нь Монголын хувьд Европ, Ойрх Дорнодын зах зээлд нэвтрэх гарц болдог бол Монгол Туркийн компаниудад Төв Азид тэлэх боломж олгодог.

Чех 2025.03.9-12



Европын зах зээлд гарах боломж

Чех улс Монголын Европ дахь үйлдвэрлэл, технологийн чухал түнш юм. Мах, хөдөө аж ахуй, инновацын салбарт хамтрах боломж нээлттэй. Олон арван жилийн найрсаг харилцаа, хөдөлмөр эрхэлж буй монголчууд хоёр орныг ойртуулж ирсэн. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Төрийн айлчлалын үеэр уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааны түвшнийг шат ахиулж, Иж бүрэн түншлэлд хүргэж, Монголын бүтээгдэхүүнийг Европын зах зээлд гаргах бодит боломж нээгдэв. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаас гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Европын зах зээлд гаргах боломжийг эрэлхийлж, энэ чиглэлд хоёр орны хамтын ажиллагаа ийн эхэллээ. 2024 оны байдлаар хоёр орны худалдааны эргэлт 18 сая ам.доллар байна. Манай экспорт 300 гаруй мянган ам.доллар, импорт 17 сая орчим юм. Монгол, Чехийн эдийн засгийн хамтын ажиллагаа аж үйлдвэр, хөдөө аж ахуй, дэвшилтэт технологид чиглэж байна. Чех улс өндөр технологи, машин тоног төхөөрөмж, боловсруулах үйлдвэрлэлийн туршлагатай бол Монгол Улс мах, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн нөөцтэй. Европын зах зээлд гарахад Чехийн стандарт, туршлага манай улсад чухал ач холбогдолтой. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Төрийн айлчлалын ачаар Монголын бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингээж экспортлох боломж нээгдэж байна. Хоёр орны харилцааны онцлог нь удаан хугацааны найрсаг түншлэл, хөдөлмөр эрхэлж буй монгол иргэдийн гүүрэн холбоо юм. ▶

Польш 2025.03.13-14

Иж бүрэн түншлэлийн төлөө

Энэ онд Монгол Улс, Бүгд Найрамдах Польш улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой тохиож буй. Хоёр улсын найрсаг харилцаа тэртээ XIII зуунаас эхлэлтэй. Түүнчлэн 2008 онд БНПУ-ын тухайн үеийн Ерөнхийлөгч Лех Качинскийг Монгол Улсад албан ёсоор айлчлах үеэр хоёр орны Ерөнхийлөгч "Хамтарсан тунхаглал" гаргаж байсан билээ. Энэхүү тунхаглал нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд хөгжүүлэх чиг баримжаа болсон гэж үздэг. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн энэ удаагийн айлчлалын үеэр хоёр орны төрийн тэргүүн ганцаарчилсан уулзалт, албан ёсны хэлэлцээ хийсэн. Мөн хоёр улсын хамтран хэрэгжүүлэх "Иж бүрэн түншлэлийн үйл ажиллагааны 2025-2030 оны төлөвлөгөө"-г баталлаа. "Монгол Улс итгэлтэй, найдвартай, удаан хугацааны түнш" байх зарчим баримталж байгааг Ерөнхийлөгч У.Хүрэлсүх онцлоод харилцан ашигтай хамтран ажиллахыг уриалав.

2024 оны байдлаар хоёр орны худалдааны эргэлт 105 сая ам.доллар байна. Тодруулбал, манай улс нэг сая гаруй ам.долларын экспорт хийсэн бол 104 орчим сая ам.долларын бараа бүтээгдэхүүн импортолсон байна.

ОХУ 2025.05.7-9

Түүхэн, улс төрийн итгэлцлийг бэхжүүлэв

Монгол, Оросын эдийн засгийн харилцаа эрчим хүч, шатахуун, тээвэр логистик, хөдөө аж ахуйн салбарт тулгуурладаг. ОХУ нь Монголын нефть бүтээгдэхүүний гол нийлүүлэгч бөгөөд цахилгаан эрчим хүч, төмөр замын хамтын ажиллагаа стратегийн ач холбогдолтой. Монгол Улс Оросын хувьд Азийн зах зээлд хүрэх транзит орон, тээврийн чухал коридор юм. Хоёр улсын итгэлцэл, түншлэл зуу гаруй жилийн түүхтэй. Байгалийн нөөц, газарзүйн уудам орон зай, тээврийн холболт нь эдийн засгийн хамтын ажиллагааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх суурь болдог. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-д төрийн айлчлал хийж, Москва хотноо Эх орны дайны ялалтын 80 жилийн ялалтын баярт оролцсон. Энэ үеэр Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтэй албан ёсны уулзалт хийж, хоёр улсын найрамдалт, стратегийн түншлэлийн харилцааг

бататгав. Монгол Улс, Монголын ард түмэн дайны эхний өдрүүдээс эхлэн "Бүхнийг ялалтын төлөө", "Бүхнийг фронтод" хэмээх урианы дор Зөвлөлтийн Улаан армид бүх талын буцалтгүй тусламжийг хүргүүлэхийн төлөө хичээн зүтгэж байсан нь Монгол, Оросын найрамдалт харилцааны түүхэн дэх хамгийн чухал үйл явдлуудын нэг байсныг түүхийн хуудас харуулж буйг онцолж, Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн Эх орны дайны ялалтын 80 жилийн ойн ёслолын жагсаалд оролцож буйг тэмдэглэв. Мөн хоёр орны төрийн тэргүүн худалдаа, хий, тээвэр логистик, энергетик, байгаль орчин зэрэг салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Хоёр тал "Бүх талын стратегийн түншлэл"-ээ бататгах чиглэлээр бодлогоор уялдуулсан зөвлөмжүүдэд санал нэгдсэн.

Киргиз 2025.7.20

Хөдөө аж ахуйн салбарын ашигтай хамтрал

Монгол болон Киргиз улсын нүүдлийн соёл, мал аж ахуйн төстэй тогтолцоо нь хамтын харилцааны суурь болдог. Киргизтэй хамтын үйлдвэр, хүнсний нийлүүлэлт, хөдөө аж ахуйн салбарт харилцан ашигтай, бодит хамтын ажиллагаа эхэлж байна. Учир нь төрийн айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Жапаров нар "Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс хооронд Иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал"-д гарын үсэг зурсан. Киргиз Улстай иж бүрэн түншлэл тогтоосон нь Монголын Төв Азийн бодлогын чухал амжилт байв. Айлчлалын хүрээнд Монгол, Киргизийн бизнес форум болж, хоёр орны төр, засгийн байгууллагууд, бизнесийн төлөөлөл, хөрөнгө оруулагчид оролцлоо. Энэ үеэр хүнс, хөдөө аж ахуй, ноос ноолуурын хамтарсан үйлдвэр байгуулах асуудал ч яригдсан. Мөн Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод", "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Киргизтэй хамтран хүнсний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангаж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Киргиз нь Төв Азийн зах зээлд гарах суваг, Монгол нь түүхий эдийн нөөцөөрөө харилцан ашигтай. Хүнсний нийлүүлэлтийн тогтвортой байдал, хамтарсан боловсруулах үйлдвэр нь хоёр орны ирээдүйн гол чиглэл гэдгийг айлчлалын үеэр талууд онцолж байлаа. ▶

Тажикистан 2025.07.23-26



Хамтарсан үйлдвэр байгуулах боломж

Монгол, Тажикистаны эдийн засгийн хамтын ажиллагаа харьцангуй шинэ боловч хөдөө аж ахуй, ургамал тариалан, усалгааны систем, хүнсний аюулгүй байдалд төвлөрөх боломжтой. Ерөнхийлөгчийн Тажикистанд хийсэн айлчлал хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах шинэ чиглэлийг нээв. “Найрсаг харилцаа, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улсын Хамтарсан мэдэгдэл”-д Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, БНТУ-ын Ерөнхийлөгч Эмомали Рахмон нар гарын үсэг зурсан. Тажикистан усалгаатай газар тариалан, усны нөөцөөр давуу бол Монгол Улс мал аж ахуй, түүхий эдийн арвин нөөцтэй. Ерөнхийлөгчийн айлчлалын үр дүнд манай улс Тажикистантай ургамал, усалгаатай газар тариалан, мал аж ахуйн технологийн солилцоо хийх боломж нээгдэж байна. Мөн Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд хамтран ажиллахаар болсон бол хоёр орны 150 гаруй бизнес эрхлэгч, баялаг бүтээгч хөрөнгө оруулалт, худалдаа, хүнс, хөдөө аж ахуй зэрэг салбарт харилцан бие биенээ ашигтай хамтрах боломж эрэлхийлэн, хамтын ажиллагааны эхлэлийг тавилаа. Хоёр улс технологи, туршлага солилцож, хамтарсан үйлдвэр байгуулах сонирхолтой. Газарзүйн өөр орчин нь харилцан нөхөх боломж олгож, бүс нутгийн хүнсний нийлүүлэлтийг тогтвортой болгоход чухал хувь нэмэр оруулах чадвартай. Төрийн айлчлалын хүрээнд Душанбе хотноо анх удаа “Тажикистан-Монголын бизнес форум” зохион байгууллаа. Форумгаар худалдааны эргэлтийг эрс нэмэгдүүлэх, учирч буй саад бэрхшээлийг арилгах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, авто болон агаарын тээврийн чиглэл бий болгох зэргийг хэлэлцсэн.

Монгол-Хятад-Орос 2025.09.02

Гурван улсын эдийн засгийн коридор

Монгол Улс мөнхийн хоёр хөрштэй. Харин мөнхийн хоёр хөрш болох ОХУ, Хятад бол дэлхийн “аварга” гүрнүүд” билээ. Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг гэсэн ардын сургамж үгийг бид ямагт санаж

хоёр хөрш улстайгаа найрсаг харилцаатай, бүх талаар хамтарч ажилладаг байх нь Монгол Улс энх тайвнаар оршин тогтнох чухал нөхцөл юм. Гурван улсын төрийн тэргүүн нар 2025 оны есдүгээр сарын 2-ны өдөр БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо уулзлаа. Уг уулзалтаар Монгол Улс бүс нутгийн тээвэр, эрчим хүчний зангилаа болох стратегийн байр сууриа баталгаажуулж эдийн засгийн коридорыг 2031 он хүртэл сунгаж, байгалийн хийн хоолойн төслийг эцэслэв. Монгол, Хятад, Оросын гурван талт эдийн засгийн хамтын ажиллагаа тээвэр, логистик, эрчим хүч, худалдаанд чиглэдэг. Монгол Улс газарзүйн байршлынхаа ачаар транзит, эдийн засгийн коридорын гол зангилаа болдог. Хятад зах зээл, Орос эрчим хүч, Монгол холбогч орон гэсэн харилцан нөхөх бүтэцтэй. Байгалийн хий, төмөр зам, авто тээврийн төслүүд гурван талд ашигтай юм. Энэ хамтын ажиллагаа нь Монголын бүс нутгийн стратегийн үнэ цэнийг өсгөж, эдийн засгийн оролцоог нь нэмэгдүүлдэг.

Энэтхэг 2025.10.13-16



Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтдаа

Энэтхэг улс бол манай гуравдагч хөрш, эдийн засгаа төрөлжүүлэх чухал түнш билээ. Монгол, Энэтхэгийн эдийн засгийн хамтын ажиллагаа уул уурхай, сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи, хүнсний салбарт өргөжиж байна. Энэтхэг асар том зах зээл, технологийн чадавхтай бол Монгол Улс байгалийн баялаг, хөдөө аж ахуйн нөөцтэй. АйТи, стартап, эм үйлдвэрлэл, боловсролын салбарт хамтрах боломж өндөр. Хоёр орны харилцааны онцлог нь ардчиллын нийтлэг үнэт зүйл, зөөлөн хүч, соёлын харилцаанд тулгуурласан урт хугацааны түншлэл юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Энэтхэг Улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд Ерөнхий сайд Нарендра Модитой “Хайдарабад” ордны цэцэрлэгт хүрээлэнд хоёр ард түмний найрамдал, нөхөрлөлийг бэлгэдэн дурсгалын мод тариалаа. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Ерөнхий сайд Н.Моди нарын тарьсан мод эх дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн хамтын хүчин чармайлтын илэрхийлэл боллоо гэж талууд үзсэн юм. Айлчлалын хүрээнд Шинэ Дели хотноо зохион байгуулсан “Энэтхэг-Монголын бизнес форум”-д хоёр орны төр, засгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, 150 ▶

▶ гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон. Энэхүү форум нь хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи, аялал жуулчлал, хүнсний үйлдвэрлэл зэрэг Монгол Улсын хурдацтай хөгжиж буй салбарын ашиглагдаагүй боломжуудыг судлах зорилготой.

Хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа сүүлийн жилүүдэд нэмэгдэж, 2024 оны байдлаар 110 гаруй сая ам.долларт хүрч, ногоон хөгжил, бизнесийн хамтын ажиллагаа тэлж байна. Энэтхэгт мал, амьтны үс, хялгас, хонины ноос, хийн буюу цахилгаан биш моторт багаж зэргийг нийлүүлж, харин хүнс, гэр ахуйн бараа, протез, химийн задлан шинжилгээ хийх аппарат, өргөгч, ачигч, вааран эдлэл, оёмол бүтээгдэхүүн голлон авч байна.

Итали 2025.12.01-03



Илүү сайн амьдралын төлөөх стратегийн түншлэл

Монгол Улс Итали Улсыг гуравдагч хөрш, Европ дахь дотнын итгэлт түнш хэмээн үздэг бол Монгол, Италийн эдийн засгийн хамтын ажиллагаа ноолуур, хувцас загвар, хөнгөн үйлдвэр, хүнсний салбарт төвлөрдөг. Европын өндөр стандарттай зах зээлд Монголын бүтээгдэхүүнийг гаргах гол гүүр нь Итали болж чадна. Хоёр улс тогтвортой үйлдвэрлэл, нэмүү өртөг шингээсэн экспортод анхаарч байна.

Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр найрсаг харилцаа, хамтын ажиллагааны түвшнийг хоёр шатаар ахиулж “Стратегийн түншлэл”-д хүргэсэн нь харилцаа, хамтын ажиллагаанд онцгой ач холбогдол өгч байгаагийн илрэл гэдэгт төрийн тэргүүн нар санал нэгдлээ. Итали Улстай стратегийн түншлэл тогтоосон нь Монголын Европ дахь байр суурийг бататгахаас гадна Европын өндөр стандарттай зах зээлд гарах боломж олгож байна. Соёл, түүхийг хүндэтгэдэг уламжлал нь хоёр улсын харилцааг итгэлцэлд суурилсан стратегийн түншлэл болгож байна. Манай хоёр улсын хооронд орчин цагийн дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ой энэ онд тохиож байна. Айлчлалын үеэр Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Ерөнхий захирал Др.Чю Донгиубараалхсан. У.Хүрэлсүх гус байгууллагын хүндэт зочны дэвтэрт “Нүүдлийн соёл, иргэншил, бэлчээрийн мал аж ахуйтай Монгол Улс бэлчээрийн менежмент, хөрс, усны нөөцийг хамгаалах, хүнсний

тогтвортой бүтээмжийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр улам өргөн хүрээнд хамтран ажиллахын төлөө байна. Монгол Улсын санаачилсан “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил”-ийн хүрээнд дэлхий нийтийн эрх ашиг, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, бодит үр дүнд хүрэх олон ажлыг хамтран хийхдээ таатай байх болно. Та бүхний “Илүү сайн үйлдвэрлэл, илүү сайн шим тэжээл, илүү сайн орчин, илүү сайн амьдрал” гэсэн зорилго бүрэн биелж, хүн төрөлхтөн эрүүл, аюулгүй орчинд аз жаргалтай, сэтгэл хангалуун амьдрах болтугай” хэмээн бичиж үлдээлээ. АНУ-ын Нью-Йорк хотноо 2022 онд болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулга уулзалтын үеэр Монгол Улсын санаачилгаар 2026 оныг “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил” болгож, манай улс Удирдах хорооны даргаар ажиллаж байна.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Итали Улсад хийсэн төрийн айлчлалынхаа үеэр Ром хотноо болсон “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил”-ийн нээлтэд оролцсон. Ерөнхийлөгчийн төрийн айлчлал нь хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойн хүрээнд мөн төрийн тэргүүний түвшинд 14 жилийн дараа болж байгаа гэдгээрээ онцлог байлаа.

Ухаалгаар байрласан улс:

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2025 онд найман улсад төрийн айлчлал хийжээ. 2025 оны айлчлалуудыг өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад ололт, амжилтаа бататгаж, харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг тэлж, улам өргөжүүлэн хөгжүүлсэн, гадаад харилцааны тэнцвэртэй бодлогыг хангасан жил боллоо. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн дэлхийн улс орнуудад хийж буй төрийн айлчлалууд нь гадаад бодлогыг эдийн засгийн бодит үр ашигтай уялдуулж, Монгол Улсыг бүс нутаг, тив дамнасан түншлэлүүдийн идэвхтэй оролцогч болгож чадсан стратегийн ач холбогдолтой үйл явдлууд байлаа.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2025 оны айлчлалууд нь улс төрийн бэлгэдлээс илүү худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарт чиглэсэн бодит агуулгатай байж чадлаа. Мөн Монгол Улс “ухаалгаар байрласан улс” гэдгээ харуулсан төрийн айлчлалуудыг Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хийсэн байна гэж үзэх үндэслэлтэй юм. ■

БОДЛОГО, СТРАТЕГИ

О.Нямсүрэн: “Хүнсний хувьсгал” бол Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлд тулгуурласан бодлогын бодит үр дүн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хүнсний төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга, доктор, дэд профессор О.Нямсүрэнтэй ярилцлаа.

“Хүнсний хувьсгал”-ыг амжилттай хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бодлогын түвшинд хэрхэн зохион байгуулж байна вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн улс орон даяар амжилттай хэрэгжиж байна. Бодлогын хэрэгжилтийн уялдааг хангах зорилгоор Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хүнсний төсөл, хөтөлбөрийн алба болон холбогдох ажлын хэсэг “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн явцыг тогтмол хэлэлцэж байна. Энэ хүрээнд холбогдох төрийн байгууллагуудад бодлогын зөвлөмж, чиглэл өгч, хамтын ажиллагааг системтэйгээр зохион байгуулж байгаа нь салбар хоорондын уялдааг хангах чухал механизм болж байна. Мөн шинжлэх ухаан, технологид суурилсан бодлогын дэмжлэг үзүүлэх зорилготой “Эрдэмтдийн зөвлөл” идэвхтэй ажиллаж байна. Түүнчлэн хүнс, хөдөө аж ахуйн салбарын үндэсний үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоод нэгдэн “Хүнсний хувьсгал” НҮТББ-ыг байгуулж, бодлого, үйлдвэрлэл, олон нийтийн уялдааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Ийнхүү “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь төрийн оновчтой бодлого, нийгэмд тэгш хүртээмжтэй дэмжлэг, хувийн хэвшил, иргэдийн идэвхтэй оролцоо нэгдсэн тохиолдолд бодит үр дүнд хүрч болдгийг харуулсан төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийн жишиг загвар болж байна.

Та энэхүү үндэсний хөдөлгөөнийг хэрхэн дүгнэж байна вэ?



Төрийн бодлого, хувийн хэвшил, иргэдийн оролцоо, шинжлэх ухааны дэмжлэг уялдсан тохиолдолд бодит үр дүн гарч болдгийг энэхүү үндэсний хөдөлгөөн тодорхой харуулж байна. Хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлогыг нэг удаагийн төсөл, арга хэмжээ гэж бус, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн стратеги болгон тогтвортой хэрэгжүүлэх нь чухал юм. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг Монгол Улсын бодит нөхцөлд нутагшуулан хэрэгжүүлж буй үндэсний хэмжээний шилдэг жишиг бөгөөд эдийн засгийн өсөлт, нийгмийн эрүүл мэнд, тогтвортой хөгжлийг цогцоор нь дэмжсэн бодлогын манлайлал гэж дүгнэж болно.

Цаашдын стратегийг хэрхэн харж байна вэ?

Хүнсний аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын түвшинд авч үзэн, хууль эрх зүй, мэдээллийн дэд бүтэц, олон улсын хамтын ажиллагааг цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд олон улсын стандартуудыг үндэсний хууль тогтоомжид үе шаттай шингээж, экспорт, импортын зохицуулалтыг шинэчлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлээс хэрэглээ хүртэлх мэдээллийг нэгтгэсэн нэгдсэн дата платформ, гарал үүслийн мөшгөх системийг нэвтрүүлэх нь нэн чухал юм. Мөн дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн сургалтын байгууллагууд олон улсын стандартын дагуу сургалтын хөтөлбөрөө хөгжүүлж, чанарын баталгаажуулалтыг хангах шаардлагатай байгааг холбогдох статистик, судалгаанууд тодорхой харуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн институтын зүгээс “Ерөнхийлөгчийн илгээлт-2100” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, өндөр хөгжилтэй улс орнуудад оюутан залуусыг сургах замаар олон улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх асуудлыг бодлогын тэргүүлэх чиглэлд авч үзэн, онцгой анхаарал хандуулж байна. ■

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

Чинюнь Дяо: Бид "Хүнсний хувьсгал"-ын зорилгыг бүрэн дэмжиж ажиллаж байгаа

Монгол дахь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Суурин төлөөлөгч хатагтай Чинюнь Дяотай ярилцлаа.

-Юуны өмнө хүнсний баталгаат байдал, ойлголт, үзэл баримтлалын талаар товч дурдана уу?

-Дэлхийн II дайны дараа хүн төрөлхтөний өмнө тулгараад байсан өлсгөлөн, хүнсний хомсдолын асуудлыг шийдвэрлэхийн тулд шинээр байгуулсан Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага дэлхий дахинд хүнсний хангалттай нийлүүлэлт, үйлдвэрлэлийг дэмжихэд гол анхаарлаа хандуулж байв.

2000 оноос хойш хүнсний баталгаат байдлын тухай ойлголт, мэдлэг улам гүнзгийрч хангамж, хүртээмж, хэрэглээ болон тогтвортой байдал гэсэн дөрвөн үндсэн хэмжээсийг энэхүү үзэл баримтлалд багтаасан. Тодруулбал, нийгэм-эдийн засаг, агро-хүрээлэн буй орчин зэрэг олон хүчин зүйлээс хамаарах улсын түвшний хүнсний хангамж, өрх гэрийн хүнсний хүртээмж, хувь хүний хүнсний хэрэглээ болон хүнсний нийлүүлэлтийн тасалдалгүй байдал гэсэн дөрвөн тулгуур үзүүлэлтийг харгалзаж хүнсний баталгаат байдал хангагдсан эсэхийг тодорхойлно гэж ойлгож болох юм.

Өрх гэр, хувь хүний түвшинд хүнс, шим тэжээлийн баталгаат байдлыг тодорхойлох нь энэ асуудлыг илүү бодитой ойлгож зөв бодлого, арга хэмжээ авахад ач холбогдолтойг ухаарах нь чухал юм. Нэмж хэлэхэд, сүүлийн жилүүдэд дээр дурдсан дөрвөн тулгуур үзүүлэлт дээр уур амьсгалын өөрчлөлт, хүнсний бие даасан байдал, байгаль орчныг доройтуулахгүйгээр хүнсний үйлдвэрлэлийг урт хугацаанд эрхлэх болон хүнсний тогтолцооны сөрөн тэсвэрлэх байдал зэргийг хүнсний баталгаат байдлын ойлголтод авч үздэг болсон.



Эндээс, тухайн улсад хүнсний баталгаат байдал хангагдаж байгаа эсэхэд нэг хоёр өгүүлбэрээр хариулт өгөх нь учир дутагдалтай гэдэг нь харагдах байх. Аливаа улсын хүнс, шим тэжээлийн баталгаат байдлыг хангах бодлогын цөм нь хүн төрсөн цагаасаа бие махбодынхоо хэрэгцээнд нийцсэн тэжээллэг, чанарын баталгаатай хоол хүнс хэрэглэх боломжоор хангагдаж үр дүнд нь эрүүл саруул өсөж бойжин, сурч, хөдөлмөрлөх өндөр чадвартай, бүтээмжтэй байж, урт бөгөөд чанартай амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн байх нь чухал. Энэ нь олон салбарын хамтын хүчин чармайлт гэдэг нь харагдаж байна.

-Монгол Улсын хүнсний баталгаат байдлын өнөөгийн нөхцөл байдлыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын зүгээс хэрхэн үнэлж байна вэ?

-Өнөөгийн байдлаар Монгол Улсын хүнсний баталгаат байдал, түүний шалгуурууд болох хүнсний хангамж, хүртээмж, хэрэглээ, тогтвортой байдлын хүрээнд анхаарах асуудлууд байна. Тухайлбал, улс орны хэмжээнд олон төрлийн хүнсний хангамж, хүнсээр дамжуулан хүртэх шимт бодис, тэр дундаа бичил тэжээлийн хангамж ямар түвшинд байгааг одоогийн дата мэдээллээс үнэлэх боломжгүй юм. Хүн амын шим тэжээлийн доройтлыг сайжруулахад чиглүүлэн хүнсний нэр төрлийг хүнсний хангамжийн байдлыг тодорхойлох, хүнсний бүлгийн жагсаалтад түлхүү оруулах нь зүйтэй харагдаж байна.

Өөр нэг асуудал нь, Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдалд таван жил тутамд хийдэг судалгааны сүүлийн дүнг харахад, хүн амын дунд бичил тэжээлийн дутлын тархалт 2017 оны түвшнээс буураагүй, илүүдэл жин, таргалалт хүн амын дунд нэмэгдсэн. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн дунд өсөлт хоцролтын тархалт үндэсний түвшинд өссөн байна. Хүмүүс хоол тэжээлээс авах шимт бодисыг зохистой хэмжээнд авахгүй байгаа нь эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх ▶

▶ төдийгүй улс орны эдийн засагт ч хортой. Энэ судалгааг Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын ажиллагаагаар 1990-ээд оноос хийж ирсэн нь сайшаалтай. Гэхдээ энэ судалгаагаар гарч байгаа дүнгүүдэд анхааран, байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй сайжруулахад Засгийн газар манлайлан ажиллаж бүх талын хамтын ажиллагааг урт хугацааны тодорхой төлөвлөгөөтэйгөөр тогтвортой бий болгож, санхүүгийн найдвартай эх үүсвэрээр хангаж байж үр дүнд хүрнэ.

-Танай байгууллагаас “Хүнсний Хувьсгал”-ын хүрээнд Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

-Хүнс, хөдөө аж ахуй нь уул уурхайн дараа орох стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн хоёр дахь том салбар. Тус салбарын цаашдын амжилт, бүтэлгүйтэл аль аль нь бусад салбарын ахиц дэвшилд шийдвэрлэх нөлөө үзүүлнэ. Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь үнэхээрийн чухал. Монгол Улсын газар зүйн байршил нь худалдаа, экспортын олон сорилтыг үүсгэдэг.

Бараа бүтээгдэхүүний олон улсын тээврийн зардал өндөр, худалдааны логистикийн гүйцэтгэлийн хугацаа урт зэрэг тулгамдсан олон асуудал байна. Мах, сүү, ноос, ноолуур, арьс, шир зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын өртгийн сүлжээ сул хөгжилд “Хүнсний хувьсгал” болон “Цагаан алт” зэрэг бусад хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагаа чиглэж байгааг бүрэн дэмжиж ажиллаж байна.

Бид үйлдвэрлэгч, судлаачид зэрэг холбогдох талуудтай ингэний сүү, дотор мах болон хар ямааны өөрийн өвөрмөц шинж бүхий ноолуур зэрэг бүтээгдэхүүний өртгийн сүлжээг, экспортлох боломжтой бүтээгдэхүүн хөгжүүлэхэд хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна. Түүнчлэн, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйн хөгжлийг дэмжиж “Венло” загварын гидропоник тариалалтын технологи бүхий хоёр хүлэмжийг Төв, Дархан-Уул аймагт төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд байгуулахад амжилттай хамтран ажиллалаа. Ингэснээр жилийн турш шинэ ногоо тариалах боломжтой болж, орон нутгийн

аж ахуй эрхлэгчдийн орлого нэмэгдэхийн сацуу хүнсний ногооны хангамж ч мөн дээшилж байна.

Түүнчлэн, бидний хэрэгжүүлсэн мал үржлийн зохиомол хээлтүүлгийн ажлын дүнд 600 гаруй өрхийн орлого, үйлдвэрлэлийн чадавхыг сайжруулсан. Мөн сүүний фермерийн инкубатор хөтөлбөр нь залуу фермерүүдийн бизнесийн ур чадварыг дээшлүүлж байгаа зэрэг олон ажлыг дурдаж болно.

-НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага дэлхийн хэмжээнд хүнсний тогтвортой системийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, санаачилгуудаас Монгол Улсад хамгийн тохиромжтой, үр дүнтэй гэж үзэж болох ямар ажил байна вэ?

-ХХААБ нь хүнсний тогтвортой тогтолцоог хөгжүүлэхэд дэлхий дахинд манлайлан бодлого, стратегийн боловсруулах, хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, “Парисын хэлэлцээр”-ийн зорилгод хүрэхэд дэмжих зэргээр улс орнуудын Засгийн газартай хамтран ажиллаж байна. Мөн Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн төлөв байдал” (State of Food and agriculture), “Хүнсний аюулгүй байдал ба шим тэжээлийн төлөв” (State of Food insecurity) зэрэг гол тайлангуудыг гаргадаг. Мөн хүнс, хөдөө аж ахуйн талаарх дэлхийн хамгийн өргөн мэдээллийн бааз (FAOSTAT)-ыг ажиллуулж байна.

Монгол Улсад хүнсний тогтвортой тогтолцоог бүрдүүлэхэд нөхцөл байдлын товч дүн шинжилгээг манай байгууллага хийсэн. Мөн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж зөвлөмжийг гаргасан. Уг зөвлөмжид тусгасан ажлуудыг бид төслүүдээр дамжуулан хэрэгжүүлж байна. Үүнтэй холбогдуулж хэлэхэд, Монгол Улсад хөдөөгийн хүн амын нийт орлогын 70 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуй тэдний амьжиргаа, хүнс, шим тэжээлийн байдалд гол тулгуур болж байна. Сүүлийн 35 жилийн хугацаанд мал сүргийн тоо толгой дор хаяж гурав дахин нэмэгдсэн. Энэ нь нийт бэлчээр талхлагдаж доройтох гол нөхцөл болж байна. Иймээс мал аж ахуйг эрхлэх арга барилдаа анхаарах зайлшгүй шаардлага үүсэхийн зэрэгцээ малчдын дийлэнх нь амьжиргааны хувьд тун эмзэг байгаа тул бидний ажил үүнд нэлээн чиглэж байгаа. ■

СУДЛААЧ

М.Пүрэвжав: Монгол Улс 35 жил хүнсээ судалж, шинжлээгүй орхигдуулж ирсэн

ШУТИС-ийн харьяа Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн захирал, эрдэмтдийн зөвлөлийн гишүүн, доктор, дэд профессор М.Пүрэвжавтай Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын талаар ярилцлаа.

-УИХ-ын 36-р тогтоолоор Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулагдсан. Та бүхний судалгаа, шинжилгээний ажил хэрхэн явж байгаа вэ?

-Ерөнхийлөгчийн У.Хүрэлсүхийн “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, УИХ-ын 36-р тогтоолд Монгол Улс Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнтэй болох ёстой гэдгийг заасан. Социализмын нийгмийн үед Хүнсний эрдэм шинжилгээ зураг төслийн институт гэж улсын хэмжээний хүнсний салбарын судалгаа, шинжилгээний байгууллагатай байсан. Тэгээд 1990-ээд оны эхээр хувьчлагдсан. Ийнхүү 30 шахам жил Монгол Улс хүнсний чиглэлээр ямар нэгэн эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулдаг бодлогын байгууллагагүй байсаар ирсэн. Иргэд өнөөдөр хоол хүнсний шошгын мэдээллийг төдийлөн сайн мэдэхгүй учраас ашиглаж чадахгүй байна. Манай хүнс үйлдвэрлэгчид бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх, бүтээгдэхүүн дээрээ шошгын мэдээлэл тавих, стандартын холбогдох тохирлууд авах, технологийн үед зөв боловсруулж байна уу, шим тэжээлийн алдагдал болон амт, өнгө үзэмжийн асуудал ямар байна вэ зэрэг бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн асуудлаар хамтарч ажилладаг шинжлэх ухааны байгууллага Монголд байхгүй. Тиймээс манай хүнс үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ холбогдох шинжилгээг урд хөрш рүү явуулж байна. Герман, Солонгос руу явуулж байна. Аливаа хүнсийг хил гаалиар нэвтрүүлэхдээ асар өндөр шалгалтын дор хийдэг. Хоёрдугаарт, гадаад улс орнуудад энэ шинжилгээнүүдийг хийлгэхэд маш



өндөр зардлыг манай хүнс үйлдвэрлэгчид зарцуулдаг. Энэ асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байсан. Тиймээс манай Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн энэ тал дээр өндөр хариуцлагатай ажиллах ёстой юм. Улсын хэмжээнд хүнсний эрдэм шинжилгээний судалгааны байгууллагагүй улс орон гэж хаана байх вэ дээ. Дэлхий дээр байхгүй үзэгдэл. Тиймээс Монгол Улсын иргэд ямар найрлагатай хүнс, хоол хэрэглэхээ мэдэхгүй, хоол хүнсний талаар мэдлэг хомс байна шүү дээ. Манай Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн 2024 оны тавдугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор ШУТИС-ийн харьяанд байгуулагдсан ч 2025 оны улсын төсөвт санхүүжилт нь тусгагдаж, 2025 оны гуравдугаар сараас үйл ажиллагаа жигдэрсэн.

-Танай хүрээлэн одоо ямар судалгаан дээр ажиллаж байгаа вэ?

-Бид одоо хүнсний бүтээгдэхүүний найрлага, физик реологийн шинжилгээний арга зүйг нутагшуулах болон бодлогын судалгаан дээр ажиллаж байна. Ер нь эхлэл төдий ажлууд явж байна. Бид өнөөдөр хүнсний бүтээгдэхүүний өндөр мэдрэмжит ▶

► багажит анализын шинжилгээг нэвтрүүлэх, зөвшөөрөгдсөн арга зүйгээр баталгаатай үр дүн гаргадаг, түүндээ дүгнэлт өгдөг байх шаардлагатай байгаа. Ийм байж гэмээнэ хүнс, хоол үйлдвэрлэгчдийн хэрэгцээг хангахаас гадна нийгмийн эрүүл мэндийг сайжруулах болно. Одоогийн байдлаар хүнсний найрлагын бүх шинжилгээ, үндсэн шим тэжээлийн бодис уураг, нүүрс ус, амин дэм, эрдэс бодис, биологийн идэвхт бодисын шинжилгээ, түүнчлэн тосны хүчил, амин хүчил, транс тосны агууламж гээд олон шинжилгээг нэг дор хийдэг эрдэм шинжилгээний лаборатори байхгүй. Эдгээрийн шинжилгээ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн явцад ч шаардлагатай байдаг. Тухайлбал, шим тэжээлийн бодис хадгалалт, боловсруулалтын явцад ямар өөрчлөлтөд орж байгааг судлах ёстой. Дээр нь хүнсний физик реологи, молекул биологийн судалгаа чухал юм. Тиймээс Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн энэ бүхнийг хийх ёстой. Их олон ажил хүлээж байна даа. Ер нь бол “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжсэнээр манай хүрээлэн байгуулагдсан гэж хэлж болно. Энэ хөдөлгөөний гол агуулга бол ард түмэнтэйгээ хамтраад өнөөдөр болтол хийж чадаагүй зүйлээ илүү эрч хүчтэй нөхөж хийх гэсэн санаа шүү дээ.

-Цаашдын хийх ажлын төлөвлөгөө юу байгаа вэ?

-Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн маш өндөр түвшний судалгаа хийдэг хүрээлэн болж өсөх ёстой. Гадаад харилцааг өндөр түвшинд хөгжүүлэх шаардлагатай байна. Хүн амын дунд өвчлөл нэмэгдсэнээр өдөр тутмын хоол хүнсний хэрэглээ чухлаар тавигдахын зэрэгцээ хүн бүр анхаарал хандуулдаг болсон. Үнэн зөв мэдээлэл шаардлагатай байна. Хүмүүс тосонд шарсан хүнсний бүтээгдэхүүн муу л гэдэг. Гэтэл идэж болно. Гол нь тос удаан хугацаанд халуун өндөр температурт хайрагдаж, нөгөө айхтар өвчин үүсгэдэг туйлт нэгдэл үүсгэж байна уу, үгүй юу гэдгийг хэмждэг, хянадаг болмоор байна. Түүнээс тосонд буруу байхгүй. Туйлт нэгдлүүд үүсээгүй бол хүүхдүүдэд тосонд хайрсан хуушуур өгч болно гэх мэт олон асуудал байна.

Миний мөрөөдөл Монголын уламжлалт хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх. Хүнс, хөдөө

аж ахуй эрхэлж байгаа хүмүүс бүтээгдэхүүнээ зарах гэж зовдоггүй, сургууль цэцэрлэг дотоодын чанартай хүнсээ боломжийн үнээр аваад хэрэглэдэг тогтолцоо бүрдүүлэх юм. Бэлчээрийн малын махаа гаднынханд гуйж биш гуядаж өгдөг болоход үнэт чанартай гэдгийг нотлох судалгааны баримт л чухал юм.

Бас өвс ургамал, эмийн ургамал байна. Монгол хаанаас юу ч гуйхгүй. Гол нь энэ сайхан ургамал, хоол хүнсээ шинжилж, судлах хэрэгтэй.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжсэнээр манай хүрээлэн байгуулагдсан

-Ер нь монгол хүн өдөр тутамдаа ямар хоол хүнс идвэл илүү зохимжтой вэ. Хүмүүс янз бүрээр л ярих юм. Худлаа үнэн асар олон мэдээлэл дунд бид амьдарч байна шүү дээ?

-Сүүгээ уу, таргаа уу, айргаа уу. Сүү цагаан идээгээ өргөн дэлгэр хэрэглэх хэрэгтэй. Мөн махаа иднэ. Махаа идэхдээ аль болох бага иднэ. Ядаж л зуны улиралд багасгамаар байна. Гэхдээ монголчуудын махны хэрэглээ нийт хүн амын дунджаар тийм ч их өндөр биш болох нь бусад орны хэрэглээтэй харьцуулахад харагддаг. Дээр нь нэр төрөл цөөн ч дотоодын хүнсний ногоо, улаанбуудайн гурилаа хэрэглэ. Хамгийн гол нь гурилан идэх юмаа багасгах, чихэр, чипс, чихэртэй ундааг тас болих хэрэгтэй. Талхыг иддэгээрээ иднэ. Цагаан будаагаа идэж болно. Гэхдээ аль болох олон төрлийн будаа холиод идэх хэрэгтэй. Тараг сайн уух хэрэгтэй. Тараг уухдаа үйлдвэрийн сайхан таргаа уу, өглөө оройн алинд ч болно. Зах зээл дээр маш гоё тарагны хөрөнгө оруулж ирж байна. Түүгээр гэртээ тараг бүрж болно. Урд хөршид 2000 оноос эхлээд бүх хүүхдүүдээ сүү, цагаан идээгээр “балбасан” байхгүй юу. Одоо залуучууд нь үнэхээр гоё болсон. Хоол хооронд ямар нэг идэх юм өгөх маш буруу зуршил. Хөгшчүүл “хүүхдийг байнга хэвдэг мал шиг битгий болгоод бай” гэдэг шүү дээ. Дундуур нь цайгаа ууж болно. Хэвж сурна гэдэг маш аюултай. Бодисын солилцоо хямарснаар таргалалт гээд олон өвчний суурь болно. Таргалалттай хүүхдийн элэг эрүүл байна гэж байхгүй, ихэвчлэн элэг өөхөлнө. ■

САНГИЙН ЯАМ

С.Тулга: Зээлийн хүүгийн татаасанд 213.3 тэрбум төгрөгийг зарцуулсан



Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулгаас “Хүнсний хувьсгал”-ын санхүүжилтийн талаар зарим зүйлийг тодрууллаа.

-“Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийг босгож, аж ахуйн нэгжүүдэд зээл, татаас хэлбэрээр өгөхөөр болсон. Тус хөтөлбөрийн санхүүжилт хэрхэн боссон бэ?

-“Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжсэн. Уг санхүүжилтийг арилжааны банкны эх үүсвэрээр шийдвэрлэж, улмаар зээлийн хүүгийн тодорхой хувийг Засгийн газраас хариуцаж төлөх байдлаар аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг үзүүлж байна.

Уг схемийн давуу тал нь бага санхүүжилтээр буюу төсөвт өндөр ачаалал үүсгэхгүй байдлаар арилжааны банкуудын зээлийн эх үүсвэрээр аль болох олон хүнсний үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд зээл олгохыг хүссэн. Мөн бизнесийн хөрөнгө оруулалт болон бусад шаардлагатай санхүүжилтийн асуудлыг бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн. Үүний үр дүнд 2023-2025 онд төсвөөс 213.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зээлийн хүүгийн татаасанд зарцуулж, арилжааны банкны эх үүсвэрээр нийт 3160 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 их наяд

гаруй төгрөгийн зээл олгосон. Нөгөөтээгүүр, зээлийг арилжааны банк олгож байгаа болохоор зээл олголт нь бизнесийн зарчмаар явагдаж байна. Мөн зээлийн эрсдэлийг арилжааны банк хариуцаж байгаа тул зээл очих ёстой эзэндээ очиж байгаа.

-Одоогоор хэчнээн төгрөгийн зээлийг газар тариалан, мал аж ахуй, хүнс боловсруулах үйлдвэрлэлд дэмжлэг болгож өгсөн бэ. Салбар бүрд олгосон зээл тухайн аж ахуйн нэгж, иргэдэд ач тусаа өгч чадсан уу?

-“Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл нь үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг болж чадсан, хүү болон хугацааны хувьд нэн тааламжтай нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүн юм. Тухайлбал, эргэлтийн хөрөнгийн зорилгоор олгож буй зээл нь гурав хүртэл жилийн хугацаатай, жилийн 18 хувийн хүүтэй бөгөөд Засгийн газар 13 хувийг хариуцан төлж, зээлдэгч иргэн, аж ахуйн нэгж таван хувийг төлөх нөхцөлтэй. Харин хөрөнгө оруулалтын зорилгоор олгож буй зээл нь таван хүртэл жилийн хугацаатай, жилийн 19 хувийн хүүтэй бөгөөд Засгийн газар 13 хувийг хариуцан төлж, зээлдэгч иргэн, аж ахуйн нэгж зургаан хувийг төлөх нөхцөлтэй. ■

Олгосон зээл, салбараар

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ	ХҮНС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ	МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ
405.8 тэрбум төгрөг (60%)	753.5 тэрбум төгрөг (32%)	102.2 тэрбум төгрөг (8%)
		

Н.Ариунбат: 768.1 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 493.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна

Хүнсний хангамж, аюулгүй байдлын хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлийн талаар Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт Бодлогын газрын захирал Н.Ариунбатаас тодрууллаа.

“Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд олгож буй зээлүүд дээр Монголбанк бодлогын ямар гол шалгуур тавьсан бэ? Жижиг, дунд болон том аж ахуйн нэгжүүдийн хувьд ямар тэнцвэр баримталсан бэ?

-Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Монголбанк хамтарсан “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийн хүүгийн хөнгөлөлтийн ерөнхий гэрээг байгуулсан. Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Засгийн газрын санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх чиглэлийн хүрээнд уг гэрээнд тодорхой үүрэгтэйгээр оролцож байгаа болно. Үүнд:

1. Зээлдэгч зээлийн хүүгийн үндсэн төлбөр, эсхүл хүүгийн төлбөрийг хуанлийн 90 болон түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн бол зээлийн хүүгийн хөнгөлөлтийг шилжүүлэхийг зогсоох

2. Зээлдэгч зээлийг зориулалтын бусаар зарцуулсан эсэхэд ХХААХҮЯ-тай хамтран хяналт тавих, зориулалт бусаар зарцуулсан тохиолдолд зээлийн хүүгийн хөнгөлөлтийг шилжүүлэхийг зогсоох үүрэг хамаарна.

Өнөөдрийн байдлаар хэчнээн төгрөгийн зээлийг хэдэн аж ахуйн нэгжид олгоод байгаа вэ? Зээлийн хэлбэр ямар байсан бэ?

-2023-2024 онд 3-5 жилийн хугацаатай газар тариалан, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зориулалтаар 1,261.5 тэрбум төгрөгийн зээлийг 3154 зээлдэгчид олгосны 45 хувьд буюу 1423 аж ахуй нэгжид олгосон байна.



“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд аж ахуйн нэгжид зээлийн ямар үйлчилгээ өнөөдрийн байдлаар идэвхтэй байгаа вэ?

-Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр нь 2023-2024 онд хэрэгжсэн бөгөөд өнөөдрийн байдлаар зээл олголт зогссон.

Зээл авсан аж ахуйн нэгжүүдийн эргэн төлөлтийн байдал ямар байгаа вэ? Зээл буруу зорилгоор ашиглагдсан, эргэн төлөлт саатсан тохиолдолд Монголбанк ямар хариу арга хэмжээ авдаг вэ?

-Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 1,261.5 тэрбум төгрөгийн зээл олгосноос 2025 оны аравдугаар сарын 31-ний өдрийн байдлаар 768.1 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 493.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Монголбанк хамтарсан “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийн хүүгийн хөнгөлөлтийн ерөнхий гэрээнд зээл буруу зорилгоор ашиглагдсан эсвэл 90-с дээш хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд Засгийн газраас олгох хөнгөлөлтийг цуцалж энгийн зээлийн нөхцөлд шилжүүлэхээр заасны дагуу Монголбанк гэрээгээр хүлээсэн эрх үүргийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. ■

Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр нь **2023-2024 онд** хэрэгжсэн бөгөөд өнөөдрийн байдлаар зээл олголт зогссон

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Б.Энхсайхан: Манай сан 18.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан

Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхсайхантай ярилцлаа.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн гол шалгуур нөхцөл нь юу байсан бэ? Нийт хэчнээн жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжид хэдэн төгрөгийн батлан даалт гаргасан бэ?

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь дотоодын хүнсний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн хүнсний хэрэгцээг дотоодоос хангах зорилготой чухал бодлогын ажил. Манай сан энэхүү хөтөлбөрийг анхнаас нь дэмжиж хамтран ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд зээл нь зорилтот салбар, үйл ажиллагаанд чиглэсэн байх, мөн төслийн мөнгөн урсгал, төлбөрийн чадвар, баримт бичгийн бүрдэл зэрэг банкны шалгуурыг хангах шаардлагатай.

Энэ хөтөлбөрийн хүрээнд манай сангаас барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин, нийт 46 жижиг дунд үйлдвэр, аж ахуйн нэгжид 18.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан. Үүний үр дүнд нийт 32.5 тэрбум төгрөгийн зээл олгох боломж бүрдсэн.

-Зээлийн жилийн хүү, хугацаа, дэмжлэг нөхцөлийн талаар та мэдээлэл өгнө үү?

-Уг хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн жилийн хүү 19 хувь байсан. Үүнээс 13 хувийн хөнгөлөлтийг Засгийн газраас олгож, зээлдэгчийн төлөх хүү жилийн 6 хувь болж хэрэгжсэн. Зээлийн хугацаа 60 хүртэл сар, үндсэн зээлийг эргэн төлөлтөөс чөлөөлөгдөх хугацаа 12 сар хүртэл байх боломжтой.

Манай сангийн хувьд гол дэмжлэг нь зээлдэгчийн барьцаа хөрөнгийн хүрэлцээ дутмаг нөхцөлд банкны эрсдэлийн тодорхой хэсгийг батлан даалтаар хуваалцаж, ялангуяа жижиг үйлдвэрлэгчдийн санхүүжилтэд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж

46 жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид 18.5 тэрбум төгрөгийн батлан даалт гарсан байна



байгаа юм. Тодруулбал, зээлийн үндсэн төлбөрийн дүнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргаж байна.

-Банкныхан барьцаа хөрөнгөтэй том компаниудад ихэнх зээлийг олгосон байсан. Барьцаа хөрөнгөгүй жижиг аж ахуйн нэгжүүд зээл авсан ч 100 хувь авч чадаагүй асуудал гарсан. Энэ нь ямар шалтгаантай вэ?

-Нэгдүгээрт, зээл олгох эсэх нь арилжааны банкны бүрэн эрхийн асуудал. Хөтөлбөрийн хүрээнд салбарын байгууллагаас төсөл, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан банкуудад хүргүүлдэг ч эцсийн шийдвэрийг банк дотоод журам, эрсдэлийн үнэлгээ, мөнгөн урсгал, баримтжуулалт дээр үндэслэн гаргана.

Хоёрдугаарт, жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд төслийн тооцоо, санхүүгийн тайлангийн чанар, орлого-зарлагын нотлох баримт, худалдан авалтын гэрээ/нэхэмжлэл, нийлүүлэлтийн хугацаа зэрэг дээр зөрүү гарах үед банк зээлийг бүрэн дүнгээр нь нэг дор олгохоос илүүтэйгээр үе шаттай, эсвэл батлагдсан баримтад тулгуурлан хэсэгчлэн олгох тохиолдол гардаг.

Гуравдугаарт, батлан даалт нь 100 хувь барьцаа орлох биш тул банк тодорхой эрсдэлийг өөр дээрээ үлдээдэг. Гэхдээ барьцаа хүрэлцэхгүй нөхцөлд манай сан батлан даалтаар дэмжиж, жижиг үйлдвэрлэгчдийн санхүүжилтэд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх, аль болох олон аж ахуйн нэгжийг бодит санхүүжилтэд хүргэх чиглэлээр ажилласаар байна. ■



ХҮНСНИЙ ХОМСДОЛООС ДЭЛХИЙН ЭКСПОРТЛОГЧ

Дэлхийн түүхэнд хүнсний хомсдолд нэрвэгдэж, олон арван жил өлсгөлөн, логистикийн доголдол, хоол тэжээлийн хомсдолтой тулгарч явсан орнууд цөөнгүй бий. Тухайлбал, Энэтхэг улс гэхэд өлсгөлөнд нэрвэгдэж хэдэн сая хүнээ алдсан бол, Бангладеш байгалийн гамшиг бүрийн дараа хүнснийхээ тал хувийг гадаадаас авдаг асуудалтай тулж байв. Вьетнам дайны дараа сүйрч, үйлдвэрлэл нь бараг бүрэн зогсжээ. Руанда дотоодын мөргөлдөөнөөсөө болж унасан хүнсний салбараа дахин шинээр босгож эхэлсэн гэх мэтчилэн дурдаж болно. Хүнсний тогтвортой хангамжтай өнөөгийн улс орнуудаас хэн нь ч анхнаасаа хангалуун байгаагүй. Гэхдээ тэд стратегийн зөв бодлого, технологийн шинэчлэл, дэд бүтэц, дижиталчлал, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны комбинациар хямралаа шийдэж, өнөөдөр хүнсний тогтвортой хангамжтай, экспортлогч орон болж чаджээ.

1943 оны Бенгалын өлсгөлөн нь Дэлхийн II дайны үеэр, тухайн үеийн Их Британийн колони байсан Энэтхэгийн Бенгал болон Орисса мужуудад тохиосон томоохон гамшиг байв. Судлаачдын тооцоолсноор

Бенгалын бүс нутагт (одоогийн Бангладеш болон Энэтхэгийн Баруун Бенгал) 800.0-3.8 сая хүн өлсгөлөн, хумхаа болон хоол тэжээлийн дутагдлаас үүдэлтэй бусад өвчнөөр нас барсан гэж үздэг. Хүн амын шилжилт хөдөлгөөн, эрүүл ахуйн муу нөхцөл, эмнэлгийн хангалтгүй үйлчилгээ, хүнсний хомсдол, Британийн дайны үеийн буруу бодлого зэрэг олон хүчин зүйл хоорондоо давхцаж уг гамшгийн цар хүрээг улам дордуулжээ. Тухайн үед Бенгалын эдийн засаг хөдөө аж ахуйн салбараас бүрэн хамааралтай байв. Хөдөө, орон нутгийн ядуусын тал илүү хувь нь “хагас өлсгөлөнгийн байдалд” амьдарч байсан гэж үздэг аж.


Түүнчлэн тусгаар тогтносны дараах Энэтхэг улсын хүн ам хурдацтай өсөж, технологийн хоцрогдол, бордооны нөөцгүй байдал, усалгааны сул дэд бүтэц, байгалийн гамшгийн дарамтаас болж мөн л хүнсний хомсдолд хамгийн их нэрвэгдэж байв. Тус улсын үр тарианы үйлдвэрлэл 1950-иад оны үед 50 сая тонноос дээш гардаггүй, хоёр жилд нэг удаа цар тахал шиг хомсдол нүүрлэдэг байжээ. ▶

НОГООН ХУВЬСГАЛ-ҮР ТАРИА /1966-1980/



“Ногоон хувьсгал” нь Энэтхэгийг олон арван жилийн турш зовоосон өлсгөлөн, хүнсний хомсдол, импортоос хамаарсан байдал зэргийг богино хугацаанд арилгахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. “Ногоон хувьсгал” нь хөдөө аж ахуйн салбарт шинэ технологи нэвтрүүлснээр үндсэндээ орчин үеийн аж үйлдвэрийн систем рүү шилжсэн гэж үздэг. Энэ хувьсгалыг голлон удирдсан хүн нь Энэтхэгийн хөдөө аж ахуйн эрдэмтэн М.С.Сваминиатан аж. Ургамлын сортуудыг селекцийн аргаар сонгон өвчинд тэсвэртэй, бордоонд сайн хариу үзүүлдэг, чанар сайтай, өндөр ургацтай зэрэг олон ашигтай шинжийг хөгжүүлжээ.

N-Азот, P-фосфат and K-кали



Эх сурвалж: journalofethnicfoods.biomedcentral.com

Үүний үр дүнд, ялангуяа Пунжаб, Харьяна болон Баруун Уттар Прадеш мужуудад үр тарианы үйлдвэрлэл эрс нэмэгдсэн. 1950 онд 50 сая тонн байсан хүнсний үр тариа 2020 онд 300 сая тонн орчим болж өссөн. Мөн будааны үйлдвэрлэл гурав, буудай 6-7 дахин нэмэгджээ. Энэ өсөлтөөс үүдэн Энэтхэг улс 1970-аад оны сүүл гэхэд гадаадаас буудай импортлохоо зогсоож, өөрийгөө хангадаг болов. Түүгээр ч зогсохгүй анх удаа илүүдэл буудайтай улс болж хүнсний хомсдол, өлсгөлөнгийн давтамж зогсож, дан ганц бороонд найддаг хөдөө аж ахуйн салбараа өөрчилж чадсан байна.

“Ногоон хувьсгал”-ын чухал багана нь найдвартай усалгааны дэд бүтэц байв. Үр нь өндөр ургац өгдөг ч усалгааны тасралтгүй

хангамжгүй бол ургац унах эрсдэлтэй. Тиймээс том усан сан, далан барих хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн тариалангийн сувгийн өргөтгөлүүдийг олноор хийж 1980 он гэхэд 17 гаруй сая га талбайг сувгийн усаар усалдаг болжээ. Зөвхөн үрээс гадна хөдөө аж ахуйн механикжуулалт, техник маш хурдтай нэмэгджээ. 1960 онд 30 мянга байсан тракторын тоо 1990 онд 1.3 сая, цахилгаан хадуур тав дахин нэмэгдэв.

Арвин их ургац хураасан ч үнэ унах эрсдэл их байсан учраас Энэтхэгийн Засгийн газраас үндэсний дундаж худалдан авах үнэ тогтоосон байна. Түүнчлэн Засгийн газар нь тариаланчдаас тогтмол үнээр буудай, будаа авдаг болжээ. “Ногоон хувьсгал”-ын үр дүнд Энэтхэг 1970 он гэхэд өлсгөлөнгөөс гарч, 1980-аад онд хүнсний өөрийн хангалттай нөөцтэй болж, 2000 оноос буудай, будааны экспортлогч орон болсон юм.

ЦАГААН ХУВЬСГАЛ-СҮҮ /1970-1996/

1970 оны нэгдүгээр сарын 13-нд эхлүүлсэн “Цагаан хувьсгал” нь дэлхийн хамгийн том сүүний үйлдвэрлэлийн хөгжлийн хөтөлбөр байсан бөгөөд Энэтхэгийн Үндэсний Сүүний Хөгжлийн Зөвлөлийн (NDDB) түүхэн чухал төсөл юм. Хөтөлбөрийн үндсэн зорилго нь сүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг үндэсний хэмжээнд нэмэгдүүлэх, фермерүүдийг өөрсдийнхөө хөгжлийг удирдах боломжоор хангах, бий болгож буй нөөцдөө эзэн нь болгох

Тослоггүй сүүний худалдаа




www.theindiaforum.in

▶ явдал байв. Хөтөлбөрийн хүрээнд Жерси (Jersey), Холштейн (Holstein) үүлдрийн үнээ үржүүлснээр Энэтхэгт сүүний үйлдвэрлэл эрс өсжээ. Энэхүү хөтөлбөрийг “Amul” компанийн үүсгэн байгуулагч, захирал Вергьес Күрийн (Verghese Kurien), тухайн үеийн Энэтхэгийн Ерөнхий сайд Лал Бахадур Шастри (Lal Bahadur Shastri) нар амжилтад хүргэсэн хүнд тооцогддог байна. 30 жилийн хугацаанд Энэтхэгийн хүн амд ногдох сүүний хэмжээ хоёр дахин өсжээ. Мөн сүүний аж ахуй хөдөө орон нутгийн өөрийгөө тэтгэх хамгийн том хөдөлмөр эрхлэлт болж хөгжсөн байна.

Энэхүү хөтөлбөр нь Энэтхэгийг сүүгээр дутагдалтай орноос дэлхийн хамгийн том сүүний үйлдвэрлэгч улс болгон өөрчилсөн. Тус улс 1998 онд сүүний үйлдвэрлэлээр АНУ-ыг давж тэргүүлсэн бөгөөд 2018 онд дэлхийн нийт сүүний үйлдвэрлэлийн 22.29 хувийг дангаараа эзэмшиж байв. Энэхүү хувьсгал өрнөснөөр Энэтхэгт сүүний үнэ тогтвортой болж, хүн амын уургийн хэрэглээ эрс өссөн зэрэг олон өсөлттэй тоон үзүүлэлтийг дурдаж болно.

ХӨХ ХУВЬСГАЛ-ЗАГАС, УСАН АЖ АХУЙ /1985-2005/

Энэхүү хувьсгал нь Энэтхэгийн далайн болон цэнгэг усны загас агнуурын салбарыг бүхэлд нь хөгжүүлэхэд чиглэсэн бөгөөд дэд бүтэц бий болгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, орчин үеийн технологийг нэвтрүүлэхэд төвлөрчээ. “Хөх хувьсгал”-ын загалмайлсан



эцгээр Доктор Хиралал Чаудхури (Hiralal Chaudhuri)-г нэрлэдэг аж. 1980-аад оны эхэн үед Энэтхэгт загасны үйлдвэрлэл менежментийн тааруу арга барилаас шалтгаалан буурсан боловч тус хувьсгалын үр дүнд загас, усан аж ахуйн бүтээмжээ бараг 50 хувиар өсгөжээ. Загас үржүүлэлтийг өндөр нягтралтай аргаар гүйцэтгэж, шинжлэх ухаанд суурилсан технологи ашигласнаар үйлдвэрлэлийн гарцыг эрс нэмэгдүүлсэн бөгөөд дэвшилтэт тоног төхөөрөмж, техникийн шийдлүүдийг нэвтрүүлснээр Энэтхэг улс аквакултурын салбарт дэлхийд өрсөлдөх чадвартай болсон юм. “Хөх хувьсгал”-ын бас нэг чухал тулгуур нь дэд бүтцийг системтэй сайжруулсан явдал. Загас агнуур болон хөдөө аж ахуйн салбарт хөргөлтийн агуулах, боловсруулах үйлдвэр, тээвэрлэлтийн логистикийн хүчин чадлыг өргөтгөснөөр ургац хураалтын дараах алдагдал эрс буурч, нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлжээ. Үүнтэй зэрэгцэн жижиг аж ахуй эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн загасчдыг техник технологийн сургалт, багаж хэрэгслийн хангалт, санхүүгийн дэмжлэгээр урамшуулснаар тэдний орлого нэмэгдэж, Энэтхэг улсын эдийн засгийн тогтвортой байдал өссөн байна.

Ийнхүү “Хөх хувьсгал” нь Энэтхэгийн загас үржүүлэлт, усан аж ахуйн салбарт үйлдвэрлэлийн өсөлт, технологийн шинэчлэл, экосистемийн тогтвортой хөгжил, орон нутгийн иргэдийн орлогын дэмжлэг зэрэг олон чиглэлээр нөлөөлсөн цогц стратегийн өөрчлөлт. Энэ нь улс орны хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой хувьсгалын нэгэн хэсэг болж үлджээ.

АЛТАН ХУВЬСГАЛ-ЖИМС, ХҮНСНИЙ НОГОО /1991-2003/

Энэтхэг улсад 1991-2003 оны хооронд цэцэрлэгжүүлэлт болон зөгийн балын үйлдвэрлэлийн салбар эрчимтэй хөгжсөн үеийг хэлдэг аж. Энэ хугацаанд Энэтхэг жимс болон хүнсний ногооны дэлхийн хоёр дахь том үйлдвэрлэгч, мөн хүлэмжийн болон өндөр үр ашигтай тариалалтын технологийг ашиглагч тэргүүлэх орнуудын ▶

Цэцэрлэгжүүлэлтийн нийт үйлдвэрлэл, жимс, хүнсний ногоо



нэг болсон. Улсын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулсан энэхүү хувьсгал нь хөдөө аж ахуйн салбар дахь Энэтхэгийн хамгийн чухал өөрчлөлтүүдийн нэг гэж тооцогддог. Энэ хугацаанд олон тариачны эдийн засгийн нөхцөл сайжирсан. Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшилж, хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд бизнесийн салбарт идэвхтэй оролцож эхэлжээ. Энэхүү хувьсгалын үндэслэгч Нирпахк Түтэйж(Nirpakh Tutej) нь “Алтан хувьсгалын эцэг” гэж алдаршжээ. Анх тариалангийн үндсэн түлхүүр нь үр тарианы үйлдвэрлэл байсан бол 1990 оноос хойш хүнсний ногоо, жимсний салбарт анхаарал хандуулах болсон. Үүний үр дүнд Энэтхэг улс жимс, кешью самар, кокос, мангоны тариалалтаараа тэргүүлэгч орнуудын нэг болж эхлэв. Зөвхөн хөдөө аж ахуйн нэг салбарын хөгжлийг бус нийгэм, эдийн засгийн бүхэл бүтэн системийг өөрчилсөн стратегийн том хувьсгал болсон гэж үздэг байна. Эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж, олон мянган ажлын байр шинээр бий болж, Энэтхэг улс дэлхийд цэцэрлэгжүүлэлт болон органик үйлдвэрлэлийн чиглэлээр тэргүүлэгч байр эзлэхэд хүргэсэн юм.

ШАР ХУВЬСГАЛ-УРГАМЛЫН ТОС /1980-2000/

Энэтхэгийн хөдөө аж ахуйн салбарт, ялангуяа 1986-1987 оны үеийн тослог ургамлын үйлдвэрлэлийг эрчимтэй нэмэгдүүлэх, хүнсний тосны импортын хамаарлыг бууруулах байсан бөгөөд гич, газрын самар,


шар буурцаг, наранцэцэг, гүмбэг, маалинга, кастор, нигер зэрэг тосны ургамлыг онцгойлон хөгжүүлэхэд чиглэсэн.

Шар хувьсгалын гол санаачлагч, удирдагч нь харилцаа холбооны инженер, бодлого боловсруулагч Сам Питродда (Sam Pitroda) байсан бөгөөд түүнийг “Шар хувьсгалын эцэг” гэж нэрлэдэг. Тухайн үед Энэтхэг улс хүнсний тосны хэрэгцээгээ хангахын тулд их хэмжээгээр гадаадаас импортлон оруулж хийдэг байсан бөгөөд дотоодын үйлдвэрлэл хангалтгүй байжээ. Импортын өндөр хамаарал нь улсын гадаад валютын нөөцөд дарамт учруулж, эдийн засгийн хувьд эмзэг байдал үүсгэж байлаа. Дотоодын тосны ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь зөвхөн хөдөө аж ахуйн бус, эдийн засгийн хувьд ч зайлшгүй шаардлагатай асуудал байжээ.

Тухайн үеийн Ерөнхий сайд Ражив Гандхи шинжлэх ухаанд суурилсан, тодорхой бүтэцтэй, хугацаатай “Тосны үрийн технологийн зорилго” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь салангид, зохион байгуулалтгүй оролдлогуудыг нэгтгэсэн, шинэлэг бодлогын арга барил байсан аж.

Шар хувьсгалын амжилтад нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь тослог ургамлын өндөр ургацтай шинэ сортын нэвтрүүлэлт юм. Ингэж шинжлэх ухааны үндэслэлтэй, техник технологийн дэвшилд тулгуурласан өөрчлөлтийн үр дүнд Энэтхэг улс тосны ургамлын үйлдвэрлэлээ огцом нэмэгдүүлж, хүнсний тосны импортын хамаарлыг бууруулж чадсан. Ургамлын тосны үйлдвэрлэл нь 1980-2000 онд 2.5 дахин өссөн байна. ▶


Хүнсний тосны үйлдвэрлэл, импорт ба хэрэглээ



Вьетнамын “Дой Мой” шинэчлэл- Хөдөө аж ахуйг чөлөөлсөн нь

Вьетнам улсын нутаг дэвсгэр 1960-аад оноос эхлэн дайны хөлд нэрвэгдэж, тариалангийн талбайнууд сүйдсэн, хүн амын 70 орчим хувь нь ядуурлын түвшинд, байнгын хүнсний дутагдалд байжээ. Олон улсын эх сурвалжуудын мэдээлснээр 1975 онд дайн дуусах үед Вьетнамын дотоодын цагаан будааны үйлдвэрлэл жилийн 6-7 сая тонн хүрдэг байсан ч хүн амын хэрэгцээ 9-10 сая тонноос давж, жил бүр 1.5-2 сая тонн будааны дутагдалтай, олон бүс нутагт үйлдвэрлэл бараг зогсоод байжээ.

Харин 1986 оноос Вьетнам улс социалист чиг баримжаатай зах зээлийн эдийн засгийг бий болгох Doi Moi(Дой Мой) буюу шинэчлэлийн реформыг эхлүүлсэн. Уг реформ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг аажмаар чөлөөт зах зээлд суурилсан эдийн засаг руу шилжүүлэх зорилготой бөгөөд газар тариалангийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн цогц бодлогуудыг багтаажээ. Тодруулбал, хувийн хэвшлийг зөвшөөрөх, фермерийн түвшинд газар ашиглах эрхийг урт хугацаанд олгох,



үйлдвэрлэсэн ургацын тодорхой хувийг өөрсдийн мэдэлд үлдээх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Өмнө нь бүх ургацыг төрд бүрэн тушаадаг байсан бол 1988 оноос үр тарианы 40-55 хувийг өрхийн хэрэгцээнд ашиглах эрх олгосон нь тариачдын ажиллах урам зориг, идэвхийг нэмэгдүүлж тэр хэрээр ургацын хэмжээ ч эрс өсжээ. Энэ үеэс тариаланчид тариалангийн арга барилаа шинэчилж, өндөр ургацтай сорт ашиглах боломжтой болж, бордоо, хортон шавжийн эсрэг бодис, усалгааны системийг орон нутгийн хэрэгцээнд тохируулан ашиглах бололцоотой болсон. Харин Засгийн газар хөрс сайжруулах, усалгааны суваг барих, үерийн хамгаалалтын системүүдийг босгох, тариалангийн талбайг сэргээхэд ихээхэн хөрөнгө оруулсан байна. Ази, ОХУ, Хятад зэрэг улсаас орчин үеийн хөдөө аж ахуйн техник технологи, үр үржүүлгийн дэмжлэг авсан нь цагаан будааны нэг га-аас авах ургац 1990 он гэхэд гурван тонн, 2015 онд дунджаар 5.9 тонн, зарим бүс нутагт 7.5 тоннд хүрчээ.

Хэмжээлшгүй том өөрчлөлтийн нэг нь 1990 оноос эхэлсэн экспортын бодлого байв. Хорооллын хэмжээнд байгуулсан хоршоо, хамтын тариалангийн системийг зах



▶ зээлд холбож, гадаад худалдааны тунхгийг тодорхойлж, Хөдөө аж ахуйн яамны дэргэд “Хүнсний аюулгүй байдлыг хангах, экспортын стратегийг удирдах үндэсний хороо”-г байгуулжээ. Тус улс 1998 онд жилдээ 3.5 сая тонн будаа экспортлох болж, Бразил, АНУ, Тайландтай өрсөлдөж, 2005 онд энэ тоо таван сая тоннд хүрсэн бол 2012 онд 7.72 сая тонн болж Вьетнам дэлхийн цагаан будааны нийлүүлэлтийн 20 гаруй хувийг дангаараа хангах хэмжээнд хүрснийг харуулна.

Өнөөдөр Вьетнам нь Тайландаас хойш дэлхийд хоёрдугаарт ордог цагаан будааны экспортлогч бөгөөд зарим жил Энэтхэгийн дараа гуравдугаарт бичигддэг болжээ. Мөн зөвхөн цагаан будаа бус, кофе, хушга, далайн бүтээгдэхүүн, самар зэрэг бусад бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн нийт экспортын орлого 2023 онд 53.2 тэрбум

ам.долларт хүрснээс будаа 4.4 тэрбум, кофе 4.2 тэрбум, самар 1.3 тэрбум ам.долларыг эзэлжээ. 2024 онд ургацын нийт дүн 55-58 сая тонн болж тогтвортой өсөх төлөвтэй байгаа талаар Дэлхийн Банкны тайлангаас харж болно.

Вьетнамын хүнсний хомсдолоос дэлхийн томоохон экспортлогч болох хүртэлх түүх нь нэг талаас дайны дараах ядуурал, нийгмийн хямрал, өлсгөлөнгийн эсрэг тэмцэл, нөгөө талаас хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухаан, нийгмийн хөдөлгөөн, бодлогын шинэчлэлийг хослуулсан стратегийн үр дүн юм. Хөдөө аж ахуйн салбарын шинэчлэлийг үе шаттайгаар хийж, тариалангийн үржил шимийг нэмэгдүүлж, зах зээлийн боломжийг бүрэн ашиглаж, фермерийн сэтгэлгээ, системийн зохион байгуулалтыг өөрчилсөн нь өнөөдөр дэлхийд тэргүүлэгч экспортлогч орны байр суурийг эзлэхэд хүргэсэн юм.

Шинэ тосгоны шинэчлэл

Өмнөд Солонгосын ард түмэн өлсгөлөн, хүнсний хомсдолын хүнд сорилтоос эхлээд эдийн засаг, хөдөө аж ахуй, нийгмийн томоохон шинэчлэлийн үр дүнд хүнсний аюулгүй байдлаа хангаж, экспортлогч болсон гайхалтай түүхтэй. 1950-1954 оны БНСУ-ын дайны үе, дайны дараах уналтад орсон эдийн засаг, эвдэрч сүйдсэн дэд бүтэц нь хүнсний хангамж, тариалалт, логистикт асар их хохирол учруулсан. Хүн амын 70 гаруй хувь нь тариаланч байсан ч уламжлалт гар аргаар тариалалт хийдэг, хөрсний элэгдэл өндөр, ган болон үерийн эрсдэлтэй, ургац бага байв. Гэсэн хэдий ч Солонгосын Засгийн газар, олон улсын байгууллагууд, олон нийтийн оролцоотой хамтын хүчээр хөдөө аж ахуйг сэргээх, тариаланчдын нөхцөл байдлыг сайжруулах, дотоодын хоол хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн цогц бодлогыг хэрэгжүүлсэн.

Газрын татварын системийг өөрчлөх замаар тариалангийн газрыг жижиг талбайгаар бус, үр ашигтай хэмжээнд нэгтгэж, хамтын тариалангийн хэлбэрийг хөгжүүлж эхэлжээ. Ингэснээр 1960 онд нэг га-гаас 1.3 тонн будаа хурааж байсан бол 1975 он гэхэд 3.2 тонн болж өссөн байна. Үүний зэрэгцээ тариалангийн салбарт мэргэжлийн зөвлөгөө өгөх агрономич,



1970-аад онд "Шинэ тосгон" хөдөлгөөний хүрээнд гүүр барьж байна. Солонгосын Засгийн газар орон нутгийн иргэдийн хийж буй дэд бүтцийн ажилд мод, цемент зэрэг барилгын материалаар хангаж байв.

техникч бэлтгэж эхэлсэн бөгөөд сургалт, туршилтын талбайн системийг бий болгосон нь ургац нэмэгдэхэд хүчтэй нөлөө үзүүлжээ.

Эдгээр сэргэлтийн бодлого, хөтөлбөрийн хамгийн тод жишээ нь 1970 онд эхлүүлсэн “Шинэ тосгон” хөдөлгөөн (New Village Movement) юм. Энэ хөдөлгөөний үндсэн зорилго нь хөдөө тосгоны бүтцийг сэргээж, иргэдийн оролцоонд тулгуурласан хөгжлийг бий болгох, хамтын хөдөлмөрийг дэмжих, хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой болгох байв. Энэхүү хөдөлгөөний хүрээнд тосгон бүрд зам, усан сан, хөдөө аж ахуйн зориулалттай агуулах барих, механикжуулалтын төв байгуулах, тариаланчдыг бүлэг, хоршоо болж ажиллах боломжоор хангаж байлаа.

Хоёрхон жилийн хугацаанд 33 мянга гаруй тосгонд үйлдвэрлэлийн бүтцийн шинэчлэл хийсэн гэх судалгаа ч байдаг аж. Энэ нь зөвхөн ▶





► дэд бүтцийн өөрчлөлт төдийгүй иргэдийн сэтгэлзүйн эргэлт болж, “Бид өөрсдөө хөгжилд хүрнэ” гэх итгэл, хандлагыг төлөвшүүлсэн нь дараа, дараагийн эдийн засгийн хөгжлийн суурь болсон гэж үздэг байна.


Ийнхүү орон даяар усан сангууд байгуулж, тариалангийн талбайн 70 гаруй хувьд усалгааны таатай боломжийг бүрдүүлсэн нь гангийн шокийг даван туулах гол механизм болжээ. 1971 онд гангийн улмаас ургацын 22 хувийг алдаад байсан бол 1978 онд технологийн шинэчлэлийн үр дүнд дөрвөн хувь болгон бууруулсан байна.

Үүний зэрэгцээ хувийн хэвшил, аж үйлдвэрийн салбарын өсөлттэй уялдуулан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх үйлдвэрүүдийг байгуулах бодлого хэрэгжиж, 1980-аад он гэхэд Солонгос улс хүнсний тусламжаас ангижирч, 1990 оноос хойш зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох түвшинд хүрэв. 2015 онд хөдөө аж ахуйн экспортын хэмжээ 6.4 тэрбум ам.долларт хүрсэн бол 2023 онд энэ тоо 10 тэрбум ам.доллар давсан статистик байна. Ингэхдээ зөвхөн уламжлалт бүтээгдэхүүн бус, өндөр технологи шингэсэн, нэмүү өртөг шингэсэн органик болон функциональ хүнсний экспорт илүү давамгайлсан байна.

Эдгээр улсын өсгөлөн, хүнсний хомсдолоос

гарч, экспортлогч болох замналын гол сургаамж нь хямралыг зөв үнэлж, ардиргэдийн оролцоонд тулгуурласан өөрчлөлтийг шинжлэх ухаан, технологитой уялдуулан, төр хувийн хэвшлийн хамтын хүчээр хэрэгжүүлсэнд оршино. Хөдөө аж ахуйг зөвхөн хүнсний эх үүсвэр бус үндэсний аюулгүй байдал, ард түмний сэтгэл зүйн сэргэлт, экспортыг дэмжих стратегийн салбар гэж үзэн, технологи, дэд бүтэц, бодлого, хүний нөөцийг нэгтгэн хөгжүүлсэн нь олон улсын хэмжээнд үлгэр жишээ болсоор байгаа билээ.

Холтос идэж өлсгөлөнг зогсоосон Япончууд



XIX зууны эхэн үеийн Япон оронд эхэлсэн хүйтэн зун, давтамжтай үер, тасралтгүй орох ширүүн бороо цагаан будаа, улаан буудайн талбайг нүд ирмэхийн зуур сүйтгэж, улс орон даяар ургацын алдагдал эхлэв. Түүхэнд энэ үеийг “Тэнпогийн өлсгөлөн” гэж тэмдэглэсэн бөгөөд 1833-1837 онд Японы олон бүс нутагт ургац дунджаас хоёр, бүр зарим газар гурав дахин багасч, 1836 оны байдлаар ургац ердийнхөөс ердөө 28-30 хувьтай байсан гэж ►

► тэмдэглэсэн байдаг. Ургац алдахад зөвхөн тариалангийн талбай хоосорсонгүй айл өрхүүдийн амьдралын баталгаа, ирээдүйн итгэл зэрэг хоосорчээ.

Хот тосгодоод өлсгөлөнтэй хамт өвчин ирж, бослого хөдөлгөөн гарах болж, хэдэн зуун мянган хүн амь алдсан тухай тэмдэглэл байдаг. Хоол болох бүхэн үнэ цэнтэй болсон тэр үед мод хүртэл ширээний зочин болов. Түүхэн тэмдэглэлд, ялангуяа Японы хойд нутгуудаар хүмүүс нарс модны дотор холтсыг хусаж, хатааж, тээрэмдэн нунтаглаад будаатай хольж, зуурмаг маягаар болгож иддэг байсныг дурдсан байдаг аж. “Модны талх”, “холтосны гурил” гэж нэрлэгдэх энэ хоол аманд гашуун, ходоодонд хүнд, тэжээл муутай ч өлсгөлөнгийн өвдөлтийг түр намдаах ганц найдвар байв. Үүгээр ч зогсохгүй, өвсний үндэс, зэрлэг жимс, уулын навчийг хүртэл хэд хэд буцалгаж исэлтийг нь багасган иддэг байжээ.



Өлсгөлөн улс орны сүнснийг сөхрүүлсэн ч ухаарал авчирсан юм. Нөөцлөх системийг шинэчилж, агуулах барих, тариалангийн эрсдэлийг хуваах, муж хоорондын хоол хүнсний солилцоог нээх, татварын тогтолцоог зөөлрүүлэх зэрэг алхмууд аажмаар хэрэгжиж эхэлсэн байна. Япончуудын хамгийн их хүч нь нийгмийн сахилга бат, эв нэгдэл байв. Хүн бүр гэр бүлдээ, байгальдаа хүндэтгэлтэй хандаж, бүх нөөц бололцоогоо нэгтгэв. Өлсгөлөнг зогсоохын тулд бүхэл бүтэн тосгонууд, айл өрхүүд цуглан өөрсдөө хүнсний нөөцөө нэмэгдүүлэх, үржил шимтэй газар шороогоо эрчимтэй сэргээж эхэлжээ.

Ургац зөвхөн байгаль цаг агаарын бус төр засгийн бодлогоос ч ихээхэн шалтгаалдаг гэдгийг “Тэнпо”-гийн хар жилүүд сануулсан хэрэг.

Японы дараагийн том өлсгөлөн бол 1945 онд Дэлхийн-II дайнд ялагдаж, дэд бүтэц нь сүйджээ. Ард иргэд өлсгөлөнгийн ирмэг дээр ирсэн байв. Тухайн үед уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн түвшин ердөө 27.6 хувь байсан Японы эдийн засгийн сүйрлийг илтгэнэ. Америкийн хүнсний илгээмжгүй байсан бол өлсгөлөн өргөн хүрээг хамрах аюултай байжээ. Энэхүү өлсгөлөнг зогсоосон алхам бол үйлдвэрлэл, уурхай, дэд бүтэц сэргээх ажил байв. Хотуудын зам, төмөр зам, харилцаа холбоо дахин босож эхэлснээр хүнс, бараа бүтээгдэхүүн улс даяар түгээмэл болсон. Үйлдвэрлэл хөгжсөнөөр хүмүүс ажилтай орлоготой болж үүнийг дагаад дотоодын хэрэглээ нь нэмэгдэж эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлжээ. 1952 онд Америкийн засгийн газар Японыг глобал эдийн засагт эргэн оруулахад амжилттай ажиллаж, эдийн засаг дахин эрчимтэй өсөлт рүү хөтөлсөн.

Өнөөдөр бид Японы хурдны галт тэрэг, инженерийн гайхамшгийг хараад зөвхөн технологийн тухай л ярьдаг. Харин тэр гайхамшгийн ёроолд бодит үнээр төлсөн хүндхэн сургамж нуугдана. Модны холтсыг тээрэмдэж гурил болгож байсан гар, будааны нэг аяган дээр бүхэл амьдралаа тавьж байсан зүрх, өлссөн хүүхдүүдийн уйлах чимээний цаана өнөөгийн Японы сахилга бат, ажилч хичээнгүй, нямбай зан, эрсдэлийн мэдрэмж урган гарчээ. ■



ОРОН НУТАГ

ХЯЗГААРЛАГДМАЛ ХҮРТЭЭМЖИЙГ ТЭЛЭХ СТРАТЕГИ

Дэлхийн хүнсний үйлдвэрлэл сүүлийн 30 жилд 50-60 хувиар өссөн ч хүртээмжийн асуудал, хоол хүнсний чанарын ялгаа асар их байна

Дэлхий дахинаа хүнсний үйлдвэрлэл сүүлийн 30 жилд 50-60 хувиар өссөн ч хүртээмжийн асуудал, хоол хүнсний чанарын ялгаа асар их болжээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын /ДЭМБ/ мэдээлснээр дэлхийн хоёр тэрбум хүн шим тэжээлийн дутагдалтай буюу тэжээллэг хоол хүнс хангалттай авч чадахгүй байна. Түүнчлэн вирус, нян, шимэгч, хүнд металл, пестицид зэрэг бохирдуулагчтай хоол хүнс нь 200 гаруй төрлийн өвчний шалтгаан болж байна гэдгийг 2023-2024 оны тайланд дурджээ.

Монгол Улсын хувьд хөдөө орон нутагт хүнсний үйлдвэрлэл дотоодын хэрэгцээг хангах гол эх үүсвэр боловч дэд бүтэц, хадгалалт, түгээлтийн сүлжээ муу хөгжсөн зэргээс шалтгаалан хүнсний хүртээмж хязгаарлагдмал хэвээр байна. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй

байдал” үндэсний хөдөлгөөн нь дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих төдийгүй, хүн амын эрүүл мэнд, аюулгүй органик хоол, хүнсний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын чухал алхам болов. Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулан ард иргэддээ үр өгөөжтэй өөрчлөлтүүдийг авчирна гэдгийг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх зарласан билээ.

Үүний үр дүнд өнгөрсөн жил хүнсний ногооны хэрэгцээний 85 хувийг дотоодоос хангаж чадсан юм. Мөн газар тариалангийн салбарт олгосон зээлийн үр дүнд нийт зоорины багтаамж 2021 оны суурь түвшний үзүүлэлтээр 230 мянган тонн байсан бол 2024 онд 292.2 мянган тонн болж өссөн. Махны экспортын орлогыг 2022 оны дүнтэй харьцуулахад 50 сая ам.доллаароос 285.4 сая ам.доллар болж 71.1 хувиар өсжээ. Хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд 21 аймгийн ▶

► хүнсний үйлдвэрлэл нэн чухал. Тиймээс бүс, орон нутгийн онцлогт тулгуурлан, хүнсний бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн хөгжүүлэх, дэмжих чиглэлд бодитой ажлуудыг хийж байна.

Өндөгний хэрэгцээгээ өөрсдөө

Дэлхийн хэмжээнд нэг хүнд ногдох өндөгний хэрэглээ сүүлийн жилүүдэд нэмэгдэж, дундаж хэрэглээ жилд ойролцоогоор 10 кг орчим болсон бөгөөд энэ нь хүн амын хоол тэжээлийн чанарын өсөлтийг харуулж буй юм. Манай улсын хувьд өндөгний үйлдвэрлэл хөгжих нь хүнсний аюулгүй байдлыг хангах, импортын хамаарал багасгах, орон нутгийн эдийн засгийг дэмжиж малчид, фермерүүдийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болох ач холбогдолтой. 2020 оноос өмнө өндөгний өсөн үйлдвэр үйл ажиллагаа явуулж 50-иас дээш хувийг импортоор хангадаг байв. Харин “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний үр дүнд хөдөө, орон нутагт өндөгний үйлдвэрлэл нэмэгдэж байна. **ДОРНОГОВЬ** аймгийн “Мөрөөдлийн говь” ХХК нь “Өдөр бүр шинэ өндөг” гэсэн уриатай говь нутгийн иргэдийн өндөгний хэрэгцээг хангах автомат үйлдвэр нээн ажиллуулж буй. Тус компанийн “Шанд эгг” өндөгний ферм 2021 оны аравдугаар сард анхны дэгдээхэйгээ хүлээн авч 2022 оны гуравдугаар сард эхний өндөгөө зах зээлд гаргаж эхэлсэн. Тус үйлдвэр 30 гаруй мянган тахиатай, орон нутгийн өндөгний хэрэгцээний 60 гаруй хувийг хангадаг. Цаашид зуун хувь дотоосоо хангах зорилт тавин ажиллаж байна. Тус үйлдвэрийн дарга Э.Батхуяг “Цаашдаа орон нутгаа 100 хувь хангаж Улаанбаатар болон хөрш зэргэлдээх аймгуудад нийлүүлэх зорилготой” хэмээн ярилаа.

БАЯНХОНГОР аймгийн Баянхонгор сумын “Агин өндөг”-ний үйлдвэр нь хөнгөлөлттэй зээлд хамрагдан хоёр жилийн дотор 2500 тахиаг 12 мянга болгон үржүүлж үйлдвэрээ хамгийн сүүлийн үеийн, олон улсын стандартад нийцсэн бүрэн автомат тоног төхөөрөмжөөр тоноглож хүчин чадлаа 3-4 дахин нэмэгдүүлжээ. Ингэснээр Баянхонгор аймгийн өндөгний хэрэгцээг 100 хувь хангадаг болж илүү гарснаа Өвөрхангай аймагт нийлүүлж эхэлжээ.

ХЭНТИЙ аймгийн Чингис хотод “Хэрлэн өндөг”-ний үйлдвэр шинээр үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Тус үйлдвэр нь одоогийн

байдлаар 2000 тахиатай, өдөрт 1900-2000 ширхэг шинэхэн өндгийг аймгийнхаа иргэдийн гарт хүргэж байна. Энэхүү үйлдвэрийг Улаанбаатар хотоос шилжиж ирсэн залуу гэр бүл 2023 онд байгуулжээ. Орон нутгийн зүгээс үйлдвэр байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж өгсөн нь тэдэнд томоохон дэмжлэг болжээ.

Ийн хөдөө, орон нутгийн жижиг дунд аж ахуйн нэгжүүд эрэлт ихтэй зах зээлд хөл тавьснаар өнөөдөр монголчууд өндөгний нийт хэрэглээнийхээ 80 орчим хувийг дотоодоосоо хангадаг болжээ.

Шувууны аж ахуй эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Болд “Засгийн газрын сайн бодлогын дүнд аж ахуй нэгжүүд зээлд хамрагдаж, үйл ажиллагаагаа өргөжүүлж шинээр 20 гаруй шувууны аж ахуй эрхлэгч компани нэмэгдсэнээр дотоодын өндөгний хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдсэн. Цаашид өндөгний хэрэглээ 650 сая ширхэгт хүрэх тооцоо бий” хэмээн ярьсан.


Өндөгний бизнес эрхлэгчид тариаланчдын улаан буудайг худалдан авдаг. Энэ жил шувууны аж ахуй эрхлэгчид 60 мянган тонн улаан буудай худалдаж авах төлөвлөгөөтэй аж. Ирэх хоёр жилд гурван сая шувуутай болж, дотоодын өндөгний хэрэгцээг бүрэн хангахаас гадна малын тэжээл үйлдвэрлэл, газар тариалангийн кластер бизнес хөгжүүлэх боломж бүрдэхийг хэлж байлаа.

Хөдөө орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь зөвхөн хүртээмжийг сайжруулдаг төдийгүй эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлдэг. Хөдөө аж ахуйн салбарын орлого нэмэгдсэнээр орон нутгийн ажилгүйдэл буурч, жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих замаар орон нутгийн хөгжлийг түргэтгэнэ. Мөн дотоодын хүнсний үйлдвэрлэл нэмэгдэх нь импортыг орлох, валютын урсгалыг багасгах замаар эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх ач холбогдолтой.

Хөдөөгийн хөрсөнд соёолсон “Хүнсний хувьсгал”

ДОРНОД аймаг хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл, хүнсний нарийн ногооны нэр төрөл, тариалалтыг нэмэгдүүлэх, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг өсгөх, хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг ►

ХӨДӨӨ АЖ АХУЙН АГРОПАРК БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТ



****ХАА-н агропарк нь үйлдвэр, фермерүүд, нөхөрлөл, хоршоод, аж ахуйнуудыг дэмжсэн кластерийг бий болгоход чиглэгдэнэ.**

Эх сурвалж: ХХААХҮЯ

► бууруулах, өрх бүр хашаандаа хүнсний ногоогоо тариалах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Арван мянган хүлэмж” төслийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хүнсний ногоо тариалан эрхлэгчдэд өнгөрсөн жил 311, энэ жил 400 хүлэмжийг олгосон. Цаашид аймгийн нийт айл өрхийн 50 хүртэлх хувь буюу хоёр өрх тутмын нэг нь хүлэмжтэй болох зорилт тавьжээ.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутагт гэрчимжүүлэн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Дорноговь аймгаас санаачлан хэрэгжүүлж буй “Шинэ хөдөө” төслийн хүрээнд тус аймгийн Иххэт суманд нийт 25 хүлэмж, газар тариаланд ашиглах иж бүрэн трактор, 1.3 тонны усны нөөцийн сав олгожээ.

БУЛГАН аймаг ДНБ-ий 60 хувийг хөдөө аж ахуйн салбараас бүрдүүлдэг аж. 2024 онд мал аж ахуйн салбараас 273.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлжээ. Хүнсний хувьсгалын хүрээнд олгож буй хөнгөлөлттэй зээлд тус аймгийн 14 иргэн, аж ахуйн нэгж хамрагдан дотоодынхоо мах, махан бүтээгдэхүүн

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Архангай аймгийн 47 аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагджээ

болон төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлж чаджээ.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Булган аймагт хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх Үйлдвэр технологийн паркийг байгуулах бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан мах, сүү сүүн бүтээгдэхүүнээр Хойд бүсийн иргэдийг хангахын зэрэгцээ түүний дагалдах баялаг арьс шир боловсруулах ноос угаах зэрэг үйлдвэрийг барихаар төлөвлөөд буй.

ДОРНОГОВЬ аймагт хөнгөлөлттэй зээлийн хүрээнд найман сумын 38 иргэн, аж ахуйн нэгж хамрагдан хамгаалагдсан хөрсний тариалалтыг 7600 м.кв-аар, хүнсний ногооны зоорины хангамжийг 30.4 хувь, төмс, хүнсний ногооны хангамжийг хоёр хувиар нэмэгдүүлсэн байна. Аймгийнхаа махны хэрэгцээг 100, сүүний 76, гурилан бүтээгдэхүүний 6.6, төмс хүнсний ногооны хангамжийн 25, өндөг 73 хувийг орон нутгаасаа тус тус хангаж байна.

Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар төмс, хүнсний ногоог хадгалах зориулалттай 305 мянган тонн хүчин чадал бүхий 5989 зоорь бий. Гэсэн хэдий ч хүн амын хүнсний ногоо, төмсний хэрэглээ болон хураан авч буй ургацын хэмжээг харьцуулахад нэмэлтээр 170 мянган тонн

► багтаамжтай зoorь, агуулах шаардлагатай гэсэн тооцооллыг салбарын яамнаас гаргасан.

ХӨВСГӨЛ аймаг төмс, хүнсний ногооны тариалалт, ургацыг нэмэгдүүлж, хадгалж нөөцлөх боломжийг бүрдүүлэх зорилгоор 500 тонны хүчин чадалтай механикжсан хоёр зoorь ашиглалтад оруулжээ. Мөн 2030 он хүртэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн таван хувийг органик баталгаажуулалтад хамруулахаар зорьж буй. Ойрын ирээдүйд органик мах махан бүтээгдэхүүн экспортлогч аймаг болохыг зорьж, малаа бүртгэлжүүлэх, малчдаа чадавхжуулах, малын эрүүл бүсээ нэмэх зорилт тавьжээ.

Харин энэ оны улсын төсөвт 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тусгасан бөгөөд Сэлэнгэ аймгийн Орхон, Мандал, Баянгол, Шаамар, Хушаат, Жавхлант, Зүүнбүрэн суманд нэг загвар, нэг төсвөөр төмс, хүнсний ногооны 200, 500 тонн багтаамжтай агуулахын барилга барьж байна. Эдгээр агуулахыг ашиглалтад оруулснаар 2800 тонн багтаамжтай, жилийн дөрвөн улиралд ашиглах боломжтой механикжсан хөргүүртэй хадгалах орчин шинээр бүрдэх юм. Ингэснээр дээрх сумын ногоочид ургацаа улирал харгалзахгүй хадгалж, борлуулахаас гадна хүнсний ногооны хадгалалт, ангиалт, савлалт, нэмүү өртөг шингээх үйл ажиллагаанд дэвшил гарах боломжтой болох юм.

ЗАВХАН аймгийн хувьд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Улаан хальст саримс”-ны тариалалтыг орон нутагтаа өргөжүүлж, нутгийн брэнд бий болгожээ. Саримсны үрийн сан байгуулах, улаан хальст саримсыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тарьж ургуулж байна. Цаашлаад хүн амын хэрэгцээт саримсны хангамжийг нэмэгдүүлэх, улмаар гадаадад экспортлох зорилт тавьжээ.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнд хамааралтай, үр дүнтэй хэрэгжиж буй төслийн нэг нь ХХААХҮЯ, Азийн хөгжлийн банк (ADB), Ядуурлыг бууруулах Япон сангийн хамтарсан “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй”-г нэрлэж болно.

2020 онд эхэлсэн уг төсөл зургаан жилийн хугацаатай хэрэгжиж байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний ногооны хүртээмжийг

нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдийн орлогыг өсгөх зорилготой. Монгол Улсад нийт тариалангийн талбайн дөнгөж 10 орчим хувь нь усалгаатай. Энэ нь байгаль, цаг уурын нөлөөнд ургац тогтворгүй байх гол шалтгаан болж ирсэн. Иймд уг төсөл нь усалгааны дэд бүтцийг шинэчлэх замаар хөдөө орон нутгийн ногоочдыг байнгын орлого, тогтвортой ургацтай болох чухал алхам юм.

Төслийн хүрээнд дараах аймаг, сумдын усалтын системийг сэргээн засварлах, шинэчлэх ажлыг хийж байна.

- **Ховд аймаг** – Алтай сумын Боомын ам
- **Говь-Алтай аймаг** – Жаргалан сумын Цахир, Халиун сумын Ёлтон
- **Завхан аймаг** – Улиастай сумын Ногоон хашаа, Тэлмэн сумын Хүрэн тал
- **Баян-Өлгий аймаг** – Баяннуур сумын Цул улаан, Сагсай сумын Улаандэл
- **Сэлэнгэ аймаг** – Сант сумын Ивэн гол
- **Төв аймаг** – Батсүмбэр сумын Сөгнөгөр
- **Хэнтий аймаг** – Хэрлэн сумын Дулааны тал

Энэ оны аравдугаар сарын байдлаар долоон усалтын системийн барилга, цахилгааны ажлыг бүрэн дуусгаж улсын комисст хүлээлгэн өгснөөр усалгаатай талбайн хэмжээ 2061 га талбайгаар нэмэгджээ. Мөн долоон аймгийн 10 суманд 59 бүлэг хоршоонд 810 ногоочин нэгдсэн ба усалгаатай талбайд тариалалт хийх технологийг эзэмших сургалтуудад хамрагджээ. Энэ онд эдгээр усалтын системийн 785.3 га талбайд 157 ногоочин, 2 аж ахуйн нэгж тариалалт хийж 1094 тонн төмс, 240.9 тонн хүнсний ногоо, 1280 тонн ногоон тэжээл хураан авчээ.

ӨВӨРХАНГАЙ аймагт 55 хүнсний үйлдвэр, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй, бага хүүтэй, урт хугацаатай зээлд хамрагдаж газар тариалан, мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах цех байгуулахад анхаарчээ. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг “Орда” гурилан бүтээгдэхүүний үйлдвэр тус зээлд хамрагдан тоног төхөөрөмжөө бүрэн шинэчилж, хүчин чадлаа хоёр дахин нэмэгдүүлжээ. Мөн аймгийнхаа 11 хүнийг тогтмол ажлын байраар ханган үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Өвөрхангай аймгийн 19 суманд нийлүүлж байгаа гэдгийг тус үйлдвэрийн захирал Ч.Гантулга хэлж байлаа.

Архангай аймагт 47 хүнсний үйлдвэр, аж ахуйн нэгж тус үндэсний хөдөлгөөний хүрээнд ►

Махны экспортын орлогыг 2022 онтой харьцуулахад 285.4 сая ам.доллар болж 71.1 хувиар өсжээ

▶ олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, мах, сүү сүүн бүтээгдэхүүн зэргийг дотоодоосоо 100 хувь хангахын зэрэгцээ аймгийн ДНБ-ий хэмжээг 2.6 хувиар өсгөсөн байна. Тус аймаг 2023 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах” жил болгон зарласан байна. Энэ хүрээнд малын эрүүл мэнд, хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах, өндөр ашиг шимтэй малын эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэн төв суурин газрын махны хэрэгцээг хангах зэрэг ажлыг шат дараатай хэрэгжүүлэн ДНБ-ий хэмжээг 2.6 хувиар өсгөж чаджээ. Архангай аймгийн хувьд жилдээ 40.2 тонн мах, 28.7 мянган тонн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодынхоо хэрэгцээг 100 хувь хангадаг байна.

АРХАНГАЙ аймгийн Цэцэрлэг суманд үйл ажиллагаа явуулдаг “Амин чанар” үйлдвэр үндэсний хөдөлгөөний хүрээнд бага хүүтэй, хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлд хамрагдан 2024 онд жилд 30 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай шинэ үйлдвэрээ Улаанбаатар хотод барьж ашиглалтад оруулжээ.

Мөн Их тамир сум “Жиферм” эрчимжсэн мал аж ахуйн ферм нь хоёр жилийн өмнө зээлд хамрагдан дэд бүтцээ сайжруулан, сүү савлагч, ариутгагч зэрэг тоног төхөөрөмж худалдан авч үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн байна.


ӨМНӨГОВЬ аймаг “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, ХХААХҮЯ-наас хэрэгжиж

**Долоон
 услалтын
 системийн
 барилга,
 цахилгааны
 ажлыг бүрэн
 дуусгаснаар
 усалгаатай
 талбайн
 хэмжээ 2061 га
 талбайгаар
 нэмэгджээ**

байгаа бодлого чиглэлтэй төлөвлөгөөт ажлаа уялдуулж, газар тариалан мал аж ахуйн салбараа дэмжих “Нутгийн жишиг” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Аймгийн удирдлагуудын зүгээс 2023 онд газар тариалан эрхлэгч иргэддээ 400 хүлэмж олгох шийдвэр гаргасан бөгөөд одоогийн байдлаар 100 хүлэмж олгогдож, удахгүй 300 хүлэмж дахин олгох гэж байна.

Улс орон даяар өрнөж буй томоохон төсөл, үндэсний хөдөлгөөн судалгаа, шинжилгээ, эрдэмтэн судлаачдын зөвлөгөө, зөвлөмжийг зайлшгүй тусах ёстой. Тиймээс Ерөнхийлөгчийн тамгын газраас аймаг, орон нутагт “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний дэргэдэх эрдэмтдийн зөвлөл болон мэргэжлийн холбооны салбар зөвлөлийг 21 аймагт байгуулсан. Ингэснээр орон нутгийн түвшинд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангахад шинжлэх ухаанчаар хандаж төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн салбарын үйл ажиллагааг илүү зохион байгуулалттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэх юм.

Өөрсдийн газар нутгаас, өөрийн хөдөлмөрөөр, эрүүл хүнсээ хангах нь “Хүнсний хувьсгал”-ын бодит үр нөлөө юм. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь нэг үеийн уриа бус, Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын ирээдүйн суурь бодлого билээ. ■



ДУГНЭЛТ

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн үргэлжлэх хүлээлттэй байна

Монгол Улсын Ерөнхийлөгч “Давсаа хүртэл айлаас гуйхгүй байя” гэх үгийг “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлэхэд хэлж байв. Утга нь Монгол Улс өнөөдөр өмсөх хувцас, идэх хоолоо гаднаас худалдаж авсаар байна. Хэрэв Ковид цар тахал шиг аюул нүүрлэвэл бид өмсөх хувцасгүй, идэх хоолгүй сууж байх нь. Дэндүү арчаагүй нөхцөл байдалд орох нь тодорхой. Тиймээс “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж, богино хугацаанд үр дүнгээ ч өгөв. Тиймээс дараагийн шатны хөтөлбөр үргэлжлэх ёстой гэдгийг эрдэмтэн судлаач, төр, хувийн хэвшлийнхэн, ард түмэн хүсэж байгаа юм.

Монгол Улс ядаж гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, ард түмэндээ эрүүл, аюулгүй хүнс идүүлэх зорилго тавьж, тодорхой хэмжээнд биеллээ олов. Гэвч давсаа гаднаас гуйсан хэвээрээ л байна. Хил гаалиар аюулгүй, эрүүл хүнс орж ирж байгаа нь эргэлзээтэй хэвээрээ байна. Дотоодынхоо хүнсний амин дэм, шимт чанарт шинжилгээ хийчихдэг улсын томоохон лаборатори ч алга байна шүү дээ. Эрдэмтэн, судлаачдаа ч үүнд төдийлөн дайчилж чадахгүй байна. Тиймээс хүнс судлалын салбараа хөгжүүлж, улсын томоохон лабораториудыг бий болгох нь чухал юм. Ард түмнээ эрүүл хүнсээр хангаж, эрүүл жаргалтай амьдруулдаг улс орнууд олон бий. Тухайлбал, Энэтхэг улс тэр олон сая хүнийг дотооддоо хүнсээр 100 хувь хангаж чадсан байна. 1960-аад оноос эхлэн хүнсний ногоон, цагаан, хөх, шар хувьсгалуудыг тасралтгүй, тууштай, зөв бодлогоор хийснээр ард түмнээ эрүүл, аюулгүй хүнсээр хангаж чаджээ. Европын өндөр хөгжилтэй улсуудтай ч яриад байх юмгүй, ард иргэдийнх нь хүнсний хангамж, аюулгүй байдал дээд зэргээр хангагдаж чадсан.

Монгол Улсад ард иргэдээ дотооддоо үйлдвэрлэсэн хүнсээр хангах нөөц бололцоо бүрэн бий. Олон төрлийн шимт ургамлаар хооллодог малын махаа идэж, эрүүл хөрсөнд ургасан үр тариа, ногоогоо хэрэглэж, сүү, цагаа идээ жимс жимсгэнээ идэх бүрэн боломжтой.



“Хүнсний хувьсгал”-ын хүрээнд ШУТИС-ийн харьяа Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг байгуулж, эрдэмтэн, судлаачдаа сонсож дайчилж эхэлсэн нь сайн зүйл болов

Тэр бүү хэл дотооддоо үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнээ экспортод гаргаж, улсдаа орлого олох боломжтой юм.

Энэ бүхний зөв эхлэл “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн байлаа. Дараагийн шат нь илүү судалгаатай, ахисан, гүнзгийрсэн байдлаар үргэлжлэх ёстой. Нийгэм үүнийг шаардаж байна. Үнэхээр төрийн бодлого нь зөв оновчтой байвал манай хүнсний салбарынхан ямар их зүйлийг хийж бүтээж болдгийг харуулж чадаж байна. Үйлдвэрүүд шинээр нэмэгдэж, олон мянган ажлын байр бий болж, жижиг, дунд үйлдвэрүүд цэцэглэж, Монгол Улс маань мандан бадрах ирээдүй ойрхон байна. Гол нь энэ эхлүүлсэн бодлогоо үргэлжлүүлж “Хүнсний хувьсгал”-ын дараагийн шатыг дор хаяж 15-30 жил тасралтгүй хэрэгжүүлэх ёстой гэдгийг эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийнхэн, ард түмэн хүсэж байна. Олон улсын туршлага ч харуулж байна. Ингэж байж бид хүнсний бүтээгдэхүүнээ 100 хувь дотоодоосоо хангах юм. Хамгийн чухал, хамгийн зөв хөтөлбөрийн эхлэл тавигдлаа. Цаашаа хүнсээ дотооддоо үйлдвэрлээд органик хүнс экспортолдог улс болон хөгжих сайхан ирээдүй харагдаж байна. ■



СУРВАЛЖИЛГА

“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” -ЫНХАН АМЖИЛТАА ДҮГНЭЛЭЭ

Дэлхийн хүнсний ажилчдын өдөр жил бүрийн арванхоёрдугаар сарын 12-нд тохиодог. Энэ өдөр “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийхөн 3.5 жилд хэрэгжүүлсэн ажлаа дүгнэж, амжилтаараа бахархсан үйл ажиллагаа болов. Уг арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Ерөнхий сайд Г.Занданшатар, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Ерөнхийлөгчийн зөвлөх Ч.Даваабаяр нарын холбогдох албаныхан оролцов. Энэхүү зөгсгэлэн арга хэмжээнд хүнсний 35, газар тариалангийн

12, мал аж ахуйн долоо нийт 54 аж ахуйн нэгж оролцож, Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа өргөжүүлж, бий болгосон 570 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүний дээжээ танилцууллаа.

“Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Атрын IV аян”, Цагаан алт” хөтөлбөрийн дүнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 44 мянган ажлын байр шинээр бий боллоо. Дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг хөнгөн, хүнсний салбар бүрдүүлж байгаа нь тогтвортой, кластер системийн суурь бэхжиж байгаагийн илрэл юм.

У.ХҮРЭЛСҮХ:
Монгол Улсын
Ерөнхийлөгч

Эх оронч худалдан авалт хийхийг уриалж байна



Миний сэтгэл их хангалуун байна. “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжих хугацаанд би 116 үндэсний үйлдвэр, аж ахуйн нэгжээр өөрийн биеэр очиж, үйл ажиллагаатай нь танилцсан. “Хүнсний

хувьсгал”-д нэгдэн, үйлдвэрлэлээ өргөжүүлж, олон мянган ажлын байр бий болгон, татвараа төлж байгаа аж ахуйн нэгж, баялаг бүтээгчдэд болон хамтран ажиллаж байгаа төр болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудад талархал илэрхийлж байна. “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн цаашид үргэлжилж, хүнс экспортлогч орон болох ёстой. Бага хүүтэй, эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийг үргэлжлүүлэн олгох ёстой. Энэ ажил урт хугацаанд явах ёстой юм. Төрөөс зөв бодлогоор дэмжээд өгвөл амжилтад хүрдэг юм байна гэдгийг бид харлаа. Үйлдвэрлэгчид, үндэсний компаниудаа төрийн бодлогоор хамгаалах хэрэгтэй. Ажлынхаа үр дүнг харж, хоорондоо уулзах үнэхээр сайхан байна. Ажил төрлөө ингэж дүгнэж ярилцаж байна.

Г.ЗАНДАНШАТАР:
Монгол Улсын
Ерөнхий сайд

Төр үйлдвэрлэгчдээ хамгаалах ёстой



Монгол Улсын Ерөнхийлөгч “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг санаачилж, Засгийн газраас улс орон даяар гурван жилийн хугацаанд хэрэгжүүлж, зарим бодит үр дүн гарлаа. Та бид хамтдаа чамлахааргүй амжилт, үр дүн гаргасан хэдий ч цаашид бүрэн үр дүнд хүрэхийн тулд дараах асуудлуудад төр, хувийн хэвшил хамтдаа хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал,

- Экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх,
- Бүс нутгийн хөгжлийн тэгш бус байдал, тээвэр логистикийн сул хөгжил,
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны чанар, ил тод байдал,
- ЖДҮ, хоршоодод очих санхүүжилтийн хүртээмж, шударга байдал,
- Хөрсний доройтол, үрийн чанар, малын эрүүл мэнд зэрэг асуудалд онцгой анхаарах ёстой.

Эдгээр нь хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангахад зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлууд юм. Монгол Улс хүнсээр зөвхөн өөрийгөө хангадаг улс биш, бүс нутгийн том экспортлогч болох бүрэн боломжтой. Тиймээс төр, хувийн хэвшил, иргэн бүрийн хамтын ажиллагаа урьд урьдынхаас илүү нягт, үр дүнтэй байх шаардлагатай.

Ж.ЭНХБАЯР:
Монгол Улсын
Тэргүүн Шадар
сайд бөгөөд
Эдийн засаг,
хөгжлийн сайд

Евразийн зах зээлд 367 төрлийн барааг татваргүй гаргана



Өнгөрсөн гурван жилийн хугацаанд дотооддоо үйлдвэрлэх боллоцоотой хүнсний нэр төрлийг гаргаж, үүнд чиглэсэн хөнгөлөлттэй зээл санхүүгийн бодлогуудыг хэрэгжүүлсэн. Үр дүн нь өнөөдөр сайн гарлаа. Цагаа олсон зөв бодлого хэрэгжсэн нь

тодорхой байна. Бид гурван жилийн хугацаанд стандартуудаа олон улсын хэмжээнд шинэчиллээ. Үйлдвэрүүдээ олон улсад өрсөлдөхүйц хэмжээнд зохион байгууллаа. Хүнсний үйлдвэрлэлд дутагдаж байсан сав баглаа боодлын кластер, үйлдвэрүүдийг цогцоор нь бий болголоо. Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг УИХ-аар соёрхон баталлаа. 200 орчим сая хүн амтай зах зээл дээр “Хүнсний хувьсгал”-ын үр дүнд бий болсон үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ гаргаж өрсөлдөх орон зай нээгдэнэ. 367 төрлийн барааг 15-50 хувийн татвартай байсныг тэглэх таатай нөхцөлөөр энэ зах зээлд нэвтрэх гэрээг хийсэн. Манай үйлдвэрүүд борлуулалтаа нэмэгдүүлэх томоохон өөрчлөлт орно гэдэг эерэг хүлээлттэй байна.

М.БАДАМСҮРЭН:
Хүнс, хөдөө аж
ахуй, хөнгөн
үйлдвэрийн
сайд

Экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого баримтална



Монгол Улсын Ерөнхийлөгч маш том манлайлал үзүүлж “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг санаачилсан. Ерөнхийлөгч өөрөө биечлэн өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн төслүүдийн хэрэгжилтийн явцын байдалтай танилцаж, тодорхой саналаа хэлж, үр дүнг нь нүдээр үзэж харлаа шүү дээ. Хөдөлгөөн өрнөөд 3.5 жил боллоо. Эрх зүйн баримт бичиг 70 хувьтай тавьсан зорилгодоо хүрсэн байна. Үйлдвэрүүд шинээр байгуулагдах үйл ажиллагаа 70-аас дээш хувьтай хэрэгжиж байна. Дүгнэж хэлбэл, тавьсан зорилгоо давуулан биелүүлээд байна. Энэ хөтөлбөрийг цаашаа

2050 он хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлж гэдгийг төрийн болон хувийн хэвшлийнхэн санал нэгтгэйгээр илэрхийлж байна.

Зах зээлийн эдийн засагтай улсад төр бизнес хийхгүй, харин бизнесийг дэмжих ёстой. Яаж дэмжих вэ гэхээр хөнгөлөлттэй зээл олгох юм. Мөн дэд бүтцээр дэмжих ёстой. Зам, эрчим хүч, үйлдвэр технологийн парк барих, хүний нөөцийг нэмэгдүүлэх, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн дэмжлэг, гааль тарифын дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах бодлого, газар олголтын дэмжлэгийг үзүүлэх ёстой. Энэ дотроос хамгийн чухал нь хөнгөлөлттэй зээл юм. 1.3 их наяд төгрөгийг хөнгөлөлттэй зээлийн хүрээнд олголоо. Харин аж ахуйн нэгж үүнээс давсан хэмжээний ажлын байрыг нэмэгдүүлж, улсад татвар төлнө. Цаашид газрын баялгаас олж байгаа орлогоос нөхөн сэргээгддэг хүнс, хөдөө аж ахуйн салбар руу шингээх тогтолцоог бүрдүүлэх, улсын төсвөөс хамаарахгүй, сайд, дарга хэн байхаас үл хамааран тогтолцоог нь бүрдүүлж өгөх хууль, эрх зүйн баримт бичгийг өргөн барихаар бэлдэж байна.

ИНФО

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд гарсан зарим бодит үр дүнг дурдъя

1000 гаруй шинэ хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл бий болж, үйлдвэрлэл бодитоор өслөө.

Тухайлбал, 2022-2025 онд хүнсний ногооны үйлдвэрлэл **40** хувиар, тэжээлийн үйлдвэрлэлийн хүчин чадал **42.4** хувиар тус тус нэмэгдэж, тариалангийн талбай **13** хувиар тэллээ. Үр дүнд нь улирлын шинжтэй импортын хамаарал бодитоор буурч, зарим төрлийн хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах түвшинд хүрлээ.



Суурь дэд бүтэц өргөжиж, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдлээ.

Мал төхөөрөх **10**
Мах боловсруулах **7**
Сүү, сүүн бүтээгдэхүүний **11**
Гурилан бүтээгдэхүүний **16**

Ургамлын гаралтай бүтээгдэхүүний **3**
Шингэн хүнсний бүтээгдэхүүний **3**
Давсны **1**
Сав баглаа боодлын **2**

нийт **53** шинэ үйлдвэр ашиглалтад орлоо.

Импорт буурч, валют эх оронд үлдэх эхлэл тавигдлаа.

2025 оны эхний 11 сарын байдлаар нийт импорт **379** сая ам.доллаароор буурлаа.

Тухайлбал, төмс, тахианы мах, улаанбуудай, сүү, цөцгий, тараг зэрэг стратегийн хүнсний бүтээгдэхүүний импорт буурч, жил бүр гадагшаа **100** орчим сая ам.доллар урсдаг байсан бол 2025 онд **21.3** сая ам.доллар эх орондоо үлдэв.



Хүнсний экспорт нэмэгдлээ.

2025 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар мах, махан бүтээгдэхүүний экспорт **76.4 мянган** тонн болж нэмэгдэж, хүнсний экспортын орлого **300 сая** ам.долларыг давлаа.

Хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдэдээ санхүүгийн бодит дэмжлэг үзүүлээ.

Арилжааны банкуудаар дамжуулан **5-6** хувийн хүүтэй, **3-5** жилийн хугацаатай, нийт **1.3** орчим их наяд төгрөгийн зээлийг **2522** орчим аж ахуйн нэгж, иргэнд олголоо. Уг нэн хөнгөлөлттэй зээл, санхүүжилтэд зориулж төсвөөс **200** орчим тэрбум төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна.



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнд хамрагдаж, үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлж, амжилттай ажиллаж буй зарим аж ахуйн нэгжээр орж бодит байдалтай танилцаж сурвалжилга мэдээлэл бэлтгэсэн билээ.

“ХАРУМАФҮЖИ СҮҮНИЙ ФЕРМ”

Д.Бямбадорж: Ард олондоо хайрлагдсан дотно амтыг түгээнэ



“Харумафүжи сүүний ферм”-ийн үүсгэн байгуулагч

Харумафүжи Д.Бямбадорж аварга “Шинэ Монгол Харумафүжи” сургуулиа байгуулсныхаа дараа сурагч хүүхдүүдэд үдийн цай хөтөлбөрт нь шинэ, эрүүл, амьд, органик сүү, сүүн бүтээгдэхүүнийг оруулах ёстойг ойлгожээ. Монгол хүүхдүүдийн чихрийн хэрэглээ хэт өндөр, харин эсрэгээрээ сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ бага шахуу өсөн торниж байгааг олж харсан хэрэг. Энэ л дүр зургийг өөрчлөхийг хүсэж 2021 оноос Японы “но-хау”-г судлан эх орондоо нутагшуулан сүүний фермтэй болохоор сэтгэл шулууджээ. Өнөөдөр энэхүү зорилго нь биелэлээ олж “Шинэ Монгол Харумафүжи” сургуулийн 2000 сурагчаас гадна ерөнхий боловсролын зургаан сургууль, гурван цэцэрлэгийг өглөө бүр аз жаргалтай, чанартай, шинэ сүүгээр хангаж байна. Одоогоор Харумафүжи ферм бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлээгүй бөгөөд цаашид саалийн үнээний тоог хоёр дахин нэмэгдүүлэхэд сүүгээр хангах

сургууль, цэцэрлэгийн тоо тэр хэрээр нэмэгдэх нь тодорхой.

Тус ферм нь Францын сүүний чиглэлийн Монбельярд үүлдрийн нийт 160 орчим үхэртэй. Өдөрт нэг үнээнээс дунджаар 14-22 литр сүү авч тараг, цөцгий, зайрмаг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна. Сүүгээ сүүлийн үеийн дэвшилтэд технологи, бүрэн автомат тоног төхөөрөмжөөр вакум орчинд боловсруулж, түүхий сүүний амт чанар, амин чухал зүйл болсон уургийг задлахгүйгээр температурын аргаар ариутган савладаг аж. Сүү саахаас эхлээд бүх процесс технологид суурилсан, агаарт урвалд орохгүй, шимт байдлыг нь алдагдуулахгүй үйлдвэрлэдэг байна.

Анх сүүний фермээ ашиглалтад оруулахад “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд олгогддог хөнгөлөлттэй зээл томоохон дэмжлэг болсонд талархалтай хандаж цаашид ч үргэлжлээсэй хэмээн хүсдэгээ Харумафүжи аварга манай сэтгүүлээр дамжуулан уламжилсан.

Аз жаргалтай үнээнээс аз жаргалтай сүү гардаг гэнэ. Тийм ч учраас Харумафүжи сүүний

фермийн үнээнүүд дэлхийд алдартай сонгодог хөгжим эсвэл Монгол Улсын Ардын Жүжигчин Н.Жанцанноров гуайн зохиосон аяыг сонсож өвс, тэжээлээ идэн, тав тухтай дулахан, агааржуулалт сайтай орчинд сүү үйлдвэрлэж байна. Тус фермийнхэн “Эх орны хөрсөнд дэлхийн жишигт нийцсэн сүүний фермийн үйл ажиллагааг төгөлдөржүүлж ард түмэндээ эрүүл, аюулгүй, амьд ариун сүү, сүүн бүтээгдэхүүнийг уламжлуулан түгээнэ” гэсэн эрхэм зорилготой. Энэ бол зүгээр ч нэг зорилго биш. Үг бүр нь амьтай, гүн утга агуулгатай гэдгийг Харумафүжи аварга хэлж байлаа. Тус фермийн бас нэгэн гол чухал зүйл нь хэрэглэсэн усаа дахин боловсруулж ашигладаг. Харумафүжи аварга “Хүн гэдэг байгалийн амьтан. Тийм ч учраас байгаль, эх дэлхийтэй шүтэлцээтэй оршдог. Бид газар тариалан, уул уурхай, хөдөө аж ахуйн чиглэлээр бизнес эрхэлж болох ч байгаль орчноо бохирдуулж болохгүй гэдгийг үргэлжилж санаж, ажил хэрэг болгох хэрэгтэй” гэдгийг онцгойлон захисан билээ. ■



“ӨГӨӨМЖ АРХАД” ХХК

Н.Энхжаргал: Жижиг, дундын салбарыг дэмжиж байгаад баяртай байна



“Өгөөмж Архад” компанийн гүйцэтгэх захирал

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх өнгөрсөн арваннэгдүгээр сард “Өгөөмж Архад” талх нарийн боовны үйлдвэрээр зочлоход Ерөнхийлөгчийн багт орж явах завшаан тохиосон юм. Үйлдвэрийн хаалгаар ороход шинэхэн талх, нарийн боовны үнэр хамар цоргиж байв. Тус үйлдвэр “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд зээл авч үйлдвэрлэлээ хоёр дахин өргөжүүлжээ. Тодруулбал, хоёр тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авч, үйлдвэрийн байр, агуулахаа өргөтгөж, дотоодын лаборатори, цэвэрлэх байгууламжаа ашиглалтад оруулсан байна. Ингэснээр хүчин чадлаа 2.4 дахин, борлуулалтын орлогоо хоёр дахин нэмж, бүтээгдэхүүний нэр, төрлөө олшруулан, шинээр ажлын байр бий болгосон талаараа “Өгөөмж Архад” компанийн гүйцэтгэх захирал Н.Энхжаргал танилцуулсан юм. Тус үйлдвэр Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 1800 гаруй аж ахуйн нэгжтэй хамтран ажилладаг. Хэдхэн жилийн өмнө жижиг аж ахуйн нэгж байсан “Өгөөмж Архад”

компани өнөөдөр дунд аж ахуйн нэгжийн эгнээнд шилжжээ.

“Өгөөмж Архад” компани одоо 30 гаруй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. 170 ажилтантай. Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO45001:2018, Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO14001:2015, Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг хянах тогтолцоо HACCP хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн дотоод лабораторитой болж ашиглалтад орсон бөгөөд ISO/IEC 17025:2017 Сорилтын болон шалгалт тохируулгын, лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага хангуулахаар зорин ажиллаж байгаа юм байна. Мөн тогтвортой хөгжлийн хүрээнд олон ажлыг өрнүүлжээ.

Төр зөв бодлогоор дэмжээд, санхүүжилт нь үнэн, шударга байхын зэрэгцээ бизнесээ зөв удирдаж, төсөл хэрэгжүүлэхэд маш богино хугацаанд жижиг үйлдвэрлэлээс дунд бизнес рүү асар хурдтай шилжиж чаддаг гэдгийг “Өгөөмж Архад” компани харуулж байна.

“Өгөөмж Архад” компанийн ирээдүйн зорилго импортын



барааг орлосон бүтээгдэхүүнийг Монголдоо үйлдвэрлэж, өргөн хүрээнд зах зээлд нэвтрэхийг нэн тэргүүнд зорьж байгаа гэнэ. Бүр цаашдаа экспортод бүтээгдэхүүнээ гарахын тулд олон улсын шаардлага хангасан үйлдвэрийн бааз суурийг маш сайн бэлдэж байгаа гэдгийг Н.Энхжаргал захирал онцолсон юм. Мөн тэрбээр “Цехээс үйлдвэрлэлийн түвшинд шилжих үед олон улсын стандартыг тогтоож сахиулах нь үнэхээр амар биш байсан. Хүн процесс хоёрыг өөрчлөх хүнд байлаа. Үүнийг үнэхээр зоригтойгоор мэдлэг ур чадвараа тасралтгүй сайжруулснаар өнөөдрийн түвшинд хүрсэн байна. Хамт олны маань үнэнч хандлага, ур чадварынх нь өсөлт бас нөлөө үзүүлсэн. Жижиг бизнест стандартыг тогтоож, түүнийг сахиулах гэдэг амар биш юм билээ. Ер нь бизнес хийж амжилтад хүрэхийн тулд худлаа ярьдаггүй хүн хамгийн чухал. Бусдад юу өгч байгаагаа ойлгосон хүн хамгийн чухал. Итгэл даадаг хүмүүс бизнест амжилт үзүүлдэг юм байна гэдгийг олон жилийн туршлагаасаа харж байна. Хариуцлагаа ухамсарлахгүйгээр хүн цаашаа алхаж чадахгүй. “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд 20 жил зүтгээд чадаагүй бүтээн байгуулалтаа хоёрхон жилийн дотор бид босгож чадлаа” хэмээв. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Өгөөмж Архад” компаниар зочлохдоо “Хүнсний хувьсгал”-д нэгдэн үйлдвэрлэлээ өргөтгөж, ажлын байр бий болгон, татвараа төлж, шударга тууштай ажиллаж байгаад нь талархал илэрхийлж байлаа. ■

“ОЧИРДАГИНАС” ХХК

Х.Тэмүүжин: Дэлхийн махны олимпоос есөн алт, нэг хүрэлтэй ирсэн



“Очирдагинас” компанийн гүйцэтгэх захирал

Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Очирдагинас” компани 2022 онд нэг үйлдвэртэй байсан бол “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний үр дүнд хоёр шинэ үйлдвэр ашиглалтад оруулж, нийт гурван үйлдвэрээс бүрдсэн экспортын цогцолбор үйлдвэрээ байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүлжээ.

Тус компани “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд арилжааны банкны хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, нөөшилсөн бүтээгдэхүүн болон анхан шатны мах боловсруулах үйлдвэрээ ашиглалтад оруулаад байгаа юм. Улмаар үйлдвэрлэлийн хүчин чадлаа хоёр, хөргөлттэй зоорины багтаамжаа хоёр, үйлдвэрийн талбайгаа гурав дахин нэмэгдүүлжээ. Экспортын үйлдвэрт нь 70 гаруй нэр төрлийн чанамал, хагас утлагат, давхар утлагат хиа, элэгний нухаш, зайдас, утсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа юм. 2018 оноос гэрийн тэжээвэр

амьтанд зориулсан хоёр төрлийн бүтээгдэхүүнээ Солонгосын зах зээлд нийлүүлж байсан бол өдгөө 20 төрөл болгож нэмэгдүүлжээ.

Мөн “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд тоног төхөөрөмжийн гаалийн татварын хөнгөлөлтөд хамрагдаж, 2024 оны хөнгөлөлт болох 44.7 сая төгрөгийн буцаан олголтыг 2025 онд авсан бол 2026 онд 133 сая төгрөгийн буцаан олголтыг авахаар болжээ.

“Очирдагинас” компанийн гүйцэтгэх захирал Х.Тэмүүжин “Энэ жил манай компанийн 20 жилийн ой болж байна. Үйл ажиллагаа амжилттай сайхан явж байна. 2017 оноос экспортын үйлдвэрлэлийн төслөө хэрэгжүүлсэн. Үйлдвэрлэл олон улсын стандарттай байх ёстой гэдэг зорилго тавьж, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ 2018 онд ашиглалтад оруулсан. Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд явуулсан бодлого нүдээ олсон ажил гэж боддог. Манай улс хүнс

үйлдвэрлэгч орон байх зорилго тавьсан. Энэ зорилго биеллээ олж байгаа гэж хэлмээр байна. Манайх нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэр дээрээ гурван тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан. Анхан шатны мах боловсруулах үйлдвэрийнхээ тоног төхөөрөмж сайжруулах зорилгоор 4.8 тэрбум төгрөгийн зээл авсан. Бусад санхүүжилтийг өөрсдөө хийсэн.

Бид гурван жилд нэг удаа зохион байгуулагддаг, дэлхийн хамгийн том мах, махан бүтээгдэхүүний IFFA үзэсгэлэнд оролцсон. 2025 оны тавдугаар сарын 3-8-ны хооронд Германы Франкфурт хотод болсон уг үзэсгэлэнд арван бүтээгдэхүүнээ авч яваад есөн алт, нэг хүрэл медальтай ирсэн. Энд дэлхийн хэмжээний мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниуд ордог. Монголын мах, махан бүтээгдэхүүн дэлхийд зөвшөөрөгдсөн гэдгийг бид баталсан” хэмээн ярилаа. ■



IFFA үзэсгэлэнд оролцож, 9 алт, 1 хүрэл авав

“ВИТАФИТ ИНВЕСТ” ХХК

Ч.Ванчин-Эрдэнэ: “Хүнсний хувьсгал” дотоодын үйлдвэрлэгчдэд том дэмжлэг боллоо



“Витафит Инвест” ХХК-ийн Орлогч захирал

Монголын шингэн хүнсний зах зээлд 26 жилийн турш үнэтэй хувь нэмрээ оруулж буй “Витафит” компанийн ундаа, жүүс, сүүн бүтээгдэхүүний үйлдвэртэй танилцахаар нэгэн жавартай өглөө Витафит үйлдвэрийг зорилго. Үйлдвэрийн хашаагаар оруут ажил ид өрнөж, зогсоо зайгүй ажиллаж, сэрээт өргөгчөөр бараа өргөн зөөж, зарим нь лууван, жимсний шүүсний савнуудыг ачиж харагдана. “Витафит Инвест” ХХК-ийн Орлогч захирал Ч.Ванчин-Эрдэнэтэй уулзсанаар үйлдвэртэй танилцах аялал маань эхэлсэн юм. Витафит группийн нэгдсэн лаборатори нь бүтээгдэхүүн бүрээс дээж авч, эрүүл мэндэд аюулгүй, чанарын шалгуурыг давсан эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гарт хүргэдэг өндөр стандарттай. HF-28 үйлдвэр. Энд бүх үйл явц автоматаар уран нарийн хийгдэх бөгөөд Германы “Krones” брэндийн халуун савлагааны систем нь үйлдвэрийн үнэт цагийг хэмнэнэ. Цагт 18 мянган бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

Ч.Ванчин-Эрдэнэ захирал үйлдвэрээ танилцуулж явахдаа нэгэн “нууц өрөө”-г нээсэн нь жижгэрүүлсэн үйлдвэр буюу шинэ бүтээгдэхүүн мэндэлдэг туршилтын лаборатори байлаа. Тэрбээр “Бид шинэ санааг шууд үйлдвэрлэдэггүй. Эхлээд жижиг хэмжээнд туршиж, төгс болтол нь боловсруулна. Ингэж шинэ амтыг бүтээдэг” гэсэн юм.

Аялал лууван боловсруулах үйлдвэрт үргэлжиллээ. “Витафит Инвест” компани нь Монгол хөрсөнд ургасан луувангаар импортын бүтээгдэхүүнийг орлох ухаалаг санаачилга гарган “Монгол лууван” төслийг амжилттай хэрэгжүүлж буй. Голландын “NAVAL F1” сортын шүүслэг лууванг эх орондоо нутагшуулж, Сэлэнгэ аймгийн Хушаат суманд “GAP” чанарын стандартаар тариалж, өөрийн үйлдвэрт боловсруулан, эрүүл органик “Монгол лууван” брэндээр дотоодын зах зээлээ хангаж “газраас гарт” хүргэж байна. Тус компани “Хүнсний хангамж, аюулгүй байдал” хөдөлгөөнд оролцож, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр үйлдвэрээ

бүрэн шинэчилжээ. Италийн “Vometa”, Нидерландын “Allround” брэндээр үйлдвэрээ тоноглож, хүчин чадлаа дөрөв дахин өсгөснөөр 2025 онд 3500 орчим тонн лууван боловсруулж А амин дэм үйлдвэрлэж буй.

Ч.Ванчин-Эрдэнэ захирал “Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хувьсгал” дотоодын үйлдвэрлэгчдэд маш том дэмжлэг болсон. Хөнгөлөлттэй зээлийг цааш үргэлжлүүлбэл олон компани зах зээлээ тэлэх, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх боломжтой болно” хэмээн онцолсон. Тэрбээр үйлдвэрээ танилцуулсны дараа “Зүрх мартаггүй” төслийн багтай уулзах тухайгаа хуучилсан юм. Учир нь “Монгол лууван” брэндийн нэгж худалдан авалт бүр бяцхан хүүхдүүдэд амьдрал бэлэглэж, өнөөдрийн байдлаар 220 гаруй сая гаруй төгрөг хуримтлагдан 25 орчим хүүхдийн зүрхийг эрүүл цохилуулжээ. Энэ бол хүнсний салбарт шинэ хандлага төдийгүй бахархам дэвшил юм. ■



Ж.Болд: Дотоодын өндөгний хэрэгцээг 100 хувь хангана



“Түмэн шувуут” ХК-ийн гүйцэтгэх захирал

Өндөг бол дэлхий дээрх бүхий л идэж болох зүйлсээс уураг, амин дэмээр хамгийн баялаг хэмээн хоол зүйчид тодорхойлдог. Тэгвэл энэхүү хүний биед ач тустай, бидний өдөр тутмын хэрэглээ болсон өндөгний хүнсний аюулгүй байдлын технологийн шийдэл, үйл ажиллагаатай нь танилцахаар хотоос холгүйхэн байрлах “Түмэн шувуут” компанийн шувууны аж ахуйн фермийг зорилоо. Мөн тэдний малын тэжээлийн “Агро фийд” үйлдвэрээр орж, шувуу болон малын тэжээлийн үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний төрөл, автоматчилагдсан технологийн шийдэл, бүтээн байгуулалттай бүрэн танилцсан юм.

“Өндөглөгч тахианы аж ахуй-2” нь тахианы найм, дэгдээхэйн хоёр, нийлээд 10 байртай, 400 мянган шувуу өдөрт 200-250 мянга орчим жилд 85 сая ширхэг өндөг гаргаж байна. Өндөглөгч тахианы байрнаас өндөгнүүд автомат шугамаар урсан нэг цэгт бөөгнөрдөг. Цугласан өндгийг мөн л хүний оролцоогүй автоматаар савладаг, хэт том болон шувууны

сангасаар бохирдсон өндгийг ялгах ажлыг л хүний оролцоотой хийдэг аж. Тэр ч бүү хэл сангас зайлуулах, тахианы ус, хоол тэжээл өгөх процесс, гарсан өндгийг хураах гээд бүх ажиллагаа бүрэн автомат болжээ. Өндөглөгч тахианы байр тогтмол 18-20 хэмийн дулаан байх ёстой. Тахианы байр болгон ухаалаг системтэй учраас дулаан болон агааржуулалтыг нэг түвшинд барьж чаддаг байна. Тахиа яг л хүүхэд шиг арчилгаа их шаарддаг, эмзэг мэдрэмтгий амьтан, тиймээс шувуу маллагааны олон улсын стандартыг ч нэвтрүүлсэн гэдгийг “Өндөглөгч тахианы-2” фермийн дарга Д.Баянмөнх хэлсэн юм.

“Өндөглөгч тахианы аж ахуй-3” фермийг барих ажил өнгөрсөн оны таван сард эхэлж байсан бол өнөөдөр барилгын ажил 100 хувь дуусжээ. Шувууны 10 байртай бөгөөд одоогоор дөрвөн нь үйлдвэрлэл явуулж байна. Байр тус бүр 50 мянган өндөглөгч тахиатай. Өдөрт нийт 180 мянга гаруй өндөг үйлдвэрлэж байна.

2004 онд байгуулагдсан “Түмэн шувуут” ХК нь өдгөө 17 нэр төрлийн

савлагаатай өндөг, 10 нэр төрлийн мал, амьтны тэжээл болон шувууны сангасыг боловсруулж органик бордоо үйлдвэрлэж байна. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгосон урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамрагдан шувууны аж ахуйн үйлдвэрлэл, хүчин чадал, техник технологийн дэвшилд ахиц гарч, үйлдвэрлэл үйл ажиллагаагаа олон улсын стандартад хүргэжээ. Мөн “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэн 2023 оноос хойш зах зээлд худалдаалж буй дотоодын өндөгний үнээ нэг ч удаа нэмээгүй байна. Тус компанийн Гүйцэтгэх захирал Ж.Болд “Ирэх хоёр жилд дотоодын өндөгний аж ахуй нийтдээ гурван сая тоо толгой шувуутай болж, жилд дунджаар 650 сая ширхэг өндөг үйлдвэрлэх бөгөөд дотоодын өндөгний хэрэгцээг 100 хувь хангана” гэдгээ хэлсэн юм. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд “Түмэн шувуут” ХК нь нэг тэрбум өндөг үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлжээ. ■





Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн ХҮРЭЛСҮХ:

**ҮНДСНИЙ
ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ
ДЭМЖИЖ,
ЭХ ОРОНЧ
ХУДАЛДАН АВАЛТ
ХИЙЦГЭЭЕ!**

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний
хэрэгжилтийн үр дүн, үзэсгэлэнгийн арга хэмжээ 2025.12.12